



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ 2024

WHITE PAPER ON CRIME

Улаанбаатар хот
2025 он

ЗАХИАЛАГЧ



ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ГҮЙЦЭТГЭГЧ



ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛЬ

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ЗӨВЛӨЛ



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН ГАЗАР



АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР



ЦАГДААГИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР



ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ
ГАЗАР



ШҮҮХ
ШИНЖИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗАР



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ БАГ

Зөвлөх

Л.Нямгэрэл

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах
зөвлөлийн Ажлын албаны дарга, хууль зүйн доктор

О.Зоригт

Дотоод хэргийн их сургуулийн захирал,
хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

Судалгааны багийн ахлагч

С.Гантулга

Дотоод хэргийн их сургуулийн Дэд бөгөөд Эрдэм шинжилгээ,
инновацийн газрын захирал, хууль зүйн доктор, дэд профессор,
цагдаагийн хурандаа

Судалгааны багийн гишүүд

Б.Одмандах, Г.Амаржаргал (ГХУСАЗЗАА),
Д.Энхтөр (Хууль зүйн доктор), Л.Мөнх-Оргил, В.Номинчулуун, Ч.Цэнд-Аюуш, Т.Анхбаяр (ДХИС),
Н.Алтантүлхүүр, Б.Оч, Т.Энхгэрэл (ШЕЗ),
Б.Мөнхдорж (Хууль зүйн доктор, дэд профессор), З.Сансарзолбоо, А.Нямсүрэн (УЕПГ),
Л.Түвшинбат, А.Мөнхтамир (АТГ),
Д.Жанчивдорж, А.Манлай (Хууль зүйн доктор), С.Энхбаатар (ЦЕГ),
Д.Намгэрэл (ШШГЕГ),
Ц.Мөнхбат, Д.Орхонсэлэнгэ, Т.Раднаасүмбэрэл (ШШЕГ),
Х.Буянбат (ХЗҮХ)

Эх бэлтгэсэн

Л.Одхүү, Б.Тулга (ДХИС)

АГУУЛГА

БОСГО ҮГ	4
ӨМНӨХ ҮГ	5
ТОВЧИЛСОН ҮГ	6
ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	7

I. ЦАГДАА - POLICE

1. Товч танилцуулга	22
2. Гомдол, мэдээлэл	22
3. Гэмт хэрэг	24
4. Мөрдөн шалгах ажиллагаа	40
5. Зөрчил шалган шийдвэрлэлт	43
6. Замын хөдөлгөөний аюулгүй байдал	46
7. Эрүүлжүүлэгдсэн хүн	77
8. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил	77

II. ПРОКУРОР - PROSECUTION

1. Товч танилцуулга	90
2. Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавьсан хяналт	93
3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавьсан хяналт	99
4. Шүүхэд төрийг төлөөлөх ажил	107
5. Ял эдлүүлэх ажиллагаанд тавьсан хяналт	114
6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил	118
7. Прокурорын байгууллагаас авч хэрэгжүүлсэн зарим ажил, арга хэмжээ	120

III. ШҮҮХ – COURT

1. Товч танилцуулга	127
2. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт	131
3. Зөрчлийн шийдвэрлэлт	144

IV. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

ГҮЙЦЭТГЭЛ – CORRECTION

1. Товч танилцуулга	151
2. Хорих ялын гүйцэтгэл	152
3. Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл	155
4. Баривчлах шийтгэлийн гүйцэтгэл	166
5. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл	167

V. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР - ANTI-CORRUPTION AGENCY

1. Товч танилцуулга	171
2. Гомдол, мэдээлэл	172
3. Мөрдөн шалгах ажиллагаа	173
4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хохирол нөхөн төлүүлэлт	176
5. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил	175
6. Монгол Улсын авлигын индекс, түүний үр дүн	178
7. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил	179

VI. ШҮҮХ ШИНЖИЛГЭЭ – FORENSIC

1. Товч танилцуулга	187
2. Шинжилгээний тоон мэдээ	188
3. Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал	195
4. Сан баяжуулалт, ашиглалтын статистик	198
5. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил	199

VII. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIMINAL DAMAGE

1. Цагдаагийн байгууллагын статистик	203
2. Авлигатай тэмцэх байгууллагын статистик	206
3. Прокурорын байгууллагын статистик	207
4. Шүүхийн статистик	208
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистик	209

VIII. ХҮҮХЭД ХОХИРСОН БОЛОН ХҮҮХДИЙН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ- CHILD VICTIM OFFENSE, JUVENILE DELINQUENCY

214

IX. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ - PREVENTIVE MAINTENANCE

230

ЭХ СУРВАЛЖ

244

ХАВСРАЛТ

246

БОСГО ҮГ

Гэмт хэргийн төлөв байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан тодорхойлж, төрийн бодлого боловсруулах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг үнэлэхэд чухал гарын авлага болсон “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном”-ыг бид 2016 оноос эхлэн уламжлал болгон эрхлэн гаргаж ирлээ.

Энэхүү бүтээл нь жилээс жилд улам боловсронгуй болж, зөвхөн гэмт хэрэг, зөрчлийн статистик тоо мэдээллийг нэгтгэн харуулах төдий бус, харин түүнд тулгуурласан дүн шинжилгээ, бодлогын санал, зөвлөмжийг багтаадгаараа онцлогтой судалгааны цогц бүтээл болон төлөвшжээ.

Энэ жилийн “Гэмт хэргийн цагаан ном” нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн түүхт 60 жилийн ойгоор олны хүртээл болж байна.

“Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2024”-д хүүхэд хохирсон, хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг тусгайлан авч үзэж, энэ төрлийн гэмт явдлын шалтгаан нөхцөл, нийгмийн сөрөг үр дагаврыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарласан нь төрийн бодлого боловсруулагчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудын судалгааны эх сурвалж болно гэдэгт итгэлтэй байна.

Хүүхдийг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх нь зөвхөн хууль сахиулах байгууллагын бус бүх нийтийн өмнө тулгамдсан асуудал хэвээр байсаар байна.

Энэхүү бүтээлийг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн багш, судлаачид болон хамтран ажилласан хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон статистикийн байгууллагуудын удирдлага, албан хаагчдад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хууль дээдлэх зарчим батжиж, амгалан тайван нийгмийг цогцлоох үйл хэрэг улам өргөжин дэлгэрэх болтугай.

Хүндэтгэсэн:

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА, ХУУЛЬ
ЗҮЙН ДОКТОР (Ph.D) Л.НЯМГЭРЭЛ

ӨМНӨХ ҮГ

Дотоод хэргийн их сургууль нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх, практик байгууллагын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорьж ажилладаг билээ. Энэ ч утгаараа манай Их сургуулийн эрдмийн хамт олон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн захиалгаар “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном” бүтээлийг тав дахь жилдээ хариуцан боловсруулж, та бүхэнд өргөн барьж байна.

Гэмт хэргийн цагаан ном нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого боловсруулах, Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах чухал эх сурвалж болохын зэрэгцээ, криминологийн шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, олон нийтэд гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын цогц мэдээлэл өгөхөд ихээхэн үүрэг гүйцэтгэж байна.

Энэхүү бүтээл нь агуулга, судалгааны арга зүйн хувьд жил ирэх тусам боловсронгуй болж, тухайн жилийн гэмт хэргийн нөхцөл байдал, онцлогийг багтааж ирсэн. Энэ удаагийн цагаан ном нь хүүхэд хохирсон болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг онцгойлон авч үзэж, дүн шинжилгээ хийснээрээ онцлог болсон.

Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг нь зөвхөн Монгол Улсад бус, дэлхий дахинд хүний эрхийн салбарын тулгамдсан асуудлын нэгт тооцогддог бөгөөд тухайн улсын тогтвортой хөгжилд ноцтой эрсдэл учруулдаг нийгмийн сөрөг үзэгдлийн нэг юм. Иймд энэхүү асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг, хариуцлага нэн чухал билээ.

Энэхүү бүтээлийг боловсруулахад хамтран ажилласан Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн удирдлага, алба хаагч болон Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн, судлаачдад талархал илэрхийлье.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

Хүндэтгэсэн:

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ,
ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА О.ЗОРИГТ

ТОВЧИЛСОН ҮГ

АТГ	Авлигатай тэмцэх газар
БГХ	Бүртгэсэн гэмт хэрэг
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ДЦШ	Дотоодын цэргийн штаб
ЗЦГ	Замын цагдаагийн газар
ИАТЦХ	Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс
МХХ	Монголын хуульчдын холбоо
МША	Мөрдөн шалгах ажиллагаа
НААСЭГХ	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
НТАХЯ	Нийтэд тустай ажил хийлгэх ял
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЦУГ	Нийслэлийн цагдаагийн удирдах газар
ОНАБАСЭГХ	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТЗЦГ	Төмөр замын цагдаагийн газар
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ХАБТХАЖЭГХ	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
ХБООЭГХ	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
ХБМБ	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт
ХБЭЧХБЭГХ	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХТАБЭТЭГХ	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг
ХХУТЭЭЧЭГХ	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
ХХЧБЭЭГХ	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
ХЭМХБЭГХ	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХТТГ	Хар тамхитай тэмцэх газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШЕГ	Шүүх шинжилгээний ерөнхий газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

ЦАГДАА-POLICE

Хүснэгт

Хүснэгт №1. Цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээллийг бүртгэсэн нэгжээр нь

Хүснэгт №2. 2024 онд хэргийн шийдвэрлэлт хамгийн бага нэгжүүд

Хүснэгт №3. Түдгэлзүүлсэн хэргийн үндэслэл

Хүснэгт №4. Түдгэлзүүлснээс сэргээсэн хэргийн шийдвэрлэлт

Хүснэгт №5. Зөрчлийн шийдвэрлэлт

Хүснэгт №6. Зам тээврийн ослын шинжтэй дуудлага

Хүснэгт №7. Нийслэлд ирүүлсэн зам тээврийн ослын шинжтэй дуудлага

Хүснэгт №8. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол

Хүснэгт №9. Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт

Хүснэгт №10. Орон нутагт бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт

Хүснэгт №11. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт

Хүснэгт №12. Бүртгэгдсэн зам тээврийн ослын хэлбэр

Хүснэгт №13. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт

Хүснэгт №14. Бүртгэгдсэн зам тээврийн осол гарсан, учирсан хохирол сараар

Хүснэгт №15. Зам тээврийн осол бүртгэгдсэн гараг

Хүснэгт №16. Зам тээврийн осол бүртгэгдсэн цаг хугацаа

Хүснэгт №17. Зам тээврийн осол гарсан зам, орчин, цаг агаарын байдал

Хүснэгт №18. Зам тээврийн осол гарсан зам, орчин, цаг агаарын байдал

Хүснэгт №19. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

Хүснэгт №20. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

Хүснэгт №21. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

Хүснэгт №22. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

Хүснэгт №23. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

Хүснэгт №24. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

Хүснэгт №25. Бүртгэгдсэн гэмт хэрэг харьцуулалт

Хүснэгт №26. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхцөл байдал

Хүснэгт №27. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн насны байдал

Хүснэгт №28. Гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдал

Хүснэгт №29. Гэмт хэрэгт холбогдсон хүний боловсролын байдал

Хүснэгт №30. Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

Хүснэгт №31. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Хүснэгт №32. Зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон тохиолдол

Хүснэгт №33. Гэмтсэн хүний тоон үзүүлэлт

Хүснэгт №34. Зам тээврийн ослын улмаас гэмтсэн тохиолдол аймаг, дүүрэг

Хүснэгт №35. Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын нөхцөл байдал

Хүснэгт №36. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас учирсан хохирол

Хүснэгт №37. Замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

Хүснэгт №38. Согтуугаар үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, тоон үзүүлэлт

Хүснэгт №39. Нийт илрүүлсэн согтуугийн зөрчил

Хүснэгт №40. Зөрчилд авсан захиргааны арга хэмжээ

Хүснэгт №41. Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Хүснэгт №42. Хүүхэд өртсөн зам тээврийн ослын гэмтэл бэртэл

Хүснэгт №43. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн нас

Хүснэгт №44. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

Хүснэгт №45. Зам тээврийн ослын шалтгаан

Хүснэгт №46. Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Хүснэгт №47. Явган зорчигч ба дугуйтай хүний буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Хүснэгт №48. Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол

Хүснэгт №49. Зам тээврийн ослын хэлбэрийн тоон үзүүлэлт

Хүснэгт №50. Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол

График

График №1. Сүүлийн 20 жилд бүртгэсэн гэмт хэрэг

График №2. Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл

График №3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн төрөл

График №4. Шалгасан хэрэг

График №5. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

График №6. Ажиллагаанд шалгагдаж буй үлдэгдэл хэргийн тоо

График №7. Хохирол нөхөн төлүүлэлт /сая.төгрөгөөр/

График №8. Түдгэлзүүлсэн хэргийн төрөл

График №9. Түдгэлзүүлсэн хэргийн төрөл

График №10. Үлдэгдэл түдгэлзүүлсэн эрүүгийн хэргийн ангилал

График №11. Бүртгэгдсэн зөрчлийн ангилал

График №12. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын хэлбэрийн харьцуулалт

График №13. Зам тээврийн осол бүртгэгдсэн гараг

График №14. Хүний амь нас хохирсон зам тээврийн осол бүртгэгдсэн цаг хугацаа

График №15. Бүртгэгдсэн гэмт хэрэг харьцуулалт

График №16. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг харьцуулалт

График №17. Гэмт хэрэгт холбогдогчийн хүйс

График №18. Нас барсан хүний тоон үзүүлэлт

График №19. Гэмтсэн хүний тоон үзүүлэлт (бүс нутгаар)

График №20. Гэмт хэрэгт өртөн гэмтэж хохирсон хүмүүсийн хүйс

График №21. Гэмт хэрэгт өртөн амь нас хохирсон хүмүүсийн хүйс

График №22. Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний гэмтлийн зэрэг

График №23. Согтуугаар үйлдэгдсэн ослын нөхцөл байдал

График №24. Согтуугаар үйлдэгдсэн ослын нөхцөл байдал

График №25. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон байдал

График №26. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон байдал

График №27. Замын үйлдэгдсэн, хүний амь нас хохирсон ослын хэлбэр

График №28. Ослын тоо жил, сараар

График №29. Согтуугаар үйлдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон тохиолдол

График №30. Согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил (нийслэлд)

График №31. Согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил (орон нутагт)

График №32. Хүүхэд өртсөн зам тээврийн осол (нийслэлд)

График №33. Хүүхэд өртсөн зам тээврийн осол (орон нутагт)

График №34. Осолд өртсөн хэлбэр

График №35. Явган болон дугуйтай хүнээс шалтгаалсан зам тээврийн осол

График №36. Явган болон дугуйтай хүнээс шалтгаалсан зам тээврийн осол

Зураг

Зураг №1. Зам тээврийн осолд өртөж хохирсон хүмүүсийн насны байдал

Зураг №2. Ослын улмаас хохирогчийн биед учирсан гэмтлийн байдал

Зураг №3. Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон мэдээлэл

ПРОКУРОР-PROSECUTION

Хүснэгт

Хүснэгт №1. Улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хяналт тавьсан гомдол, мэдээлэл, хэрэг

Хүснэгт №2. Орон нутгийн прокурорын газрын хяналт тавьсан гомдол, мэдээлэл, хэрэг

Хүснэгт №3. Мөрдөн байцаалт явуулсан хэргийг төрлөөр нь харуулбал

Хүснэгт №4. Нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газраас хяналт тавьсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг

Хүснэгт №5. Орон нутгийн прокурорын газраас хяналт тавьсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг

Хүснэгт №6. Өсөлт, бууралтыг харуулбал

Хүснэгт №7. Прокурорын дүгнэлт

График

- График №1. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт
- График №2. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан хэргийн шийдвэрлэлт
- График №3. Оногдуулсан шийтгэлийг 2023 онтой харьцуулан харуулбал
- График №4. Прокурорын зөвшөөрөл олгосон байдал
- График №5. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хянаад бичсэн дүгнэлт
- График №6. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт
- График №7. Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт
- График №8. Яллах дүгнэлт үйлдсэн хэрэг
- График №9. Хяналтын ажлын явцад авсан арга хэмжээ
- График №10. Шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг
- График №11. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг
- График №12. Прокурор гэм буруугийн шүүх хуралдаанд оролцсон байдал
- График №13. Прокурор эрүүгийн хариуцлагын шүүх хуралдаанд оролцсон байдал
- График №14. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг
- График №15. Шүүхээр хэлэлцэгдсэн эсэргүүцэл
- График №16. Зөрчил хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцсон байдал
- График №17. Зөрчил хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцсон байдал
- График №18. Ял эдлүүлэх ажиллагаатай танилцсан байдал
- График №19. Ял эдлүүлэх ажиллагааг шалгасан байдал
- График №20. Хорих ял эдэлсэн хоригдлын тоо
- График №21. Хорихоос өөр төрлийн ял эдэлсэн ялтны тоо
- График №22. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бичсэн мэдэгдэл
- График №23. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн шалгалт
- График №24. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн судалгаа

Зураг

- Зураг №1. Прокурорын байгууллагын тогтолцоо
- Зураг №2. Улсын Ерөнхий Прокурорын газрын бүтэц, зохион байгуулалт
- Зураг №3. Гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан байгууллагаар нь харуулбал
- Зураг №4. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан байгууллагаар нь харуулбал
- Зураг №5. Зөрчлийн хэргийн төрлийг зүйлчлэлээр нь харуулбал
- Зураг №6. Гомдол, мэдээллийн хүлээн авч шалгасан байгууллагаар нь харуулбал
- Зураг №7. Хэрэг бүртгэлт явуулсан байгууллага тус бүрээр харуулбал
- Зураг №8. Хэрэг бүртгэлт явуулсан хэргийг төрлөөр нь ангилж үзвэл

Зураг №9. Мөрдөн байцаалт явуулсан байгууллага тус бүрээр нь харуулбал

Зураг №10. Хорихоос өөр төрлийн бусад ялын биелэлтийг төрөл тус бүрээр нь харуулбал

ШҮҮХ-COURT

Хүснэгт

Хүснэгт №1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

Хүснэгт №2. Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

Хүснэгт №3. Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

Хүснэгт №4. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо

Хүснэгт №5. Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг

Хүснэгт №6. Шүүхээс оногдуулсан ял, хариуцлагын төрөл

Хүснэгт №7. Баривчлагдсан сэжигтний тоо

Хүснэгт №8. Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний тоо

Хүснэгт №9. Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан шүүгчийн захирамжийн тоо

Хүснэгт №10. Анхан шатны шүүхийн хэргийн үлдэгдэл

Хүснэгт №11. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг

Хүснэгт №12. Хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн, харьцуулсан байдал

Хүснэгт №13. Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн мэдээлэл

Хүснэгт №14. Шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн мэдээлэл

Хүснэгт №15. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг

Хүснэгт №16. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоо

График

График №1. Монгол Улсын шүүхийн байгууллагын тогтолцоо

График №2. Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар шүүгчийн гаргасан захирамжийн төрөл

График №3. Ял шийтгүүлэгчдийг насны бүлэг

График №4. Ял шийтгүүлэгчдийг боловсролын байдал

График №5. Ял шийтгүүлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн байдал

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ-CORRECTION

Хүснэгт

Хүснэгт №1. Хорих ял эдлэгсдийн судалгаа

Хүснэгт №2. Хорих ял эдлэгсдийн хүйсийн судалгаа

Хүснэгт №3. Хорих ял эдлэгсдийн боловсролын судалгаа

Хүснэгт №4. Хорих ял эдлэх хугацааны судалгаа

- Хүснэгт №5. Хорих ял эдлэгсдийн ял шийтгэгдсэн зүйлчлэлийн судалгаа
- Хүснэгт №6. Хорих ял эдлэгсдийн орон нутгийн харьяаллын судалгаа
- Хүснэгт №7. Хорих ял эдлэгсдийн шүүхээр хэдэн удаа ял шийтгүүлсэн талаарх судалгаа
- Хүснэгт №8. Хорих ял эдлэгсдийн иргэний харьяалал
- Хүснэгт №9. Хорих анги, цагдан хорих байрнаас оргосон хоригдол, хоригдогчийн судалгаа
- Хүснэгт №10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэсэн хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл
- Хүснэгт №11. Торгох ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №12. Торгох ял (хуулийн этгээдэд оногдуулсан)-ын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №13. Нийтэд тустай ажил хийлгэх ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №14. Эрх хасах ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №15. Зорчих эрхийг хязгаарлах ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэсэн хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл
- Хүснэгт №17. Тэнссэн этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №18. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №19. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №20. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №21. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)
- Хүснэгт №22. Хуулийн этгээдэд эрх хасах, татан буулгах албадлагын арга хэмжээ авсан судалгаа
- Хүснэгт №23. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа
- Хүснэгт №24. Баривчлагдсан этгээдийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)
- Хүснэгт №25. Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)
- Хүснэгт №26. Цагдан хоригдсон хоригдогсдын судалгаа

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР- ANTI-CORRUPTION AGENCY

Хүснэгт

- Хүснэгт №1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гомдол, мэдээллийн сүүлийн 5 жилийн шийдвэрлэлтийн харьцуулсан тоо
- Хүснэгт №2. Гомдол, мэдээлэлд холбон шалгасан этгээдийн албан тушаалын байдал
- Хүснэгт №3. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал

Хүснэгт №4. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн албан тушаалын ангилал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График

График №1. Хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График №2. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо

График №3. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График №4. Шүүхээс шийдвэрлэгдсэн хэрэг

График №5. Хэргийн шийдвэрлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График №6. Ажиллагаанд байгаа хэргийн тоо (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График №7. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭ-FORENSIC

Хүснэгт

Хүснэгт №1. Улсын хэмжээнд Шүүх шинжилгээний ерөнхий газарт хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 5 жилээр)

Хүснэгт №2. 2024 онд хийсэн шүүх шинжилгээ (аймаг, шинжилгээний төрлөөр)

Хүснэгт №3. 2024 оны криминалистикийн шинжилгээний тоо (шинжилгээний төрөл, аймгаар)

Хүснэгт №4. Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн шүүх анагаах ухааны шинжилгээ

Хүснэгт №5. Улсын хэмжээнд хийсэн шинжилгээ (сүүлийн 7 жилээр)

Хүснэгт №6. Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд хийсэн байгалийн ухааны шинжилгээ (шинжилгээний төрөл, аймгаар)

Хүснэгт №7. Хэргийн газрын үзлэг (хэргийн өнгөөр)

Хүснэгт №8. 2024 онд хэргийн газрын үзлэгт оролцсон байдал (хэргийн өнгө, аймгаар)

Хүснэгт №9. Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт төрлөөр

Хүснэгт №10. 2024 онд хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт (аймаг тус бүрээр)

Хүснэгт №11. 2024 оны сан баяжуулалт, ашиглалтын статистик (аймаг тус бүрээр)

График

График №1. Шүүх шинжилгээний ерөнхий газарт 2024 онд хийсэн нийт шинжилгээний тоо (шинжилгээний төрлөөр)

График №2. Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээ (сүүлийн 5 жилээр)

График №3. Шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 5 жилээр)

График №4. Криминалистикийн шинжилгээ

График №5. Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ (төрлөөр)

График №6. Эдийн засгийн шинжилгээ (хэргийн төрлөөр)

График №7. Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд хийсэн тусгай шинжилгээ (хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ)

График №8. Экологийн шинжилгээ (эрүүгийн хэргийн төрлөөр)

График №9. Хэргийн газрын үзлэг (хэргийн өнгөөр)

График №10. Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт (төрлөөр)

График №11,12. 2024 оны сангийн баяжуулалт (Арсенал, Папилон)

Зураг

Зураг №1. Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ-CRIMINAL DAMAGE

Хүснэгт

Хүснэгт №1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Хүснэгт №2. Тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Хүснэгт №3. Гэмт хэргийн онцлог, нөхцөл байдлын улмаас учирсан хохирол

Хүснэгт №4. Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог байдлын улмаас учирсан хохирол

Хүснэгт №5. Прокурорын байгууллагад бүртгэгдсэн хохирогч

График

График №1. Хохирсон хүн, хуулийн этгээдийн байдал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График №2. Нийт хохирол, нөхөн төлүүлсэн байдал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График №3. Учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө, нөхөн төлүүлсэн байдал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

График №4. Хохирогчид (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

ХҮҮХЭД-CHILDREN

Хүснэгт

Хүснэгт №1. 2023, 2024 онд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоон үзүүлэлт, харьцуулалт

Хүснэгт №2. Хүүхэд хохирсон зам тээврийн ослын тоо

Хүснэгт №3. Зам тээврийн ослын улмаас нас барсан болон гэмтсэн хүүхдийн тоо

Хүснэгт №4. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн насны ангилал

Хүснэгт №5. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

Хүснэгт №6. Явган зорчигч ба дугуйтай хүний буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Хүснэгт №7. Хүүхэд өртөж хохирсон гэмт хэргийн шийдвэрлэлт

Хүснэгт №8. Хүүхдийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж, хорих ял эдлэгсдийн тоо

Хүснэгт №9. Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)

Хүснэгт №10. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо

Хүснэгт №11. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо (Эрүүгийн хуулийн зүйл ангиар)

Хүснэгт №12. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн цаг, гараг, газар

График

График №1. Хохирсон хүүхдийн төрөл, насны ангилал

График №2. Хүүхдэд учирсан хохирлын хэмжээ

График №3. Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо

График №4. Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэргийн түвшин

График №5. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн төрөл

График №6. Нийслэлийн дүүргүүдийн нутаг дэвсгэрт хүүхэд өртсөн зам тээврийн ослын тоо

График №7. Орон нутагт хүүхэд өртсөн зам тээврийн ослын тоо

График №8. Хүүхэд зам тээврийн осолд өртсөн хэлбэр

График №9. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн түвшин (2005-2024 он)

График №10. Энэ төрлийн гэмт хэргийн сүүлийн 10 жилийн илрүүлэлтийн хувь (хэргийн ангиллаар)

График №11. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн нас, хүйс, боловсролын түвшин

Зураг

Зураг №1. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн газрын харьцуулалт

Зураг №2. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн ерөнхий нөхцөл байдал

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ-PREVENTIVE MAINTENANCE

Зураг

Зураг №1. "Colombo Plan" байгууллагын Зөвлөлдөх хорооны 48 дахь хурлын оролцогчид

Зураг №2. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалтад оролцогчид

Зураг №3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тусгай чиг үүргийн байгууллагуудын алба хаагчид

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЦАГДАА - POLICE

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
3. ГЭМТ ХЭРЭГ
4. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА
5. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭЛТ
6. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ
7. ЭРҮҮЛЖҮҮЛЭГДСЭН ХҮН
8. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ



МОНГОЛ УЛСАД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ (2024)

УЛСЫН ХЭМЖЭЭНД

44673 +25.6%



12550 +16.5%

ОРОН НУТАГТ

32123 +28.6%


НИЙСЛЭЛД



ГЭМТ ХЭРГИЙН БҮТЭЦ




АНГИЛАЛ



ЗОНХИЛОХ ТӨРӨЛ

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДАЛ



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧ
(2024)



НИЙТ
ХОЛБОГДСОН 25291 +4.8%



6.6%

ХҮҮХЭД
1675 +5.1%



21.6%

ЭМЭГТЭЙ
5468 +8.9%

НАС

ЭРЭГТЭЙ

ЭМЭГТЭЙ

36

70+

5

68

65-69

134

222

60-64

40

459

55-59

120

643

50-54

159

1033

45-49

214

1674

40-44

294

2183

35-39

564

3715

30-34

505

3332

25-29

658

4881

18-24

2677

860

16-17

46

717

14-15

52



СОГТУУГААР
ҮЙЛДСЭН
ГЭМТ ХЭРЭГТ
ХОЛБОГДСОН ХҮН

6862 +37.8%



МАНСУУРУУЛАХ ЭМ,
СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ
БОДИС ХУУЛЬ БУСААР
АШИГЛАХ ГЭМТ ХЭРЭГТ
ХОЛБОГДСОН ХҮН

221 +0.5%



НАСАНД ХҮРЭЭГҮЙ
ХҮН ҮЙЛДСЭН
ГЭМТ ХЭРЭГТ
ХОЛБОГДСОН ХҮН


1373 +8.1%




ЭМЭГТЭЙ ХҮН
ҮЙЛДСЭН
ГЭМТ ХЭРЭГТ
ХОЛБОГДСОН ХҮН

5468 +8.9%

АЙМГУУДАД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ



ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ



1.Товч танилцуулга

Монгол Улсын цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн тусгай алба юм.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авч шалгах, нууц далд аргаар үйлдэгдсэн болон тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах, гэрч, хохирогчийг хамгаалах, хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Мөн гудамж талбай, олон нийтийн газарт цагдаагийн эргүүл зохион байгуулах, байнгын болон түр хяналтын цэг ажиллуулах, тээврийн хэрэгсэл ашиглан хяналт тавих, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлуудыг иргэн, хуулийн этгээдийн дэмжлэг, туслалцаатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан үед нийтийн хэв журам сахиулах, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үед хамгаалалт зохион байгуулах, гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хорио цээрийн дэглэм сахиулах, дипломат төлөөлөгчийн газрыг хамгаалах, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах зэрэг ажлыг зохион байгуулдаг.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө, зөрлөгүүдэд хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа цагдаагийн төв байгууллага болон иргэддээ тайлагнан, хамтран ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж буй 90 гаруй хуульд тусгагдсан хэм хэмжээгээр үүрэг хүлээж ажилладаг ба гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон олон тооны захиргааны үүргийг хэрэгжүүлдэг.

“Монголын цагдаагийн байгууллага” гэсэн тогтолцоо бие дааж бүрэлдэн тогтох үйл явц 1990 оны 4 дүгээр сард НАХЯ-ыг татан буулгаж, УЦСЕГ-ыг төрийн захиргааны төв байгууллагын түвшинд байгуулснаар эхэлж, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатайгаар хөгжих болсон.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийг 1993 онд баталж, 1994 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр шинэ үеийн цагдаагийн байгууллагын үндэс суурь бүрэлдэж тогтсон ч нийгмийн хэрэгцээ, шаардлагатай уялдан 2017 онд Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн баталсан.

Цагдаагийн байгууллага нь Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Хэрэг бүртгэх алба, Урьдчилан сэргийлэх алба, Стратеги, бодлого, инновац, хөгжлийн алба, Экологийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын хангах алба, Тээврийн цагдаагийн алба, Санхүү, аж ахуйн алба, Интерполын үндэсний төв товчоо, Захиргааны удирдлагын газар, Хар тамхитай тэмцэх газар, Дотоод хяналт-Аюулгүй байдлын газар, Тусгай ажиллагааны газар, Тусгай газраас бүрдэнэ.

2.Гомдол, мэдээлэл

Цагдаагийн байгууллага нь 2024 онд иргэн, хуулийн этгээдээс 323607 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 116320 буюу 35.9% нь гэмт хэргийн шинжтэй, 198889 буюу 61.5% нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол,

мэдээлэл 14547 буюу 4.7%, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 14601 буюу 14.4%-иар тус тус өссөн бол зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 552 буюу 0.3%-иар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 32101 буюу 27.6%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 82776 буюу 71.2%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1443 буюу 1.2%-ийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 124255 буюу 62.5%-ийг зөрчлийн хэрэг нээж, 72701 буюу 36.6%-ийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 1933 буюу 0.9%-ийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1.Цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээллийг бүртгэсэн нэгжээр нь

№	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага		Өмнөх үлдэгдэл гомдол, мэдээлэл	Үүнээс	Тухайн онд шинээр хүлээн авсан гомдол, мэдээлэл	Нийт шалгасан гомдол, мэдээлэл
				Шийдвэрлэсэн		
А			1	2	3	8
1	Баруун бүс	Баян-Өлгий	69	69	3424	3493
2		Говь-Алтай	16	16	1983	1999
3		Завхан	32	32	1889	1921
4		Үүнээс: Тосонцэнгэл	11	11	876	887
5		Увс	43	43	2693	2736
6		Ховд	66	66	4105	4171
7		Үүнээс: Булган	6	6	759	765
8	Хангайн бүс	Архангай	46	46	2981	3027
9		Баянхонгор	80	80	4426	4506
10		Булган	38	38	2562	2600
11		Орхон	139	139	5607	5746
12		Өвөрхангай	59	59	4124	4183
13		Үүнээс: Хархорин	20	20	1406	1426
14		Хөвсгөл	63	63	3204	3267
15	Төвийн бүс	Говьсүмбэр	21	21	1473	1494
16		Дархан-Уул	68	68	4648	4716
17		Дорноговь	87	87	4821	4908
18		Үүнээс: Замын-Үүд	18	18	1817	1895
19		Дундговь	28	28	1798	1826
20		Өмнөговь	88	88	5807	5895
21		Үүнээс:Цогтцэций сум	23	15	1482	1505
22		Сэлэнгэ	114	114	5932	6046
23		Үүнээс: Мандал	33	33	2157	2190
24		Төв	24	24	4649	4673
25		Үүнээс: Заамар	5	5	1147	1152
26	Зүүн бүс	Дорнод	57	57	4175	4232
27		Сүхбаатар	69	69	3023	3092
28		Хэнтий	99	99	4568	4667
29		Үүнээс: Бор-Өндөр	14	11	893	907
30	Нийслэл		4507	4507	193164	197671
31	Баянгол		870	870	28971	29841
32	I хэлтэс		522	522	15090	15612
33	II хэлтэс		348	348	13881	14229
34	Баянзүрх		1173	1173	50340	51513
35	I хэлтэс		643	643	25973	26616
36	II хэлтэс		323	323	13717	14040
37	III хэлтэс		207	207	10650	10857
38	Сүхбаатар		691	691	22531	23222
39	I хэлтэс		467	467	12784	13251
40	II хэлтэс		224	224	9747	9971

41	Сонгинохайрхан	693	693	41885	42578
42	I хэлтэс	386	386	22276	22662
43	II хэлтэс	153	153	12360	12513
44	III хэлтэс	154	154	7249	7403
45	Хан-Уул	543	543	24396	24939
46	I хэлтэс	331	331	14894	15225
47	II хэлтэс	212	212	9502	9714
48	Чингэлтэй	444	444	19282	19726
49	I хэлтэс	219	219	9051	9270
50	II хэлтэс	225	225	10231	10456
51	Багануур	44	44	2314	2358
52	Багахангай	6	6	479	485
53	Налайх	43	43	2966	3009
54	Мөрдөн байцаах алба	23	23	635	658
55	Эрүүгийн цагдаагийн алба	35	35	1139	1174
56	Экологийн цагдаагийн алба	8	8	828	836
57	ЦА	ЗЦГ	146	146	41036
58		ИАТ			
59		Төмөр зам	6	6	433
60	НЦУГ	Халаасны хулгай	9	9	1464
61	Хар тамхитай тэмцэх газар	10	10	503	513
62	НХЖХ, ОНАБХА				
63	Зөрчлийн хэрэг бүртгэх алба			61	61
64	Дотоодын цэргийн штаб	10	10	279	289
65	Улсын дүн	6060	6060	317547	323607

3.Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт **44673** гэмт хэрэг бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод **32123** (71.9%), орон нутагт **12550** (28.1%), гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Улсын хэмжээнд нийт 9099 хэрэг буюу 25.6%,
- Нийслэлд 7145 хэрэг буюу 28.6%,
- Орон нутагт 1974 хэрэг буюу 16.5%-иар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн **38953** буюу 87.2% нь хөнгөн, **5720** буюу 12.8% нь хүнд ангиллын хэрэг байх бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.3%-иар, хүнд гэмт хэрэг 43.5%-иар тус тус өссөн байна.

График 1.Сүүлийн 20 жилд бүртгэгсэн гэмт хэрэг





График 2.Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл



3.1. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг)

2024 онд цагдаагийн байгууллагад нийт 44673 гэмт хэрэг бүртгэсэн. Тэр дундаа хүний амьд явах эрхийн эсрэг 852 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 1.9%-ийг эзэлж байна. Энэ бүлгийн гэмт хэрэг нь өмнөх оноос 279 буюу 48.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 37.7%, нийслэлд 26.3%, орон нутагт 65.3% байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 28.2 нэгжээр, нийслэлд 43.5 нэгжээр буурсан бол орон нутагт 5.0 нэгжээр өссөн.

3.1.1. Хүнийг алах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл)

Хүнийг алах гэмт хэрэг 2024 онд 191 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 8 буюу 4.0%-иар буурчээ. Улсын хэмжээнд нийт бүртгэсэн 44673 гэмт хэргийн 191 буюу 0.3%-ийг хүнийг алах гэмт хэрэг эзэлж байна. Харин нийслэлд хүнийг алах гэмт хэрэг 104 бүртгэсэн нь өмнөх оноос 17 хэргээр буюу 14.0%-иар буурч, орон нутагт 87 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 9 хэргээр буюу 11.5%-иар өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэргийг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 29 буюу 15.2% нь Даваа гарагт, 23 буюу 12.0% нь Мягмар гарагт, 32 буюу 16.8% нь Лхагва гарагт, 34 буюу 17.8% нь Пүрэв гарагт, 24 буюу 12.6% нь Баасан гарагт, 23 буюу 12.0% нь Бямба гарагт, 26 буюу 13.6% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 47 буюу 24.6% нь 06:00-14:00 цагт, 32 буюу 16.8% нь 14:00-19:00 цагт, 34 буюу 17.8% нь 19:00-22:00 цагт, 78 буюу 40.8% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 115 буюу 60.2% нь гэр, орон сууцанд, 40 буюу 21.0% нь гудамж талбайд, 8 буюу 4.2% нь олон нийтийн газарт, 5 буюу 2.6% нь аж ахуй нэгжид, 22 буюу 11.5% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 144 буюу 75.4% нь согтуугаар, 3 буюу 1.6% нь хүүхэд оролцож, 23 буюу 12.0% нь эмэгтэй хүн оролцож, 11 буюу 5.8% нь бүлэглэн, 37 буюу 19.4% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 125 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7 хэрэг буюу 5.9%-иар, үүнээс 121 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 4 буюу 3.4%-иар тус тус өссөн.

Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 96.8% байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.4 нэгжээр, нийслэлд 96.3% байгаа нь 3.7 нэгжээр, орон нутагт 97.8% байгаа нь 0.7 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүн. Нийт 204 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 11 буюу 5.1%-иар буурсан. Холбогдогчдын 22 буюу 10.8% нь эмэгтэй, 182 буюу 89.2% нь эрэгтэй, 3 буюу 1.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх онтой харьцуулахад эрэгтэй хүн 4 буюу 2.2%-иар, эмэгтэй хүн 7 буюу 24.1%-иар тус тус буурч, хүүхэд өмнөх оны түвшинд байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 196 иргэн хохирч, үүнээс 172 хүн нас барж, 24 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 7 буюу 3.4%-иар, гэмтсэн хүн 7 буюу 22.6%-иар тус тус буурч, нас барсан хүн 172 байгаа нь адил дүнтэй байна.

Учирсан хохирол. Иргэн учирсан 2424.3 сая төгрөгийн хохирлын 1843.8 сая төгрөг буюу 76.1%-ийг нөхөн төлүүлж, 139.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад учирсан хохирол 698.8 сая төгрөг буюу 40.5%-иар, нөхөн төлүүлсэн хохирол

118.3 сая төгрөг буюу 6.9%-иар, битүүмжилсэн хөрөнгө 38.9 сая төгрөг буюу 38.6%-иар тус тус өссөн байна.

3.2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг)

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд 8935 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 404 буюу 4.7%-иар өсөж, нийслэлийн хэмжээнд 5173 бүртгэгдсэн нь 34 буюу 0.7%-иар буурч, орон нутгийн хэмжээнд 3761 бүртгэгдсэн нь 440 буюу 13.2%-иар өсөж, бусад газар /хилийн чандад/-т 1 бүртгэгдсэн нь 2 буюу 66.7%-иар буурсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1292 буюу 14.5% нь Даваа гарагт, 1273 буюу 14.2% нь Мягмар гарагт, 1264 буюу 14.1% нь Лхагва гарагт, 1249 буюу 14.0% нь Пүрэв гарагт, 1230 буюу 13.8% нь Баасан гарагт, 1396 буюу 15.6% нь Бямба гарагт, 1231 буюу 13.8% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 1990 буюу 22.3% нь 06:00-14:00 цагт, 1934 буюу 21.7% нь 14:00-19:00 цагт, 1434 буюу 16.0% нь 19:00-22:00 цагт, 3577 буюу 40% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 3160 буюу 35.4% нь гэр, орон сууцанд, 2526 буюу 28.3% нь гудамж талбайд, 1392 буюу 15.6% нь олон нийтийн газарт, 515 буюу 5.8% нь аж ахуйн нэгжид, 1342 буюу 14.9% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 3806 буюу 42.65 нь согтуугаар, 366 буюу 4.15 нь хүүхэд оролцож, 826 буюу 9.25 нь эмэгтэй хүн оролцож, 1341 буюу 15.05 нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 333 буюу 3.75 нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 6934 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 523 хэрэг буюу 8.2%-иар өсөж, үүнээс 4362 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 177 буюу 3.9%-иар буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 62.95 байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 54.6% байгаа нь 10.2 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 79.8% байгаа нь 6.4 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 6916 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 308 буюу 4.3%-иар буурсан. Холбогдогчдын 731 буюу 10.6% нь эмэгтэй, 6185 буюу 89.4% нь эрэгтэй, 404 буюу 5.8% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 292 буюу 4.5%, эмэгтэй хүн 16 буюу 2.1%-иар, хүүхэд 32 буюу 7.3%-иар тус тус буурсан байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 9331 иргэн хохирч, үүнээс 11 хүн нас барж, 9001 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 408 буюу 4.6%, гэмтсэн хүн 640 буюу 7.7%-иар, нас барсан хүн 5 буюу 83.3%-иар тус тус өссөн байна.

Гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргээр нь авч үзвэл 7418 буюу 82.3% нь хөнгөн, 1077 буюу 12.0% нь хүндэвтэр, 506 буюу 5.6% нь хүнд зэргийн гэмтэл учирсан байна.

Учирсан хохирол. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 14619.3 сая төгрөгийн хохирлын 11058.4 сая төгрөг буюу 75.6%-ийг нөхөн төлүүлж, 541.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 21780.4 сая төгрөг буюу 59.8%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 11614.5 сая төгрөг буюу 51.2%-иар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 497.3 сая төгрөг буюу 12.3 дахин өссөн байна.

3.2.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1559 бүртгэгдсэн нь өмнөх оноос 144 буюу 10.2%-иар, орон нутгийн хэмжээнд 862 бүртгэгдсэн нь 186 буюу 27.3%-иар тус тус өсөж, нийслэлийн хэмжээнд 697 бүртгэгдсэн нь 41 буюу 5.6%-иар буурсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 257 буюу 16.5% нь Даваа гарагт, 195 буюу 12.5% нь Мягмар гарагт, 233 буюу 14.9% нь Лхагва гарагт, 220 буюу 14.1% нь Пүрэв гарагт, 217 буюу 13.9% нь Баасан гарагт, 205 буюу 13.1% нь Бямба гарагт, 232 буюу 14.9% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 349 буюу 22.4% нь 06:00-14:00 цагт, 372 буюу 23.9% нь 14:00-19:00 цагт, 306 буюу 19.6% нь 19:00-22:00 цагт, 532 буюу 34.1% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1293 буюу 82.9% нь гэр, орон сууцанд, 101 буюу 6.7% нь гудамж талбайд, 30 буюу 1.7% нь олон нийтийн газарт, 3 буюу 0.2% нь төрийн байгууллагад, 1 буюу 0.1% нь төрийн бус байгууллагад, 12 буюу 0.8% нь аж ахуйн нэгжид, 119 буюу 7.6% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 844 буюу 54.1% нь согтуугаар, 2 буюу 0.1% нь мансуурсан үедээ, 12 буюу 0.8% нь хүүхэд оролцож, 127 буюу 8.1% нь эмэгтэй хүн оролцож, 6 буюу 0.4% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 1309 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 25 буюу 1.9%-иар буурсан. Холбогдогчдын 106 буюу 8.1% нь эмэгтэй, 1203 буюу 91.9% нь эрэгтэй, 14 буюу 1.1% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оноос эрэгтэй хүн 34 буюу 2.7%-иар буурч, эмэгтэй хүн 9 буюу 9.3%-иар, хүүхэд 7 буюу 2.0 дахин тус тус өссөн байна.

Хохирсон хүн. Гэмт хэргийн улмаас 1578 иргэн хохирсон, үүнээс 1345 буюу 85.2% нь эмэгтэй, 203 буюу 12.9% нь хүүхэд, 28 буюу 1.8% нь нас барсан, 1303 буюу 82.6%-ийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулбал, хохирсон иргэн 118 буюу 8.1%-иар, өртөж хохирсон хүүхэд 32 буюу 18.7%-иар, эмэгтэй хүн 63 буюу 4.8%-иар, нас барсан 7 буюу 33.3%-иар, гэмтсэн хүн 65 буюу 5.3%-иар тус тус өсжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 720, хамтран амьдрагч 360, төрсөн хүүхэд 86, дагавар хүүхэд 43, үрчилж авсан хүүхэд 2, төрсөн эцэг, эх 32, төрсөн ах, эгч 19, төрсөн дүү 28, хадам эцэг, эх 12, бусад 197 хүн байна.

Учирсан хохирол. Энэ гэмт хэргийн улмаас 3251.3 сая төгрөгийн хохирол учирсан байна.

График 3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн төрөл



3.3. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг)

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2024 онд 847 бүртгэсэн нь нийт бүртгэсэн гэмт хэргийн 1.9%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд шинээр бүртгэсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 119 хэргээр буюу 16.35%-иар, нийслэлд 481 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 117 хэргээр буюу 32.14%-иар, орон нутагт 366 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 2 хэргээр буюу 0.55%-иар тус тус өссөн байна.

3.3.1. Хүчиндэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл)

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 658 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 94 буюу 16.7%-иар, нийслэлд 365 бүртгэгдсэн нь 78 буюу 27.2%-иар, орон нутагт 293 бүртгэгдсэн нь 16 буюу 5.78%-иар тус тус өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 85 буюу 12.9% нь Даваа гарагт, 77 буюу 11.7% нь Мягмар гарагт, 119 буюу 18.1% нь Лхагва гарагт, 93 буюу 14.1% нь Пүрэв гарагт, 100 буюу 15.2% нь Баасан гарагт, 95 буюу 14.4% нь Бямба гарагт, 89 буюу 13.5% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн, цагаар нь авч үзвэл 155 буюу 23.5% нь 06:00-14:00 цагт, 148 буюу 22.5% нь 14:00-19:00 цагт, 77 буюу 11.7% нь 19:00-22:00 цагт, 278 буюу 42.2% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 414 буюу 62.9% нь гэр, орон сууцанд, 75 буюу 11.4% нь гудамж талбайд, 48 буюу 7.3% нь олон нийтийн газарт, 18 буюу 2.7% нь аж ахуйн нэгжид, 3 буюу 0.4% нь төрийн бус байгууллагад, 5 буюу 0.7% нь нийтийн тээвэрт, 92 буюу 14% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэгдсэн хэргийн 149 буюу 22.6% нь согтуугаар, 23 буюу 3.5% нь хүүхэд оролцож, 8 буюу 1.2% нь эмэгтэй хүн оролцож, 117 буюу 17.8% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 29 буюу 4.4% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хэрэг бүртгэлтийн 566 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 99 хэрэг буюу 21.2%-иар өсөж, үүнээс 207 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 11 буюу 5.1%-иар буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 36.5% байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.1 нэгжээр, орон нутагт 49.0% байгаа нь 7 нэгжээр, нийслэлд 24.2% байгаа нь 15.4 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 329 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 буюу 8.6%-иар, 27 буюу 8.2% нь 14-17 насны хүүхэд байгаа нь 25 буюу 48.1%-иар тус тус буурсан байна

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 675 иргэн хохирч, 49 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс хохирсон хүн 110 буюу 19.5%-иар, гэмтсэн хүн 4 буюу 8.9%-иар тус тус өссөн.

Хохирсон иргэдийн 436 буюу 64.6% нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 7 нь хүүхэд байна гэсэн үг юм.

Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 29 буюу 4.3% нь 7 хүртэлх, 173 буюу 25.6% нь 8-13 насны, 234 буюу 34.7% нь 14-17 насны хүүхэд байна.

3.4. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг)

2024 онд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 586 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 1.31%-ийг эзэлж байна.



Улсын хэмжээнд энэ төрлийн 586 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 229 гэмт хэрэг буюу 64.1%-иар, нийслэлд 444 бүртгэгдсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 169 гэмт хэрэг буюу 61.45%-иар, орон нутагт 142 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 60 хэргээр буюу 73.2%-иар тус тус өсжээ.

3.5. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлэг)

2024 онд хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг 42 гэмт хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 41 хэргээр буюу 42 дахин өссөн байна. 2023 онд нийслэлд энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй бөгөөд 2024 онд 13 гэмт хэрэг бүртгэгдсэн. Харин орон нутагт 2024 онд энэ төрлийн 29 гэмт хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 28 хэргээр буюу 29 дахин өссөн үзүүлэлттэй байна.

3.6. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэг)

2024 онд 48 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 9 хэргээр буюу 23.1%-иар, нийслэлд 39 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 15 хэргээр буюу 62.5%-иар тус тус өссөн бол орон нутагт 9 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 6 хэргээр буюу 40%-иар буурсан байна.

3.7. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэг)

2024 онд хүүхдийн эсрэг 66 гэмт хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 2 хэргээр буюу 2.9%-иар буурсан бол, нийслэлд 55 гэмт хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 8 хэргээр буюу 17%-иар өссөн, орон нутагт 11 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 10 хэргээр буюу 47.6%-иар буурсан байна.

3.8. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг)

2024 онд цагдаагийн байгууллагад өмчлөх эрхийн эсрэг 27971 гэмт хэрэг шинээр бүртгэгдсэн нь нийт хэргийн 62.6%-ийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 6285 хэргээр буюу 29%-иар, нийслэлд 22718 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 5982 хэргээр буюу 35.7%-иар, орон нутагт шинээр 5253 бүртгэгдсэн нь өмнөх оноос 303 хэргээр буюу 6.1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3.8.1. Хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл)

Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2024 онд 7626 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2225 буюу 41.2%-иар, нийслэлд 6041 бүртгэгдсэн нь 2423 буюу 67%-иар тус тус өссөн бол, орон нутагт 1585 бүртгэгдсэн нь 198 буюу 11.1%-иар буурсан байна.

2	2024	Тоо эзлэх/хувь	110 9.8	22760 89.4	1812 78.9	197 86.4	1060 77.5	47 85.5	58 16.9	12 12.6
Орон нутаг										
3	2024	Тоо эзлэх/хувь	1013 90.2	2708 10.6	485 21.1	31 13.6	307 22.5	8 14.5	286 83.1	83 87.4

Улсын хэмжээнд явган зорчигч мөргөх хэлбэрээр гарсан зам тээврийн ослын 1812 буюу 78.9% нь нийслэлд бүртгэгдсэн.

Онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн 1123 ослын 1013 буюу 90.2% нь орон нутгийн замд гарсан байна.

График 12. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын хэлбэрийн харьцуулалт



Хүснэгт 13. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлт

Төв, орон нутаг дэвсгэр /аймаг/	Онхолдох	Мөргөлдөх	Явган зорчигч мөргөх	Дугуйтай зорчигч мөргөх	Үл хөдлөх зүйл мөргөх	Зорчигч унагах	Мал, амьтан мөргөх	Бусад
Төв	122	343	27	1	23	0	79	11
Өмнөговь	150	320	1	0	29	0	7	3
Сэлэнгэ	75	292	29	4	33	1	61	6
Орхон	25	291	48	7	19	0	3	7
Хэнтий	67	174	24	1	39	0	22	7
Ховд	64	129	45	0	31	0	17	14
Баянхонгор	55	140	40	1	7	2	2	0
Дорноговь	49	151	16	0	16	0	2	11
Булган	41	112	13	0	9	0	25	1
Дархан-Уул	24	97	49	4	14	0	6	2
Өвөрхангай	29	122	13	1	5	0	17	1
Дорнод	36	63	47	3	8	1	5	2
Сүхбаатар	34	74	23	2	10	0	8	6
Баян-Өлгий	25	88	25	1	13	0	4	1
Хөвсгөл	30	69	25	0	13	1	0	2
Дундговь	48	49	9	1	5	0	9	2

Увс	30	41	17	2	17	0	4	1
Завхан	46	29	7	1	10	1	6	1
Архангай	34	44	14	0	1	0	2	1
Говьсүмбэр	10	55	3	1	4	0	3	3
Говь-Алтай	19	25	10	1	1	2	4	1
Орон нутаг	1013	2708	485	31	307	8	286	83
Баянгол	4	4037	302	40	129	4	1	1
Баянзүрх	14	5666	467	46	281	14	14	0
Сүхбаатар	8	3085	260	34	155	6	0	4
Сонгинохайрхан	34	4077	296	19	216	10	23	2
Хан-Уул	26	4192	254	39	157	7	9	1
Чингэлтэй	2	1503	206	15	95	6	2	3
Багануур	7	26	13	4	9	0	4	0
Багахангай	4	7	0	0	6	0	2	1
Налайх	11	167	14	0	12	0	3	0
Нийслэл	110	22760	1812	197	1060	47	58	12

Зам тээврийн осол гарсан улирал

Зам тээврийн ослын 7676 буюу 24.8% нь өвөл, 6652 буюу 21.5% нь хавар, 7417 буюу 23.9% нь зун, 9232 буюу 29.8% нь намар бүртгэгджээ. Өвлийн улиралд замын гадаргууд өөрчлөлт орох, халтиргаа гулгаанаас хамааралтай зам тээврийн ослын дуудлага өсдөг учир тухайн улиралд бүртгэгдсэн осол их байна. Хүний амь нас хохирсон осол зун болон намрын улиралд их бүртгэгдсэн нь жолоочийн бэлтгэгдсэн байдал, жолоочид харшлах эм бэлдмэлийн талаарх ойлголт, тухайн улиралд аялал зугаалга, хичээл сургалтын шилжилт хөдөлгөөн хийдэгтэй нягт холбоотой байхад өвлийн улиралд ослын гэмтэл, бэртэл ихэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 14.Бүртгэгдсэн зам тээврийн осол гарсан, учирсан хохирол сараар

Сар	Улс	Хүний амь нас хохирсон осол	Амь нас хохирсон хүн
1 сар	2346	14	22
2 сар	2159	25	31
3 сар	2027	25	28
4 сар	2003	37	44
5 сар	2622	57	64
6 сар	2600	55	63
7 сар	2315	61	76
8 сар	2502	59	67
9 сар	2911	63	65
10 сар	3381	61	66
11 сар	2940	54	62
12 сар	3171	37	43

Хүний амь нас хохирсон ослын бүртгэлээс харахад 7-10 сард хүний амь нас хохирсон тохиолдол их байна.


Зам тээврийн осол гарсан гараг, цагаар

Зам тээврийн ослын гаралт долоо хоногийн бүх өдрүүдэд жигд бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад Ням гарагт бүртгэгдсэн зам тээврийн осол өсөх хандлагатай байна.

Хүснэгт 15.Зам тээврийн осол бүртгэгдсэн гараг

№	Шалгуур үзүүлэлт	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Улсын хэмжээнд								
1	Тоон үзүүлэлт	4731	4503	4607	4415	4499	4198	4024
	Эзлэх хувь	15.3	14.5	14.9	14.3	14.5	13.6	13.0
Нийслэл								
2	Тоон үзүүлэлт	3970	3779	3950	3713	3773	3506	3365
	Эзлэх хувь	15.2	14.5	15.2	14.3	14.5	13.5	12.9
Орон нутаг								
3	Тоон үзүүлэлт	761	724	657	702	726	692	659
	Эзлэх хувь	15.5	14.7	13.4	14.3	14.8	14.1	13.4

График 13.Зам тээврийн осол бүртгэгдсэн гараг



Зам тээврийн осол гарсан цаг хугацаа

Бүртгэгдсэн 30977 зам тээврийн осол гарсан цагийг бүлэглэн авч үзвэл:

- ❖ 07.00-12.00 цагт 8106 буюу 26.2%;
- ❖ 13.00-18.00 цагт 10004 буюу 32.3%;
- ❖ 19.00-00.00 цагт 9141 буюу 29.5%;
- ❖ 01.00-06.00 цагт 3726 буюу 12% нь бүртгэгджээ.

График 14.Хүний амь нас хохирсон зам тээврийн осол бүртгэгдсэн цаг хугацаа



Улсын хэмжээнд бүртгэгдсэн 30977 зам тээврийн ослын 22851 буюу 73.7% нь өдөр, 8126 буюу 26.3% нь шөнийн цагт бүртгэгджээ.

Хүснэгт 16.Зам тээврийн осол бүртгэгдсэн цаг хугацаа

Зам тээврийн осол бүртгэгдсэн цаг	Улсын хэмжээнд	Улаанбаатарт	Орон нутагт
	Зам тээврийн ослын тоо		
07.00-12.00	8106	7164	942
13.00-18.00	10004	8379	1625
19.00-00.00	9141	7362	1779
01.00-06.00	3726	3151	575

Хүний амь нас хохирсон 548 зам тээврийн осол гарсан цагийн талаарх мэдээллийг нэгтгэн авч үзвэл 366 буюу 66.8% нь өдрийн цагт, 182 буюу 33.2% нь шөнийн цагуудад гарчээ.

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон зам тээврийн ослыг цагаар нь авч үзэхэд:

- ❖ 07:00-12:00 цагт 107 буюу 19.5%,
- ❖ 13:00-18:00 цагт 151 буюу 27.6%,
- ❖ 19:00-00:00 цагт 183 буюу 33.4%,
- ❖ 01:00-06:00 цагт 107 буюу 19.5% нь тус тус бүртгэгджээ.

Улсын хэмжээнд 2024 онд бүртгэгдсэн зам тээврийн осолд зам орчны нөхцөл байдлын мэдээлэл тодорхой орсон 30977 зам тээврийн осолд дараах байдлаар зам орчны үзүүлэлтийг гарган харуулав.

Хүснэгт 17.Зам тээврийн осол гарсан зам, орчин, цаг агаарын байдал

№	Цаг агаарын нөхцөл байдал	Ослын тоо	Эзлэх хувь
1	Таатай үед	28599	92.32
2	Цастай	1379	4.45
3	Үүлэрхэг	459	1.48
4	Манантай	59	0.19
5	Шуургатай	128	0.41
6	Бороотой	353	1.14

Хүснэгт 18.Зам тээврийн осол гарсан зам, орчин, цаг агаарын байдал

№	Үзэгдэх орчин	Ослын тоо	Эзлэх хувь
1	Чөлөөтэй	22836	73.72
2	Хязгаарлагдмал	1196	3.86
3	Зорчих хэсэг гэрэлтүүлэггүй	1505	4.86
4	Зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй	5244	16.93
5	Хангалтгүй	195	0.63

Хүснэгт 19.Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын гадаргуу	Ослын тоо	Эзлэх хувь
1	Хуурай	24100	77.8
2	Нойтон	2767	8.94
3	Мөстэй	4042	13.05
4	Бохирдсон	68	0.22

Хүснэгт 20.Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын онцлог	Ослын тоо	Эзлэх хувь
1	Тэгш	22988	74.21
2	Хазгай	353	1.14
3	Шулуун	5371	17.34
4	Өгсүүр	810	2.61
5	Уруу	1267	4.09
6	Огцом эргэлттэй	187	0.6

Хүснэгт 21.Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын ангилал	Ослын тоо	Эзлэх хувь
1	Ердийн	27631	82.2
2	Хорооллын	2639	8.52
3	Тууш	706	2.28
4	Хурдны	0	0

Хүснэгт 22.Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын хучилт	Ослын тоо	Эзлэх хувь
1	Асфальт	28954	93.47
2	Цемент	211	0.66
3	Бетон	229	0.74
4	Сайжруулсан	406	1.31
5	Хөрсөн	926	2.99
6	Хайрган	251	0.81

Хүснэгт 23.Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын хэсэг	Ослын тоо	Эзлэх хувь
1	Авто зам /Зорчих хэсэг/	23957	77.34
2	Явган зорчигчийн гарц	982	3.17
3	Автобусны буудал дээр	259	0.84
4	Төмөр замын гарам дээр	22	0.07

5	Гүүрэн дээр	141	0.46
6	Хонгил	35	0.11
7	Уулзвар	5581	18.02

Хүснэгт 24.Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

№	Замын өргөн	Ослын тоо	Эзлэх хувь
1	3.5 м хүртэл	393	1.27
2	3.5-5.5 м	1286	4.15
3	5.5-7.0 м	3922	12.66
4	7.0-9.0 м	13301	42.94
5	9.0-12.0 м	8575	27.69
6	12.0-16.0 м	2524	8.15
7	16.0-20.0 м	685	2.21
8	20 м-с дээш	291	0.94

6.3.Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг болон зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

Гэмт хэрэг бүртгэгдсэн байдал

Цагдаагийн байгууллагад 2024 онд бүх төрлийн 44673 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 9099 гэмт хэрэг буюу 25.6%-иар өссөн тоон үзүүлэлттэй байна. Нийт гэмт хэргийн 32123 буюу 71.9% нь Улаанбаатарт, 12550 буюу 28.1% нь орон нутагт үйлдэгдсэн байна.

Хүснэгт 25.Бүртгэгдсэн гэмт хэрэг харьцуулалт


Он	Бүх төрлийн гэмт хэрэг			Хөдөлгөөний аюулгүй байдал, Тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг		
	Тоон үзүүлэлт					
	Улс	Улаанбаатар	Орон нутаг	Улс	Улаанбаатар	Орон нутаг
2023	35574	24978	10596	1280	581	699
2024	44673	32123	12550	3167	1239	1928

Улсын хэмжээнд бүртгэгдсэн бүх төрлийн гэмт хэргийн 3167 буюу 7.1%-ийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 2.5 дахин өсжээ. Эдгээрээс үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг нь өнгөрсөн оны улсын хэмжээнд 2.5 дахин, орон нутагт 2.1 дахин, нийслэлд 2.8 дахин тус тус өссөн тоон үзүүлэлттэй байна.

График 15.Бүртгэгдсэн гэмт хэрэг харьцуулалт



График 16. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг харьцуулалт



Хүснэгт 26. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхцөл байдал


Аймаг, дүүрэг		Гарсан гэмт хэрэг			Амь эрсэдсэн хүн			Гэмтсэн хүн		
		2023 он	2024 он	Харьцуулалт	2023 он	2024 он	Харьцуулалт	2023 он	2024 он	Харьцуулалт
1	Архангай	24	74	3.1 дахин	16	16	0.0	23	29	26.1
2	Баян-Өлгий	9	58	6.4 дахин	4	13	3.2 дахин	7	20	2.9 дахин
3	Баянхонгор	26	77	3 дахин	7	12	71.4	21	23	9.5
4	Булган	25	71	2.8 дахин	8	15	87.5	20	19	-5.0
5	Говь-Алтай	12	76	6.3 дахин	6	8	33.3	10	12	20.0
6	Говьсүмбэр	10	54	5.4 дахин	5	6	20.0	5	21	4.2 дахин
7	Дархан-Уул	45	119	2.6 дахин	9	11	22.2	36	33	-8.3
8	Дорноговь	42	124	3 дахин	13	28	2.2 дахин	35	47	34.3
9	Дорнод	30	94	3.1 дахин	11	7	-36.4	26	31	19.2
10	Дундговь	28	47	67.9	9	3	-66.7	19	15	-21.1
11	Завхан	13	52	4 дахин	6	7	16.7	11	19	72.7
12	Орхон	34	97	2.9 дахин	2	6	3 дахин	33	30	-9.1
13	Өвөрхангай	36	158	4.4 дахин	9	20	2.2 дахин	30	32	6.7
14	Өмнөговь	63	141	2.2 дахин	17	21	23.5	49	39	-20.4
15	Сүхбаатар	30	83	2.8 дахин	8	5	-37.5	25	20	-20.0
16	Сэлэнгэ	40	113	2.8 дахин	20	23	15.0	31	44	41.9
17	Төв	91	155	70.3	40	39	-2.5	82	78	-4.9
18	Увс	18	62	3.4 дахин	8	8	0.0	11	10	-9.1
19	Ховд	37	88	2.4 дахин	13	8	-38.5	31	29	-6.5

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2024

20	Хөвсгөл	34	105	3.1 дахин	10	11	10.0	30	45	50.0
21	Хэнтий	52	80	53.8	34	9	-73.5	36	27	-25.0
Орон нутаг		699	1928	2.8 дахин	255	276	8.2	571	623	9.1
22	Баянгол	84	179	2.1 дахин	3	3	0.0	85	102	20.0
23	Баянзүрх	132	292	2.2 дахин	15	22	46.7	121	180	48.8
24	Сүхбаатар	81	155	91.4	6	6	0.0	74	106	43.2
25	Сонгинохайрхан	101	226	2.2 дахин	16	25	56.3	84	130	54.8
26	Хан-Уул	109	186	70.6	12	15	25.0	94	122	29.8
27	Чингэлтэй	49	152	3.1 дахин	3	8	2.7 дахин	45	71	57.8
28	Багануур	11	19	72.7	1	0	-1 дахин	10	4	-60.0
29	Багахангай	3	6	2 дахин	0	0	0	3	1	-3 дахин
30	Налайх	11	24	2.2 дахин	1	3	3 дахин	9	13	44.4
Нийслэл		581	1239	2.1 дахин	57	82	43.9	525	729	38.9
Улс		1280	3167	2.5 дахин	312	358	14.7	1096	1352	23.4

“Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” 2024 онд 3167 бүртгэгдсэний 2186 буюу 69.0% нь хэрэг бүртгэлтийн хэрэг байсан бол 1775 хэрэгт мөрдөн байцаалтын хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 81.2% байгаа нь өнгөрсөн оны илрүүлэлтээс 3.5%-ийн өсөлттэй байна. 2024 онд бүртгэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 3158 буюу 99.7% нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг эзэлсэн байна.

График 17. Гэмт хэрэгт холбогдогчийн хүйс



Хүснэгт 27. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн насны байдал

Насны байдал	Холбогдогчийн тоо	Эзлэх хувь
14-15	7	0.3
16-17	15	0.6
18-24	289	10.6
25-29	374	13.8
30-34	544	20.0
35-39	464	17.1
40-44	384	14.1
45-49	245	9.0
50-54	148	5.4
55-59	116	4.3
60-64	79	2.9
65-69	33	1.2
70-с дээш	20	0.7

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийн 44.4% нь 18-34 насны хүн эзэлж байна.

Хүснэгт 28. Гэмт хэрэгт холбогдсон хүний нийгмийн байдал

Нийгмийн байдал	Холбогдогч	Эзлэх хувь
Төрийн алба хаагч	171	6.3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	739	27.2
Хувийн хэвшлийн байгууллагад ажил эрхэлдэг	346	12.7
Төрийн бус байгууллагын ажилтан	53	1.9
Малчин	235	8.6
Ажил хөдөлмөр эрхэлдэггүй	1111	40.9
Оюутан	45	1.7
Сурагч	17	0.6
Сургууль завсардсан	1	0.0

Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийн 1111 буюу 40.9% нь тодорхой хөдөлмөр эрхэлдэггүй ба өмнө оны үзүүлэлттэй харьцуулан үзвэл: төрийн алба хаагч холбогдсон гэмт хэрэг 2.3 дахин, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3 дахин, хувийн хэвшлийн байгууллагад ажил эрхэлдэг хүмүүс 2.2 дахин тус тус өсжээ.

Хүснэгт 29. Гэмт хэрэгт холбогдсон хүний боловсролын байдал

Боловсрол	Холбогдогч	Эзлэх хувь
Бүрэн дунд	1560	57.4
Дээд	507	18.7
Бага	141	5.2
Бүрэн бус дунд	300	11.0
Тусгай мэргэжлийн дунд	138	5.1
Боловсрол эзэмшээгүй	72	2.6

Гэмт хэрэгт шалгагдсан хүмүүсийн боловсролын түвшний хувьд 57.4% нь бүрэн дунд боловсролтой байна.

Зам тээврийн осол, гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэндээр хохирсон хүн, учирсан хохирол

2024 онд зам тээврийн 30977 осолд 4493 хүн өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байна. Зам тээврийн осолд өртөж, хохирсон 4493 хүний 631 буюу 14.0% нь амь нас, 3862 буюу 86.0% нь гэмтэл, бэртэл авч эрүүл мэндээр хохирсон байна.

Хүснэгт 30. Зам тээврийн ослын улмаас учирсан хохирол

Өртсөн хүн			Амь эрсэдсэн хүн			Гэмтэж, бэртсэн хүн		
Улс	Нийслэл	Орон нутаг	Улс	Нийслэл	Орон нутаг	Улс	Нийслэл	Орон нутаг
4493	2946	1547	631	131	500	3862	2815	1047

Амь нас, эрүүл мэндээр хохирсон 4493 хүний 2946 буюу 65.6% нь нийслэлд, 1547 буюу 34.4% нь орон нутгийн замд бүртгэгдсэн ослын улмаас хохирсон байна. Зам тээврийн осолд өртөж хохирсон хүн нь өмнөх оны мөн үеэс 27.6%-иар өсжээ.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 3167 гэмт хэргийн улмаас 1710 хүн хохирсны 358 буюу 20.9% нь амь эрсэдсэн, 1352 буюу 79.1% нь хүнд, хүндэвтэр хохирол учирсан.

Өртсөн хүн			Амь эрсэдсэн хүн			Гэмтэж, бэртсэн хүн		
Улс	Нийслэл	Орон нутаг	Улс	Нийслэл	Орон нутаг	Улс	Нийслэл	Орон нутаг
1710	811	899	358	82	276	1352	729	623

Улсын хэмжээнд бүх төрлийн 44673 гэмт хэргийн улмаас 991 хүн амь насаараа хохирсон нь өмнөх оны мөн үеэс 16.9%-иар өссөн харамсалтай тоон үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас амь нас хохирсон **991 хүний 358 буюу 36.1%** нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь нас нь хохирчээ.

График 18. Нас барсан хүний тоон үзүүлэлт



Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн – Зам тээврийн ослын улмаас газар дээрээ болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд /эмчлэгдэж байх явцдаа/ нас барсан хүн буюу нийт нас баралтын тоон үзүүлэлтийг авч үзсэн.

Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн– Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас боловсруулан гаргасан үзүүлэлт буюу хохирогчийн өөрийн буруутай үйлдлээс шалтгаалж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтаар хааж шийдвэрлэсэн хэргийг хасаж бусдын амь нас хохироож шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон үзүүлэлт юм.

Улсын хэмжээнд 2024 онд зам тээврийн 548 ослын улмаас 631 хүний амь нас хохирч, амь насаа алдсан 631 хүний 500 буюу 79.2% нь орон нутгийн замд, 131 буюу 20.8% нь нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн осол байна.

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон ослын 548 тохиолдол бүртгэгдэж, 631 хүний амь нас хохирсон байна. Хүний амь нас хохирсон 148 гэмт хэргийг ЭХХШТХ-ийн холбогдох зүйл заалтаар хэргийг хэрэгсэхгүй болгосон /ЦЕГ-ын статистик/ мэдээнд нас барсан хүн 358 гэсэн тоон үзүүлэлтээр тусгагдсан.

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний тоон үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад улсын хэмжээнд 14.5%, орон нутагт 11.1%, нийслэлийн хэмжээнд 29.7%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 32.Зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон тохиолдол

№	Аймаг, дүүрэг	Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон хүн			Гэмт хэргийн улмаас амь нас хохирсон хүн		
		2023 он	2024 он	Харьцуулалт	2023 он	2024 он	Харьцуулалт
1	Архангай	25	30	20.0	16	16	0
2	Баян-Өлгий	9	19	2.1 дахин	4	13	3.3 дахин
3	Баянхонгор	22	28	27.3	7	12	71.4
4	Булган	17	18	5.9	8	15	87.5
5	Говь-Алтай	11	18	63.6	6	8	33.3
6	Говьсүмбэр	7	12	71.4	5	6	20.0
7	Дархан-Уул	11	14	27.3	9	11	22.2
8	Дорноговь	28	34	21.4	13	28	2.2 дахин
9	Дорнод	21	19	-9.5	11	7	-36.4
10	Дундговь	14	8	-42.9	9	3	-66.7
11	Завхан	11	22	2 дахин	6	7	16.7
12	Орхон	5	5	0	2	6	3 дахин
13	Өвөрхангай	23	28	21.7	9	20	2.2 дахин
14	Өмнөговь	39	41	5.1	17	21	23.5
15	Сүхбаатар	16	18	12.5	8	5	-37.5
16	Сэлэнгэ	25	26	4.0	20	23	15.0
17	Төв	69	70	1.4	40	39	-2.5
18	Увс	19	16	-15.8	8	8	0
19	Ховд	21	17	-19.0	13	8	-38.5
20	Хөвсгөл	18	27	50.0	10	11	10.0
21	Хэнтий	39	30	-23.1	34	9	-73.5
Орон нутаг		450	500	11.1	255	276	8.2
22	Баянгол	7	4	-42.9	3	3	0
23	Баянзүрх	20	33	65.0	15	22	46.7
24	Сүхбаатар	13	14	7.7	6	6	0
25	Сонгинохайрхан	29	44	51.7	16	25	56.3
26	Хан-Уул	21	18	-14.3	12	15	25.0
27	Чингэлтэй	4	11	2.8 дахин	3	8	71.4
28	Багануур	2	2	0	1	0	0
29	Багахангай	0	1	0	0	0	0
30	Налайх	5	4	-20.0	1	3	3 дахин
Нийслэл		101	131	29.7	57	82	43.9
УЛС		551	631	14.5	312	358	14.7

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 358 хүн амь насаа алдаж, 1352 хүн гэмтсэн үзүүлэлтийг

өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад амь насаа алдсан хүний тоо 14.7%, гэмтсэн хүн 23.4%-иар тус тус өссөн.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бүх төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 10603 хүн гэмтсэний дотор 1352 буюу 12.8% нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн статистик үзүүлэлт гарчээ.

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн – Зам тээврийн осолд өртөж их бага, тодорхой хэмжээгээр гэмтэл, бэртэл авсан /зөөлөн эдийн гэмтэл, шарх авсан, шалбарсан, зулгарсан гэх мэт/ хүнийг багтаасан тоон үзүүлэлт юм.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн – Зам тээврийн ослын улмаас биед авсан гэмтлийн зэрэг нь шүүх эмнэлгийн магадалгаагаар хүндэвтэр, хүнд зэрэг тогтоогдон эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн улмаас гэмтсэн хүний тоон үзүүлэлт юм.


Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 3862 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 30.0%, хүнд, хүндэвтэр гэмтсэн хүн 23.4%-иар тус тус өссөн.

Хүснэгт 33. Гэмтсэн хүний тоон үзүүлэлт

Гэмтсэн хүн	Улс	Нийслэл	Орон нутаг
Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн	3862	2815	1047
Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн	1352	729	623

Нийт 3862 хүний эрүүл мэндэд хохирол учирснаас 1352 буюу 35.0% хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр хохирол учирчээ.

График 19. Гэмтсэн хүний тоон үзүүлэлт (бүс нутгаар)



Хүснэгт 34.Зам тээврийн ослын улмаас гэмтсэн тохиолдол аймаг, дүүрэг

№	Аймаг, дүүрэг	Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн			Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн		
		2023 он	2024 он	Харьцуулалт	2023 он	2024 он	Харьцуулалт
1	Архангай	45	54	20.0	23	29	26.1
2	Баян-Өлгий	20	39	95.0	7	20	3.0д
3	Баянхонгор	52	55	5.8	21	23	9.5
4	Булган	30	42	40.0	20	19	-5.0
5	Говь-Алтай	14	24	71.4	10	12	20.0
6	Говьсүмбэр	24	33	37.5	5	21	4.0д
7	Дархан-Уул	85	46	-45.9	36	33	-8.3
8	Дорноговь	61	70	14.8	35	47	34.3
9	Дорнод	56	39	-30.4	26	31	19.2
10	Дундговь	59	40	-32.2	19	15	-21.1
11	Завхан	39	53	35.9	11	19	72.7
12	Орхон	69	62	-10.1	33	30	-9.1
13	Өвөрхангай	40	34	-15.0	30	32	6.7
14	Өмнөговь	50	42	-16.0	49	39	-20.4
15	Сүхбаатар	48	28	-41.7	25	20	-20.0
16	Сэлэнгэ	85	72	-15.3	31	44	41.9
17	Төв	150	130	-13.3	82	78	-4.9
18	Увс	48	50	4.2	11	10	-9.1
19	Ховд	38	44	15.8	31	29	-6.5
20	Хөвсгөл	72	53	-26.4	30	45	50.0
21	Хэнтий	79	37	-53.2	36	27	-25.0
Орон нутаг		1164	1047	-10.1	571	623	9.1
22	Баянгол	275	427	55.3	85	102	20.0
23	Баянзүрх	451	680	50.8	121	180	48.8
24	Сүхбаатар	272	448	64.7	74	106	43.2
25	Сонгинохайрхан	331	454	37.2	84	130	54.8
26	Хан-Уул	320	478	49.4	94	122	29.8
27	Чингэлтэй	194	268	38.1	45	71	57.8
28	Багануур	27	16	-40.7	10	4	-60.0
29	Багахангай	5	7	40.0	3	1	-66.7
30	Налайх	20	37	85.0	9	13	44.4
Нийслэл		1895	2815	48.5	525	729	38.9
УЛС		3059	3862	26.3	1096	1352	23.4

Зураг 1.Зам тээврийн осолд өртөж хохирсон хүмүүсийн насны байдал




График 20.Гэмт хэрэгт өртөн гэмтэж хохирсон хүмүүсийн хүйс






График 21.Гэмт хэрэгт өртөн амь нас хохирсон хүмүүсийн хүйс



Нас, хүйсийн үзүүлэлтээс дүгнэхэд 36-54 насны эрэгтэй хүмүүс зам тээврийн осолд өртөж, амь нас, эрүүл мэндээр хохирох нь их байна.

График 22.Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний гэмтлийн зэрэг



Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас гэмтсэн 3862 хүний гэмтлийн зэрэг:


- Гэмтлийн зэрэг тогтоогдоогүй /Бага зэрэг гэмтэл авсан/ 2510 буюу 65.0%
- Хөнгөн гэмтэл 75 буюу 1.9%,
- **Хүндэвтэр гэмтэл** 983 буюу 25.5 %,
- Хүнд гэмтэл 294 буюу 7.6% нь байна.

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний 65.0% нь зөөлөн эдийн гэмтэл, бэртэл, шалбарсан, зулгарсан зэрэг амь насанд аюул багатай гэмтэл авсан байна.

Зураг 2.Ослын улмаас хохирогчийн биед учирсан гэмтлийн байдал


Зам тээврийн ослын үед амь насаа алдсан болон хүнд зэргийн гэмтэл авсан хөдөлгөөнд оролцогчдын дийлэнх хувь нь толгой, цээж, аарцаг нуруундаа гэмтэл авсан бол хөнгөн зэргийн гэмтэл авч хохирсон хүмүүс хүзүү, хөл, гар, тулгуур эрхтний гэмтэл, бэртэл авдаг байна.

Амь нас хохирсон хүмүүсийн 41.5% нь толгойдоо /суурь ясны гэмтэл/, 16.6% нь цээжиндээ, 7.8% нь олон тооны хавсарсан гэмтлийн улмаас амь нас хохирсон байна.



Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон 631 хүний 95.6% нь газар дээрээ болон 24 цагийн дотор, 4.4% нь 30 хоногт болон түүнээс дээш хоногт амь нас хохирсон байна.

Зураг 3.Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон мэдээлэл



Зам тээврийн осолд өртөж амь нас хохирсон 631 хүний 6.3% нь осолд өртсөн даруйд эмнэлгийн анхны тусламж авсан бол 93.7% буюу 591 хүн нь анхны тусламж авч чадаагүй гэсэн мэдээлэл байна. Иймд эмнэлгийн анхны тусламжийн үйлчилгээ хангалтгүй байгааг харуулж байна. Эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг түргэн шуурхай болгосноор зам тээврийн осолд өртөж нас барах тохиолдол багасаж, эрдэнэт хүний алтан амь насыг аврах ач холбогдолтой.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед үйлдэгдсэн зам тээврийн осол, учирсан хохирол

Улсын хэмжээнд 2024 онд жолооч архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс зам тээврийн 1479 осол үйлдэгдэж, явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцохдоо зам тээврийн осолд өртөж хохирсон осол 163 бүртгэгдсэн.


2024 онд бүртгэгдсэн нийт зам тээврийн осол буурсан ч согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын гаралт 6.6%-иар өссөн.

Хүснэгт 35.Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын нөхцөл байдал

№	Зам тээврийн осол	Нийт осолд эзлэх хувь	Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсон	Нийт осолд эзлэх хувь
УЛСЫН ХЭМЖЭЭНД				
1	1824	6.6	97	0.7
Улаанбаатар				
2	1162	4.8	79	0.7
Орон нутаг				
3	662	17.2	18	0.8


Согтуугаар үйлдсэн зам тээврийн ослын 1162 буюу 63.7% нь Улаанбаатарт, 662 буюу 36.3% нь орон нутагт бүртгэгдсэнээс гадна орон нутагт бүртгэгдсэн нийт ослын 4.5% нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос гарчээ.

График 23.Согтуугаар үйлдэгдсэн ослын нөхцөл байдал



Орон нутагт Сэлэнгэ, Хэнтий, Баянхонгор аймагт согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол их бүртгэгдсэн.

График 24. Согтуугаар үйлдэгдсэн ослын нөхцөл байдал




Нийслэлийн Хан-Уул, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол их бүртгэгдсэн байна.

Согтууруулах ундаа хэрэглэснээс 1824 зам тээврийн осол бүртгэгдэж, түүний улмаас 156 хүн амь эрсдэж, 233 хүн гэмтэл авч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2 тэрбум 279 сая төгрөгийн хохирол учирсан.

Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн осол 68.6%-иар өссөн ч хүний амь нас хохирсон тохиолдол 10.2%-иар буурсан үзүүлэлттэй байна.


Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас хохирсон 389 хүний насны байдлыг авч үзвэл: 0-17 насны 32 хүн 8.7%, 18-35 насны 102 хүн 26.2%, 36-54 насны 190 хүн 48.8%, 55-аас дээш насны 63 хүн 16.2%-ийг эзэлж байна. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас 117 эмэгтэй (30.1%), 272 эрэгтэй (69.9%) хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ.

График 25. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон байдал



Нийслэлийн замд согтуугаар үйлдсэн зам тээврийн ослын улмаас Сонгинохайрхан 8, Баянзүрх 6, Сүхбаатар 2, Чингэлтэй, Налайх дүүрэгт тус бүр 1 хүний амь нас хохирсон.

График 26. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон байдал



Орон нутгийн замд согтуугаар үйлдсэн зам тээврийн ослын улмаас Өмнөговь аймагт 16, Төв аймагт 12, Архангай, Баянхонгор аймагт тус бүр 11 хүний амь нас хохирсон.

Хүснэгт 36. Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас учирсан хохирол

№	Насны байдал								Хүйсийн байдал			
	Нас барсан хүн				Гэмтсэн хүн				Нас барсан хүн		Гэмтсэн хүн	
	0-17 нас	18-35 нас	36-54 нас	55-аас дээш	0-17 нас	18-35 нас	36-54 нас	55-аас дээш	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
Улсын хэмжээнд												
1	7	41	82	26	27	61	108	37	29	127	88	145
Улаанбаатар												
2	0	12	8	4	13	30	39	13	7	17	42	53
Орон нутаг												
3	7	29	74	22	14	31	69	24	22	110	46	92

Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон хүний 38 нь явган зорчигч, 55 нь тээврийн хэрэгслээр зорчигч, 63 жолооч байна.

График 27. Хүний амь нас хохирсон ослын хэлбэр



График 28.Ослын тоо жил, сараар




Согтуугаар үйлдэгдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон тохиолдол 6-10 сард их бүртгэгджээ.

Хүснэгт 37.Замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

№	Амь насаа алдсан хүн			Гэмтсэн хүн		
	Явган зорчигч	Зорчигч	Жолооч	Явган зорчигч	Зорчигч	Жолооч
Улсын хэмжээнд						
1	38	55	63	58	114	61
Улаанбаатар						
2	12	6	6	44	26	25
Орон нутаг						
3	26	49	57	14	88	36

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос орон нутагт 79 хүн, нийслэлд 27 хүний амь нас хохирсон бол орон нутгийн замд бүртгэгдсэн ослын улмаас Өмнөговь аймаг болон Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хүний амь нас хохирсон осол их бүртгэгджээ. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос орон нутагт 79, нийслэлд 27 хүний амь нас хохирсон тохиолдол бүртгэгдсэн байна.

График 29.Согтуугаар үйлдсэн ослын улмаас хүний амь нас хохирсон тохиолдол



Согтууруулах ундаа хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодох нь жолооч хурд хэтрүүлэх, гэрэл дохио болон өөдөөс ирэх саадыг анзаарахгүй, зогсоох арга хэмжээ авч чадахгүй, анхаарал төвлөрөхгүй байх зэргээр жолоочийн самбаачлах хугацаа болон өөрийгөө хянах чадварт муугаар нөлөөлж, ноцтой зам тээврийн осол гарах үндэс болдог байна.

Согтууруулах ундаа нь автомашин жолоодож буй хүний оюун ухаан, жолоодох ур чадвар, самбаачлах хугацаа, оюун санаанд шууд нөлөөлдөг учраас согтолт их байх тусам эрсдэл нь өндөр байдаг байна.

Согтуугаар үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

Улсын хэмжээнд согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2024 онд 1892 бүртгэгдсэнийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 7.3 дахин, орон нутагт 7.7 дахин, нийслэлд 9.9 дахин тус тус өссөн байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өссөн нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиас шалтгаалан гэмт хэргийн гаралт бус тоо мэдээнд нөлөөлсөн.

Тухайлбал, Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн шинжтэй үйлдэл нь тус хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр гэмт хэргийн шинжийг агуулж, Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд заалт болон нэмэгдсэн.

Хүснэгт 38.Согтуугаар үйлдсэн гэмт хэргийн учирсан хохирол, тоон үзүүлэлт

№	Аймаг, дүүрэг	Гарсан Гэмт хэрэг			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
		2023 он	2024 он	Харьцуулалт	2023 он	2024 он	Харьцуулалт	2023 он	2024 он	Харьцуулалт
1	Архангай	7	47	6.7 дахин	3	5	66.7	4	5	25.0
2	Баян-Өлгий	1	36	36 дахин		4		1	5	5 дахин
3	Баянхонгор	4	56	14 дахин	1	4		3	5	66.7
4	Булган	4	46	11.5 дахин	3	1	-66.7	1	5	5 дахин
5	Говь-Алтай	2	64	32 дахин		1		2	4	2 дахин
6	Говьсүмбэр	3	31	10.3 дахин	2			1	2	2 дахин
7	Дархан-Уул	5	81	16.2 дахин	2	4		3	2	-33.3
8	Дорноговь	11	79	7.2 дахин	5	2	-60.0	8	7	-12.5
9	Дорнод	11	65	5.9 дахин	5	2		7	6	-14.3
10	Дундговь	3	32	10.7 дахин	1	2		3	1	-66.7
11	Завхан	4	36	9 дахин	2	4	2 дахин	4	5	25.0
12	Орхон	10	65	6.5 дахин				10	4	-60.0
13	Өвөрхангай	10	126	12.6 дахин	4	4	0.0	9	12	33.3
14	Өмнөговь	17	105	6.2 дахин	7	8	14.3	15	12	-20.0
15	Сүхбаатар	8	68	8.5 дахин	2	2	0.0	7	7	0.0
16	Сэлэнгэ	12	69	5.8 дахин	5	4	-20.0	12	9	-25.0
17	Төв	12	76	6.3 дахин	3	6	2 дахин	10	12	20.0
18	Увс	6	52	8.7 дахин	3	3	0.0	3	5	66.7
19	Ховд	15	57	3.8 дахин	7	3	-57.1	14	7	-50.0
20	Хөвсгөл	11	79	7.2 дахин	2	4	2 дахин	10	12	20.0
21	Хэнтий	16	58	3.6 дахин	14	2	-85.7	15	11	-26.7

Орон нутаг	1164	172	1328	7.7 дахин	71	65	-8.5	142	138
22 Баянгол	7	90	12.9 дахин				9	14	55.6
23 Баянзүрх	8	120	15 дахин	3	4	33.3	6	20	3.3 дахин
24 Сүхбаатар	5	65	13 дахин				5	15	3 дахин
25 Сонгинохайрхан	19	102	5.4 дахин	5	3	-40.0	14	18	28.6
26 Хан-Уул	10	72	7.2 дахин	2	3	-50.0	6	16	2.7 дахин
27 Чингэлтэй		87			2		0	9	
28 Багануур	4	16	4 дахин	1			3	1	-66.7
29 Багахангай		4							
30 Налайх	4	8	9.9 дахин				4	2	-50.0
Нийслэл		57	564	7.3 дахин	11	12	9.1	47	95
УЛС		229	1892	9 дахин	82	77	-6.1	189	233

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг өссөн хэдий ч нас баралт 6.1% буурсан байна.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил


2024 онд улсын хэмжээнд согтууруулах ундааны зүйл хэрэглэж замын хөдөлгөөнд оролцсон 28155 зөрчил илрүүлсэн байна. 10738 буюу 38.1% нийслэл хотод, 17414 буюу 61.9% нь орон нутгийн замд гарсан зөрчил байна.

Хүснэгт 39. Илрүүлсэн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил

№	Улс	Нийслэл	Орон нутаг
	Нийт		
1	43146	10738	13632
Эрхийн үнэмлэхтэй үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон			
2	22975	9343	13632
Эрхээ хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон			
3	2150	652	1498
Эрхээ хасуулсан, үнэмлэхийн хугацаа дууссан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон			
4	3030	743	2287
2023 онд буурсан байдал			
5	-1343	-769	-544


Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 7 хүүхэд бүртгэгдсэн байна.

График 30. Согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил (нийслэлд)



Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт зөрчлийн илрүүлэлт бусад дүүргээс их байна.

График 31.Согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил (орон нутагт)



Орон нутагт Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь аймагт зөрчлийн илрүүлэлт бусад аймгаас их байна.

Хүснэгт 40.Зөрчилд авсан захиргааны арга хэмжээ

Он	Эрх хассан			Баривчилсан		
	Улс	Нийслэл	Орон нутаг	Улс	Нийслэл	Орон нутаг
2024	20072	6222	13850	5152	2374	2775
2023	33691	17487	16204	8303	2409	5894
Харьцуулалт	-40.4	-64.4	-14.5	-38	-1.5	-52.9

Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Улсын хэмжээнд 2024 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 1230 бүргэгдсэний 842 буюу 68.5% нь нийслэлд, 388 буюу 31.5% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Хүснэгт 41.Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Хүүхэд өртсөн зам тээврийн осол	Нийт хохирсон хүүхэд	Амь эрсэдсэн хүн, хүүхэд	Гэмтсэн хүүхэд
	Улсын хэмжээнд		
1230	1377	69	1308
	Улаанбаатар		
842	927	11	916
	Орон нутаг		
388	450	58	392

Эндээс үзэхэд өнгөрсөн онтой харьцуулахад улсын хэмжээнд 45.4%, нийслэлд 78.0%, орон нутаг 4.0%-иар тус тус өссөн.

График 32.Хүүхэд өртсөн зам тээврийн осол (нийслэлд)





График 33.Хүүхэд өртсөн зам тээврийн осол (орон нутагт)



Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон, гэмтсэн хүүхэд

Зам тээврийн ослын улмаас 69 хүүхэд амь нас хохирсон, 1308 хүүхэд гэмтсэн, 239 хүүхэд хүнд, хүндэвтэр гэмтэл авсан байна.


Хүснэгт 42.Хүүхэд өртсөн зам тээврийн ослын гэмтэл

№	Аймаг, дүүрэг	Нас барсан хүүхэд			Гэмтсэн хүүхэд		
		2023 он	2024 он	Харьцуулалт	2023 он	2024 он	Харьцуулалт
1	Архангай	4	3	-25	17	17	0
2	Баян-Өлгий	1	8	8 дахин	8	13	62.5
3	Баянхонгор	1	3	3 дахин	16	13	-18.8
4	Булган	1	4	4 дахин	17	15	-11.8
5	Говь-Алтай	1	5	5 дахин	6	3	-50
6	Говьсүмбэр	0	0	0	5	2	-60
7	Дархан-Уул	0	1	0	37	40	8.1

8	Дорноговь	2	5	2.5 дахин	20	27	35
9	Дорнод	1	1	0	19	24	26.3
10	Дундговь	1	0	0	9	8	-11.1
11	Завхан	3	1	66.7	13	13	
12	Орхон	0	0	0	27	29	7.4
13	Өвөрхангай	2	2	0	13	15	15.4
14	Өмнөговь	1	3	3 дахин	15	11	-26.7
15	Сүхбаатар	6	2	-66.7	23	18	-21.7
16	Сэлэнгэ	2	4	2 дахин	23	35	52.2
17	Төв	8	3	-62.5	24	33	37.5
18	Увс	2	2	0	26	7	-73.1
19	Ховд	3	1	-66.7	29	37	27.6
20	Хөвсгөл	3	6	2 дахин	14	17	21.4
21	Хэнтий	8	4	-50	34	15	-55.9
Орон нутаг		1164	50	58	16	395	392
22	Баянгол				73	153	2.1 дахин
23	Баянзүрх		2		117	210	79.5
24	Сүхбаатар				71	129	81.7
25	Сонгинохайрхан	3	4	33.3	93	141	51.6
26	Хан-Уул		1		91	174	91.2
27	Чингэлтэй		2		44	90	2 дахин
28	Багануур		2		4	7	75.0
29	Багахангай				2		
30	Налайх				10	12	20.0
Нийслэл		1895	3	11	3.7 дахин	505	916
УЛС		3059	53	69	30.2	900	1308

Хүүхэд өртсөн зам тээврийн ослын шалтгаан

График 34.Осолд өртсөн хэлбэр



Хүснэгт 43.Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн нас

№	Насны байдал		
	0-7 нас	8-14 нас	15-17 нас
Улсын хэмжээнд			
1	377	598	402
Орон нутагт			
2	176	178	96
Нийслэлд			
3	201	420	306

Хүснэгт 44.Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

Үзүүлэлт	Явган зорчигч	Зорчигч	Дугуйгаар зорчигч	Бусад жолооч
Нийслэл				
Тоон үзүүлэлт	586	125	100	116
Орон нутаг				
Тоон үзүүлэлт	226	192	19	13
Улс				
Тоон үзүүлэлт	812	317	119	129

Улс, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаан, нөхцөл

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 30977 зам тээврийн ослын 30098 буюу 97.2% нь жолоочийн буруугаас, 759 буюу 2.5% нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 120 буюу 0.4% нь замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан гэж бүртгэгджээ.

Хүснэгт 45.Зам тээврийн ослын шалтгаан

Он	Харьяалал	Жолоочийн буруугаас	Замын нөхцөлөөс	Явган зорчигчийн буруугаас
2024	Улсын хэмжээнд			
	Нийт ослын тоо	30098	120	759
	Нийт осолд эзлэх хувь	97.2	0.4	2.5
	Улаанбаатарт			
	Нийт ослын тоо	25308	86	662
	Нийт осолд эзлэх хувь	84.1	71.6	87.2
	Орон нутагт			
	Нийт ослын тоо	4790	34	97
	Нийт осолд эзлэх хувь	15.9	28.3	12.8

Зам тээврийн осол гарсан шалтгааныг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад: жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол өмнөх оноос 5524 (22.5%) нэгжээр, явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 184 (32.0%) нэгжээр, замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол 14 (13.2%) нэгжээр тус тус өссөн байна.

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол

Бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааны 97.2% нь жолоочийн буруутай үйлдлээс үйлдэгдсэн тоон үзүүлэлттэй үр дүн гарсан байна.

Жолоочийн буруутай ослын шалтгаанаас:

- Хажуу хоорондын зай тохируулаагүйгээс (9919)
- Уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн (3368)
- Эгнээ байр буруу эзэлсэн (2603)
- Ухрах үйлдэл буруу хийсэн (2202)

Хүснэгт 46.Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Үзүүлэлт	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	Хурд хэтрүүлсэн	Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	Анхаарал болгоомжгүй	Зогсоох арга хэмжээ аваагүй	Уулзвар нэвтрэх	Гэрэл дохио	Эргэх үйлдэл	Зай тохируулаагүй	Гүйцэж түрүүлэх	Эсрэг урсгал	Эгнээ байр	Хүн ба тээвэрлэх журам зөрчсөн	Ухрах
Нийслэл														
Тоон үзүүлэлт	1824	1232	272	5092	1394	3368	208	532	9919	244	292	2603	56	1737
Орон нутаг														
Тоон үзүүлэлт	1162	932	45	4244	756	2901	169	397	9507	91	92	2411	40	2024
Улс														
Тоон үзүүлэлт	662	300	227	848	638	467	39	135	412	153	200	192	16	178

Нийслэлд бүртгэгдсэн 26056 зам тээврийн ослын 25308 буюу 97.1%, орон нутагт бүртгэгдсэн 4921 зам тээврийн ослын 4790 буюу 97.3% нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 759 бүртгэгдсэн нь нийт ослын 2.5 хувийг эзэлж байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан ослын 662 буюу 87.2% нь нийслэлд, 97 буюу 12.8% нь орон нутагт бүртгэгдсэн.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 61 буюу 8.0% нь явган хүний буруугаас 62 буюу 8.2% нь дугуйтай хүний буруугаас, 144 буюу 19.0% нь явган зорчигч явган хүний гарц гарамтай хэсгийн гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарсан, 176 буюу 23.2% нь явган зорчигч гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарсан, 72 буюу 9.5% нь ойртон ирсэн тээврийн хэрэгслийн урдуур гүйсэн, 97 буюу 12.8% нь явган зорчигч согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцож, 147 буюу 19.4% нь сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулсан осол эзэлж байна.

Явган ба дугуйтай хүний буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол


Хүснэгт 47.Явган зорчигч ба дугуйтай хүний буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Төв, орон нутаг	Явган хүний буруугаас	Дугуйтай хүний буруугаас	Явган зорчигч явган хүний гарц гарамтай хэсгийн гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарсан	Явган зорчигч гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарсан	Ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур гүйсэн	Явган зорчигч согтуугаар	Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр хөдөлгөөнд оролцуулсан
Нийслэл	36	54	137	150	65	79	141
Орон нутаг	25	8	7	26	7	18	6
Улс	61	62	144	176	72	97	147

Явган зорчигч согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцож хохирсон 97 осол бүртгэгдсэний 79 буюу 81.4% нь нийслэлд, 18 буюу 18.6% нь орон нутагт бүртгэгдсэн.

Явган ба дугуйтай хүний буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол

График 35. Явган болон дугуйтай хүнээс шалтгаалсан зам тээврийн осол



Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол

Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол 120 бүртгэгдсэн нь нийт ослын 0.4%-ийг эзэлж байна. Дээрх бүртгэгдсэн ослын 86 буюу 71.6% нь нийслэлд, 34 28.3% нь орон нутагт тус тус бүртгэгдсэн.

Хүснэгт 48. Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол

Үзүүлэлт	Замын гэрэлтүүлэг хангалтгүй	Замын эвдрэл гэмтэл, бохирдлоос	Замын тэмдэг тэмдэглэл ойлогмжгүй, байхгүй байснаас	Замын гадаргуу халтиргаа, гулгаатай байснаас	Техникийн гэмтэл	Замын нөхцөл
Нийслэл						
Тоон үзүүлэлт	8	0	51	1	2	24
Орон нутаг						
Тоон үзүүлэлт	1	6	2	15	4	6
Улс						
Тоон үзүүлэлт	9	6	53	16	6	30

Зам тээврийн ослын хэлбэр


Бүртгэгдсэн зам тээврийн ослын 1123 буюу 3.6% нь онхолдох, 25468 буюу 82.2% нь мөргөлдөх, 2297 буюу 7.4% нь явган зорчигч мөргөх, 228 буюу 0.7% дугуйтай зорчигч мөргөх, 1367 буюу 4.4% нь үл хөдлөх зүйл мөргөх, 55 буюу 0.2% нь зорчигч унагах, 344 буюу 1.1% нь мал, амьтан мөргөх, 95 буюу 0.3% нь бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 49.Зам тээврийн ослын хэлбэрийн тоон үзүүлэлт

Үзүүлэлт	Онхолдох	Мөргөлдөх	Явган хүн мөргөх	Дугуйтай зорчигч мөргөх	Үл хөдлөх зүйл мөргөсөн	Зорчигч унагасан	Мал, амьтан мөргөх	Бусад
Нийслэл								
Тоон үзүүлэлт	110	22760	1812	197	1060	47	58	12
Орон нутаг								
Тоон үзүүлэлт	1013	2708	485	31	307	8	286	83
Улс								
Тоон үзүүлэлт	1123	25468	2297	228	1367	55	344	95

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын хэлбэрийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад

График 36.Явган болон дугуйтай хүнээс шалтгаалсан зам тээврийн осол



Хүснэгт 50.Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол

Зам тээврийн ослын хэлбэр									
№	Төв, орон нутаг	Онхолдох	Мөргөлдөх	Явган хүн мөргөх	Дугуйтай зорчигч мөргөх	Үл хөдлөх зүйл мөргөсөн	Зорчигч унагасан	Мал, амьтан мөргөх	Бусад
1	Архангай	34	44	14	0	1	0	2	1
2	Баян-Өлгий	25	88	25	1	13	0	4	1
3	Баянхонгор	55	140	40	1	7	2	2	0
4	Булган	41	112	13	0	9	0	25	1
5	Говь-Алтай	19	25	10	1	1	2	4	1
6	Говьсүмбэр	10	55	3	1	4	0	3	3
7	Дархан-Уул	24	97	49	4	14	0	6	2
8	Дорноговь	49	151	16	0	16	0	2	11
9	Дорнод	36	63	47	3	8	1	5	2

10	Дундговь	48	49	9	1	5	0	9	2
11	Завхан	46	29	7	1	10	1	6	1
12	Орхон	25	291	48	7	19	0	3	7
13	Өвөрхангай	29	112	13	1	5	0	17	1
14	Өмнөговь	150	320	1	0	29	0	7	3
15	Сүхбаатар	34	74	23	2	10	0	8	6
16	Сэлэнгэ	75	292	29	4	33	1	61	6
17	Төв	122	343	27	1	23	0	79	11
18	Увс	30	41	17	2	17	0	4	1
19	Ховд	64	129	45	0	31	0	17	14
20	Хөвсгөл	30	69	25	0	13	1	0	2
21	Хэнтий	67	174	24	1	39	0	22	7
Орон нутаг		1013	2708	485	31	307	8	286	83
1	Баянгол	4	4037	302	40	129	4	1	1
2	Баянзүрх	14	5666	467	46	281	14	14	0
3	Сүхбаатар	8	3085	260	34	155	6	0	4
4	Сонгинохайрхан	34	4077	296	19	216	10	23	2
5	Хан-Уул	26	4192	254	39	157	7	9	1
6	Чингэлтэй	2	1503	206	15	95	6	2	3
7	Багануур	7	26	13	4	9	0	4	0
8	Багахангай	4	7	0	0	6	0	2	1
9	Налайх	11	167	14	0	12	0	3	0
Нийслэл		110	22760	1812	197	1060	47	58	12

7. Эрүүлжүүлэгдсэн хүн

2024 онд улсын хэмжээнд 7710 хүн эрүүлжүүлж, 37354 хүнийг саатуулсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлсэн хүн 6446 буюу 45.5%-иар, саатуулсан хүн 705 буюу 1.9%-иар тус тус буурсан байна.

8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил

Цагдаагийн байгууллага нь 2024 онд Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, улсын хэмжээнд зохион байгуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүй, удирдлагаар ханган, үр дүнг тооцож ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх алба нь гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, дэвшилтэд техник технологи инновацыг нэвтрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх,

хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/250 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг”-ийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/48 дугаар тушаалаар Тэргүүн дэд даргаар ахлуулсан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг судалгаа дүн шинжилгээнд суурилан эрчимжүүлэх, төрөл мэргэжлийн албадын уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий “Бодлогын зөвлөл”-ийг байгуулсан.

Бодлогын зөвлөл 2024 онд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр 12 бүлэг, 105 тусгайлсан ажил, арга хэмжээг төлөвлөн, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.

Монгол Улсын согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор цахим орчинд согтууруулах ундаа дуудлагаар худалдан борлуулдаг иргэдийн зөрчлийг таслан зогсоож, цахим хаягийг устгуулах, иргэд олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор “Цахим-Архи худалдаа” тусгай арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаатай улсын хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээний эхний 28 хоногт цахим орчинд согтууруулах ундаа дуудлагаар худалдаалах зар нийтэлсэн 96 фейсбүүк хаяг, худалдан борлуулах зорилгоор нээсэн зарын 74 группийн судалгааг гаргаж дүүргийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хуваарилан хүргүүлж хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулснаар нийт 237 зөрчил илрүүлж, 5121 ширхэг согтууруулах ундааг хураан, шалгалтын ажиллагааг явуулсан.

Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хооронд замын нөхцөл байдал, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 48, цаг агаарын мэдээ, хоол болон архины хордлогоос урьдчилан сэргийлэх, хуурамч архи худалдан борлуулах болон худалдан авахаас урьдчилан сэргийлэх, ахуйн осол гэмтэл, гал түймэр, хулгайлах гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, хамтран ажиллах чиглэлээр нийт 77 контент бэлтгэж, иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэн, нэгдсэн төлөвлөлтийг мөрдөж, илрүүлэлт шийдвэрлэлтийг ахиулахын зэрэгцээ гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн ажил, арга хэмжээний саналыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдээс авч нэгтгэн Цагдаагийн байгууллагаас 2024 онд зохион байгуулж хэрэгжүүлэх тусгай-15, хэсэгчилсэн-441 ажил, арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө, хуваарь, “Мэдээлэл, ажлын чиглэл”-ийг боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 18/244 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудад хүргүүлж энэ онд улсын хэмжээнд 4 аян, нэгдсэн 11, хэсэгчилсэн 921 нийт 936 арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Эрүүл монгол хүн” хөдөлгөөн, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл



ажиллагааг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр хамтран зохион байгуулсан "Та татгалз" арга хэмжээний мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд үндсэн 35 видео шторк, 29 зурагт постер, 16 дэмжих видеог мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүтээж, цахим орчинд байршуулахад давхардсан тоогоор 102.932 хүнд таалагдаж, 114.371 хүн бусадтай хуваалцаж, 10.452.436 цахим хэрэглэгчдэд хүрсэн.

Иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ухамсар хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсээс Хэвлэл мэдээллийн төвийн цахим пэйжид 2024 оны 1 дүгээр улиралд "Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье", "Хиймэл оюун ухааны талаар таны мэдэхгүй зүйлс", "Та цахим худалдан авалт хийдэг үү", "Хуулийн нэмэлт өөрчлөлт", "Жолооч таны анхааралд", "Хуулийн зохицуулалт", "Хүүхдийг ахуйн хүрээний осол гэмтлээс сэргийлээрэй", "Танихгүй хүнээс найзын хүсэлт ирвэл яах ёстой бэ" "Таны хүүхдэд хэнээс найзын хүсэлт ирж байгаа бэ?", "Z үеийн залуучууд", "Архи согтууруулах ундааны хэрэглээнээс татгалзаарай", "Та хүүхдээ цахим орчинд хэнтэй найз гэдгийг мэдэх үү", "Иргэн та Жолоодох эрхээ хасуулсан үедээ...", "Хууль бус үйлдэл", "Идээний дээж нэртэй ч ...", "Педофил", "Цахим мөрийтэй тоглоом" "Хуурамч хаяг", "Анхаар", "Зөрчлийн тухайн хуулийн нэмэлт өөрчлөлт", "Хором бүр үнэ цэнтэй", "Автомашинь торгууль", "Хүүхэд бол толь", "Хувийн мэдээллээ нууцалъя", "Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг", "Худал мэдээлэл тараах", "Үе тэнгийн дээрэлхэл болон асран хамгаалагчдын хараа хяналтыг сайжруулах", "Хүний эрүүл мэнд, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг", "Замын хөдөлгөөнд соёлтой оролцох", "Мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл", "Шар усны үер", Цас ихээр орсонтой холбогдуулан замын хөдөлгөөнд оролцож буй жолоочдын аюулгүй байдлаа хангаж, анхаарал болгоомжтой явах" зэрэг нэртэй постер 23, видео 46, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах мэдээлэл 2, урьдчилан сэргийлэх ажил мэргэжлийн онцлог сэдвээр 1 нийт 72 мэдээллийг бэлтгэн түгээсэн нь 74,341 хүнд таалагдаж, 5279 хүн сэтгэгдэл үлдээж, 71,334 хүн бусадтай хуваалцаж нийт 5,843,988 цахим хэрэглэгчдэд хүрсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Согтууруулах ундааны эргэлтэд хяналтад тавих, архидан согтуурахтай тэмцэх, Зөвшөөрлийн тухай хуулиуд, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/48 дугаар тушаалаар баталсан "Дүрс бичлэгийн техник хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор нутаг, дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас "Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг нийт 9.145 аж ахуйн нэгж, байгууллагын гадна, дотор суурилуулсан теле-хяналтын камеруудын стандарт, шаардлага хангасан эсэхийг шалгахад 7.151 аж ахуйн нэгжийн камер Монгол Улсын стандарт MNS 6423:2019 "Теле-хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага"-ыг бүрэн хангасан, 1.994 аж ахуйн нэгжийн камер шаардлага хангаагүй тул мэдэгдэл, шаардлага хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон.

Иргэн, хуулийн этгээдийг залилах гэмт хэрэгт өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд цахим орчинд үйлдэгддэг залилах гэмт хэргийн онцлог, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх арга зам, хуурамч цахим хаяг, цахим орчны хүүхдэд үзүүлж буй сөрөг нөлөө, цахим орчны зохистой хэрэглээний талаар зурагт постер-10, видео мэдээлэл-7, нийт 17 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан нь давхардсан тоогоор 15,795 хүнд таалагдаж, 25,264 хүн бусадтай хуваалцаж, 5985 хүн сэтгэгдэл илэрхийлж, 2,084,755 цахим хэрэглэгчдэд хүрсэн байна.

Монгол Улсын Их хурлаас нэмэлт, өөрчлөлт оруулж, баталсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийг алба хаагч, иргэд олон нийтэд сурталчлан таниулах талаар Тээврийн

цагдаагийн албаны даргын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/62 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргаар 5 бүлэг, 14 заалттайгаар төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу Тээврийн прокурорын газартай хамтран “Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг сурталчлан таниулах, түгээх” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж, алба хаагчдыг чадавхжуулах чиглэлээр 21 аймаг, 9 дүүргийн нийт 502 алба хаагчийг хамруулан сургалтыг зохион байгуулж, үйл ажиллагаанд ашиглах гарын авлагыг Цагдаагийн байгууллагын <http://system.police.gov/> сайтын гарын авлага цэсэд байршуулж, 500 ширхэг гарын авлага хэвлүүлэн үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарт тараан өгч, ажилласан.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран гудамж талбай, олон нийтийн газар зорчих, зах худалдааны төвүүдээр үйлчлүүлэх, нийтийн тээврийн автобусаар үйлчлүүлэхдээ гадуур хувцасны халаасанд гар утсаа хийхгүй байх, гар утсаа хайдаг аппилкейшныг идэвхжүүлэх, сонор сэрэмжтэй байж, эд зүйлсээ хамгаалан болзошгүй эрсдэлд өртөж, хохирохгүй байх талаар NTV, TV-8 телевизийн мэдээний цагаар сэрэмжлүүлэг мэдээллийг тус тус хүргэсэн.

Зөрчлийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох ажлын хүрээнд “Зөрчлийн хэрэг шийдвэрлэлт-2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага, хүрэх үр дүн, ач холбогдлыг тусгасан 61 дугаартай танилцуулгыг боловсруулж танилцуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах үүднээс мод тарих, ургуулах, арчлах ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчлах, соён гэгээрүүлэх зорилго бүхий “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хүн бүр мод тарьцгаая” нөлөөллийн аяныг улсын хэмжээнд 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж, үндсэн 6 видео шторк, youtube видео 8, Reels 50, Paid media контент 61, зурагт хуудас 20, пост мэдээ 15, нийт 160 контентыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран бэлтгэж, иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.

Цагдаагийн байгууллагаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран зохион байгуулсан мэдээлэл, сурталчилгааны аяны хүрээнд нийт 160 мэдээ, мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 455.597 хүнд таалагдаж, 988.154 хүн бусадтай хуваалцаж, 34.457 хүн сэтгэгдэл илэрхийлж, **22.594.989** хүнд хүрсэн хандалттай байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д аймаг, нийслэлийн Засаг даргаас Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагатай зөвшилцөн гаргасан саналыг үндэслэн аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олон нийтийн цагдаагийн тоог жил бүр тогтооно гэж заасны дагуу 5 дугаар сард улсын хэмжээнд 818 олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоо батлагдаж, нийслэлд 160, орон нутагт 273 нийт 433 олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэн ажиллаж, 2024 оны хагас жилийн байдлаар гудамж, талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулахаар цагдаагийн алба хаагчидтай хамтран эргүүл, хяналт шалгалтад 3471 удаа ажиллаж, гэмт хэрэг үйлдэгдсэн хэргийн газрын хамгаалалтад 423 удаа, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн 1,222 этгээдийг цагдаагийн байгууллага болон холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч, гэмт хэрэг зөрчлийн талаарх 1,746 мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэн бүртгэлд авхуулж, цагдаагийн алба хаагчидтай хамтран 69 гэмт хэрэг, 2900 зөрчлийг илрүүлж, таслан зогсоосон байна.



Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн аюулгүй, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх талаар “Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангахад оршино” гэж тусгагдсаны дагуу Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Ногоон бүс” төслийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 4 хоногийн хугацаанд Хэвлэл мэдээллийн төв цахим хуудсанд байршуулсан нийт 15 мэдээлэл нь 4,586 хүн дэмжиж, 274 хүн сэтгэгдэл үлдээж, 12,075 хүн бусадтай хуваалцаж, 368,791 хүн үзсэн хандалттай байна.

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 10 контент, видео мэдээ байршуулж ажилласан нь нийт 14512 таалагдсан, 4905 түгээсэн, 705 сэтгэгдэл үлдээсэн, 1.286.200 хандалт авсан байна.

Цагдаагийн байгууллагын дуудлага, мэдээллийн “ECS” программд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй нийт 33,857 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнээс 5,106 нь хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн шинжтэй дуудлага бүртгэгдсэн байна.

Үүнээс гомдол, мэдээллийн бүртгэлд 29,613 буюу 87.5% хувийг хүлээн авч, эргэн шалгах шаардлагатай 4,043 буюу 11.9% хувь, ар гэрт нь хүлээлгэн өгсөн 129, гэмт хэрэг зөрчлийн шинжгүй 1,332, давхардсан мэдээлэл 1,952, зөрчлийн хуулиар торгосон 906, харьяаллын дагуу шилжүүлсэн 44, эрүүлжүүлэх саатуулах байранд хүргэсэн 147, 103-т 12 иргэн хүлээлгэн өгч, 1,838 хохирогч, 2,086 хүчирхийлэгчийн давтамжийг илрүүлэн эрх бүхий алба хаагчид, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран нэг бүрчилсэн хяналт тавин ажилласнаар Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,169 нэгж буюу 8.6% хувь буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоод цэргийн командлагчид танилцуулсан “Бүгд Найрамдах Солонгос улсын Тэжон хотод зохион байгуулагдсан Олон Улсын семинарт оролцсон тухай” 776 дугаар танилцуулгад дурдагдсан саналд Тэжон хотын захиргааны дэргэдэх Судалгаа, дүн шинжилгээний төвийн жишгээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн дэргэд зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчилд хүүхэд өртөж, хохирсон нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хотын хөгжлийн бодлогод уялдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгж ажиллуулах талаар Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран судалгааг хийж, ажилласан.

Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн судалгааг гарган нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдад гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бууруулах, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах, насанд хүрээгүй хүмүүст эвээр шийдвэрлэх боломжтой асуудлыг хүчээр шийдвэрлэх болгоомжгүй үйлдлээс үүдэн өөрийн болон бусдын биед гэмтэл учруулах хор уршгийн талаар мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой Авто радио 96.3 долгиноор 7 хоног бүрийн Пүрэв гарагт газрын болон нутаг дэвсгэр хариуцсан гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэргэжилтнүүдийн хамтаар мэдээлэл хүргэж байна.



Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Албан тушаал шатлал дэвшүүлэх багц сургалтад хамруулах шалгалт авах, нөөцөд дэвшүүлэн томилох” /Код/-909, 909.4.2-т заасны дагуу ахлагч бүрэлдэхүүнээс офицер бүрэлдэхүүнд шатлан дэвших багц сургалтад хамрагдах алба хаагчдад хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий ойлголт өгөх үүргийн дагуу “Урьдчилан сэргийлэх ажил”, “Хүүхэд хамгаалал” сэдвээр Go smart платформд байршуулах 1 цагийн сургалтын бичлэг хийлгэж, суралцагч нараас авах шалгалтын тестийг боловсруулан Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд хүргүүлсэн.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар Баянгол дүүргийн 16 дугаар хороонд байрлах Төв Гандантэгчэнлин хийдэд 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр сүм хийдийн үйл ажиллагаанд тогтмол хамрагддаг хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсэгт хамтран оролцож, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр ажиллаж мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн, хяналт шалгалт хийж, дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн.

Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах цөөнгүй тохиолдол нь хурдан морины уралдаан, үсэргээ сунгааны үеэр мориноос унах, хүүхдэд эмнэг, догшин морь унуулах, хонь, малд явуулах, морь мал болон орчиндоо аюул учруулж болох амьтны аюул, эрсдэлийн талаар тайлбарлаж хэлдэггүй, эцэг эх, асран хамгаалагчийн хайхрамжгүй байдлаас шалтгаалж аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны тогтоолын хэрэгжилтийг хангаж өвөл, хаврын хурдан морины уралдаан тэмцээнийг зохион байгуулахгүй байх талаар аймаг, дүүргийн засаг дарга нартай албан бичиг хүргүүлэх, зөвшөөрөлгүй зохион байгуулагдсан уралдаан, үсэргээ, сунгаанд хүүхдээр морь унуулсан тохиолдолд Зөрчлийн хуулийн 6.20.3.3-т заасан үндэслэлээр хариуцлага тооцож, иргэдийн хүлээх үүргийг сурталчлан таниулах талаар болон Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн хохирогч хамгаалал, хууль эрх зүйн журмын хэрэгжилтийг хангуулахаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад зөвлөмж хүргүүлсэн байна.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, зохион байгуулсан, хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний үр дүнгийн талаар танилцуулга, “Хууль сахиулах үйл ажиллагаанд хүний эрх, жендерийн тэгш байдлыг дээшлүүлэх төсөл”-ийн уулзалт, хэлэлцүүлэгт тус тус саналыг нэгтгэн Хууль зүй, Дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Давтамжтай дуудлага, мэдээлэлд хяналт тавих, бүртгэл болон шийдвэрлэлтийн чанар, үр дүнг дээшлүүлэх, программын шинэчлэгдсэн хувилбарыг ашиглах аргачлал сэдвээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэлтсийн дуудлага, мэдээлэл хүлээн авч, шалган шийдвэрлэх эрх бүхий 163 алба хаагчид сургалт зохион байгуулж, удаа дараа давтамжтай дуудлага мэдээлэл өгсөн 229 иргэнд нэг бүрчилсэн хяналт тавин ажилласнаар дуудлага мэдээлэл 356 нэгж буюу 12.5% дуудлага дуудлага мэдээлэл буурсан үзүүлэлттэй байна.

“Хүүхэд хамгаалагч” төслийн 2023 оны тайлан, хүснэгтэн мэдээг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж, төслийн төсвийн мэдээллийг авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас шаардлага, шалгуур хангасан ажиллах хүсэлтэй иргэдийг судалж, гэрээ байгуулах ажлыг 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд шаардлага, шалгуур хангасан 93 иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн ба Налайх дүүрэг, Сэлэнгэ, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Орхон аймагт төсөв батлагдаагүй,



Багахангай дүүрэг, Архангай, Завхан, Булган, Дундговь аймагт уг төсөлд ажиллах шаардлага хангасан иргэн бүртгүүлээгүй байна.

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран хохирогч хүүхдэд илрэх сэтгэцийн гэмтэл, тэдэнтэй харилцах аргачлалаар алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй сэтгэцийн гэмтэлд суурилсан хандлагаар харилцах нь" сэдэвт сургалт 2024 оны 05 дугаар сарын 15-наас 17-ны өдрүүдэд зохион байгуулагдах үед "Форензик ярилцлага зохион байгуулах нь" сэдвээр сургалтыг зохион байгуулж ажилласан. Сургалтад цагдаа, прокурорын байгууллагын 50 ажилтан, алба хаагч оролцсон.

Насанд хүрээгүй хүмүүсээс ахуйн хэрэглээний шингэрүүлсэн шатдаг хий /газ/ үнэрлэн амь нас, эрүүл мэндээрээ хохирох асуудал 2024 оны эхний 6 сарын байдлаар 3 бүртгэгдсэн тул энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургуулийн сурагч, өсвөр насны хүүхдүүдэд шингэрүүлсэн шатдаг хийн хор уршгийг сурталчлан таниулах, хүний эрүүл мэнд, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, газ, цавуу, будагч бодис үнэртэх, хордохоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр 36 удаагийн сургалт, 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, нийт 2,145 сурагчийг хамруулсан.

Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан хамтран хэрэгжүүлж буй "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх" төслийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын дарга, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн суурин төлөөлөгч нар 2023-2027 оноос "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гэр бүлийн хүчирхийллийн "GBV" мэдээллийн сангийн үйл ажиллагаа, ашиглалтын чиглэлээр холбогдох байгууллагуудын уулзалтын хөтөлбөрийг боловсруулж, танилцуулсан.

Насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдүүдийн талаарх хувийн мэдээллийг агуулсан вэб хуудас нээн, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор иргэд, олон нийтэд мэдээллийг ил болгох, тухайн мэдээллийн сангийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хууль эрх зүйн зохицуулалтыг хэлэлцэх зорилгоор "Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийн хувийн мэдээллийг олон нийтэд ил байршуулах эрх зүйн зохицуулалт" сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газар, Монголын хуульчдын холбоо, НҮБ-ын Хүүхдийн сан, Азийн сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, "Хөөрхөн зүрх" төрийн бус байгууллага зэрэг төрийн болон төрийн бус, олон улсын 17 байгууллагын төлөөлөл, удирдах албан тушаалтан, алба хаагч 42 хүн оролцуулан зохион байгуулж, тус гэмт хэргийн сүүлийн 5 жилийн нөхцөл байдлын талаар танилцуулж, саналыг нэгтгэн ажиллаж байна.

Түр хамгаалах байрны үйл ажиллагааны талаар

Улсын хэмжээнд 36 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгаа ба 2024 оны 10 дугаар сарын байдлаар 2431 хүүхэд, 68 эрэгтэй, 1308 эмэгтэй, нийт 3807 иргэн тус тус бүртгэгдсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад насанд хүрсэн эрэгтэй хүн 30 буюу 30.6%-иар буурч, хүүхэд 116 буюу 5%-иар, эмэгтэй хүн 28 буюу 2.2%-иар тус тус өсөж, үйлчлүүлсэн нийт иргэдийн тоо 114 буюу 3.1%-иар өссөн байна.

Түр хамгаалах байранд тайлант хугацаанд 108 гэр бүлийн 259 иргэнийг хүлээн авч, тусламж үйлчилгээ үзүүлж, мөн ар гэр асран хамгаалагч төрийн болон төрийн бус байгууллага, хэрэг материалыг шалгасан мөрдөгчид 104 гэр бүлийн 250 үйлчлүүлэгчийг хүлээлгэн өгсөн.

“107” тусгай дугаарт ирсэн мэдээлэл, өгсөн зөвлөгөө.

Тус байрны 107 тусгай дугаарын утсанд 2024 оны байдлаар нийт 7991 иргэн хандсанаас 1333 иргэнд хуулийн болон сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, 6567 иргэнд бусад асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Сэтгэл зүйн зөвлөгөө авсан 1333 иргэний 861 нь Улаанбаатар хотоос, 372 нь хөдөө орон нутгаас холбогдсон бол хаяг тодорхойгүй 100 иргэн хандаж зөвлөгөө авсан байна.

107 тусгай дугаарын утсанд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой, цагдаагийн байгууллагаар шалгуулах шаардлага бүхий 260 дуудлага, мэдээлэл ирснээс 169 дуудлага, мэдээллийг Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 102 тусгай дугаарт, 91 дуудлага мэдээллийг аймаг орон нутгийн цагдаагийн газарт тус тус дамжуулан, шийдвэрлэлтийг авч ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой, цагдаагийн байгууллагаар шалгуулах шаардлага бүхий 127 дуудлага, мэдээллийг 102 дугаарт болон бусад цагдаагийн байгууллагад дамжуулж ажилласан.

Тус тусгай дугаарт богино зурвас (SMS), дүрст дуудлагаар мэдээлэл хүлээн авах техникийн боломжийг бүрдүүлж, утсаар ярих боломжгүй нөхцөл байдалд орсон хүүхэд, иргэдээс дуудлага хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албатай хамтран ажиллаж “Түр хамгаалах байр”-ны гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл хүлээн авах, зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх зориулалт бүхий “107” тусгай дугаарын утсанд дүрст дуудлага хийх техникийн нөхцөлийг бүрдүүлсэн.

Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд зохион байгуулагдаж буй үйл ажиллагааг сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын албан ёсны www.police.gov.mn цахим хуудаст нийт **400** мэдээ бэлтгэн байршуулсан. Дээрх мэдээлэл нь давхардсан тоогоор **3.514.778** хүний хандалттай байна.

Тус цахим хуудсны хандалтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 37.3%-иар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллагын албан ёсны “Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв” гэх нэршил бүхий фэйсбүүкт цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ-333, видео мэдээ-633 /рийл 372/, зурагт хуудас-396, 7 шууд дамжуулалт зэрэг нийт 1445 мэдээлэл бэлтгэн байршуулсан нь 1.430.684 хэрэглэгч таалагдсан, 1.012.893 хэрэглэгч бусадтай хуваалцсан, 152.751 иргэн сэтгэгдэл илэрхийлж давхардсан тоогоор 147.704.607 хэрэглэгчийн хандалттай байна.

Мөн “Х” платформд 444 мэдээ, мэдээллийг нийтэлсэн нь нийт 544.403 хэрэглэгчид хүрсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 7 хоногт шалгаж шийдвэрлэсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэл, онцлог шийдвэрлэлийн талаарх мэдээллийг видео, бичвэр, инфографик хэлбэрээр нийт 40 удаа бэлтгэн Даваа гараг бүр “Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв” цахим хуудас, www.police.gov.mn цахим хуудаст байршуулсан.

Мөн байгууллагаас иргэд, олон нийтэд хүргэх аливаа мэдээллийг мэргэжлийн сэтгүүлч, редактораар хянуулан нийтэд мэдээлэх зорилгоор хамтран ажиллах гэрээний дагуу, ажил



гүйцэтгэгчээр нийт 58 төрлийн хэргийн мэдээг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлийн 5-д заасныг баримтлан нийтэд мэдээлэх бололцоотой хэмжээнд боловсруулан, “Мэдээний өрөө”-нд нийт 41 мэдээллийг бэлтгэж, нийтэд түгээсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн “Байгууллагын үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор радио долгионы сувгаар мэдээллийг дамжуулах” үүргийн дагуу “Дэлхийн Монголчуудын радио 88.3” радио долгионоор нийт 104 төрлийн мэдээллийг 1 сарын хугацаанд хуваарьт цагуудад иргэд, олон нийтэд мэдээллийг түгээн ажилласан.

Мөн 2024 оны эхний 11 сарын байдлаар байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, алба хаагчийн алдар гавьяаг алдаршуулах зорилгоор “Бидний нэг” контентын 13 дугаар, “Ахмадын дурсамж” нэвтрүүлгийн 2 дугаар, “Удмын хэлхээ” нэвтрүүлгийн 1 дугаар зэрэг 16 төрлийн үндсэн контент, бусад 26 нийт 40 төрлийн контентыг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэсэн.

Сургалт, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/76 дугаар тушаалын “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай”-ын хүрээнд тус Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/02 дугаар тушаалаар “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай”-аар Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын 19 заалттай салбар төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангах чиглэлээр 71 удаагийн сургалтын календарчилсан төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Дээрх төлөвлөгөөний хүрээнд алба хаагчдын мэдлэг ур чадварын ахиулах, бие бялдрыг хөгжүүлэх, сахилга ёс зүйг дээшлүүлэх зорилгоор 2024 оны эхний 5 сарын байдлаар 41 удаагийн 63 цагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 3,228 алба хаагчийн хамруулсан.

Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Төрийн Департаментын хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-ний хүрээнд Азийн сантай хамтран “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт алба хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 16-19-ны өдрүүдэд Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт зохион байгуулж цагдаагийн 120 алба хаагч хамруулсан.

Дуудлага мэдээллийн бүртгэл, шийдвэрлэлтийг чанаржуулах, алдаа дутагдлыг арилгуулах чиглэлээр Хан-Уул, Баянгол дүүргийн цагдаагийн газар, Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын нэг, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн дуудлага, мэдээлэл хүлээн авах, шалган шийдвэрлэх эрх бүхий 481 алба хаагчид ECS программ хангамжийн хөгжүүлэлт давтамжтай дуудлага мэдээлэл бүртгэх, аюулын зэргийн үнэлгээ хийх, хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн дуудлага мэдээлэл шийдвэрлэх аргачлал сэдвээр сургалт зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк, Японы сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд эрхлэн гаргасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх нь” сэдэвт цагдаагийн албан хаагчдад зориулсан видео хичээлийг цагдаагийн байгууллагын сургалтын цахим системд нэг бүлэг болгон оруулж, алба хаагчдаар судлуулах ажлыг зохион байгуулсан.

--oOo--

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ПРОКУРОР - PROSECUTION

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ
АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТ
3. ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ
АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТ
4. ШҮҮХЭД ТӨРИЙГ ТӨЛӨӨЛӨХ АЖИЛ
5. ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН
ХЯНАЛТ
6. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ
7. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС АВЧ
ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ АЖИЛ, АРГА
ХЭМЖЭЭ





2024 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ



ХЭРЭГ НЭЭХЭЭС
ТАТГАЛЗСАН

63697



ХЭРЭГ
БҮРТГЭЛТИЙН
ХЭРЭГ НЭЭСЭН

41354



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ
ҮҮСГЭЖ
ЯЛЛАГДАГЧААР
ТАТСАН

14444



2024 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ



ХҮЛЭЭН
АВАХААС
ТАТГАЛЗСАН

69966



ЗӨРЧЛИЙН
ХЭРЭГ
НЭЭСЭН

57762



ХЭРЭГ
БҮРТГЭЛТИЙН
ХЭРЭГ НЭЭСЭН

2370



ХЯЛБАРШУУЛСАН
ЖУРМААР
ШАЛГАЖ
ШИЙДВЭРЛЭСЭН

129030



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ
ҮҮСГЭЖ
ЯЛЛАГДАГЧААР
ТАТСАН

47



2024 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ



НЭГТГЭСЭН

356



ХЭРЭГ
БҮРТГЭЛТИЙН
ХЭРГИЙГ ХААСАН

18285



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ
ҮҮСГЭЖ
ЯЛЛАГДАГЧААР
ТАТСАН

11912



2024 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН МӨРДӨН БАЙЦААЛТЫН ХЭРЭГ



НЭГТГЭСЭН

10632



ТҮДГЭЛЗҮҮЛСЭН

246



ЭХҮЯТ-ЫГ
ХҮЧИНГҮЙ
БОЛГОСОН

130



ХЭРЭГСЭХГҮЙ
БОЛГОСОН

631



ЯЛЛАХ
ДҮГНЭЛТ
ҮЙЛДСЭН

15969



ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ



ЭРҮҮГИЙН
ХУУЛИЙН 6.7-1.1

263



ЭРҮҮГИЙН
ХУУЛИЙН 6.7-1.2

237



ЭРҮҮГИЙН
ХУУЛИЙН 6.7-1.3

50



ЯЛААС ЧӨЛӨӨЛСӨН

50



ШҮҮХЭЭР ХЭЛЭЛЦЭГДСЭН ЭСЭРГҮҮЦЭЛ



БИЕЛСЭН
ЭСЭРГҮҮЦЭЛ

668



ХЯНАЛТЫН ШАТНЫ
ШҮҮХЭЭР
ХЭЛЭЛЦЭГДСЭН
ЭСЭРГҮҮЦЭЛ

39



ДАВЖ ЗААЛДАХ
ШАТНЫ ШҮҮХЭЭР
ХЭЛЭЛЦЭГДСЭН
ЭСЭРГҮҮЦЭЛ

843



ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТЫН АЖЛЫН ТАЛААР



НЭЭЛТТЭЙ
ДЭГЛЭМТЭЙ

5839



ХААЛТТАЙ
ДЭГЛЭМТЭЙ

1304



ТУСГАЙ
НЭГЖИД

37



СУРГАЛТ ХҮМҮҮЖЛИЙН
ТУСГАЙ БАЙГУУЛЛАГАД
ӨСВӨР НАСНЫ
ЯЛ ЭДЭЛСЭН

83



ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТЫН АЖЛЫН ТАЛААР



ХОРИХООС ӨӨР
ТӨРЛИЙН ЯЛААР
ШИЙТГҮҮЛСЭН ЯЛТАН

19117



ТОРГОХ ЯЛААР
ШИЙТГҮҮЛСЭН
ЯЛТАН

10418



ЦАГДАН ХОРИХ, БАРИВЧЛАХ, АЛБАДАН СААТУУЛАХ БАЙРУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВЬСАН ХЯНАЛТЫН ТАЛААР



ЦАГДАН ХОРИХ
БАЙРНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

1567



БАРИВЧЛАХ
БАЙРНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

813



АЛБАДАН
СААТУУЛАХ БАЙРНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

844

1.Прокурорын байгууллагын үндсэн чиг үүрэг

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

1.1.Прокурорын байгууллагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт


Прокурорын байгууллага нь Улсын ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум буюу сум дундын болон дүүргийн прокурорын газраас бүрдэнэ. Прокурорын хяналтын ажлын онцлогийг харгалзан дагнасан чиг үүрэгтэй Тээврийн прокурорын газар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 1. Прокурорын байгууллагын тогтолцоо



Улсын ерөнхий прокурорын газар нь дараах бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2. Улсын Ерөнхий Прокурорын газрын бүтэц, зохион байгуулалт



- Орон тооны бус зөвлөл :
1. Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөл ;
 2. Прокурорын мэргэжлийн зөвлөл ;
 3. Прокурорын ёс зүйн зөвлөл ;
 4. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл;
 5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөл;
 6. Эрдмийн зөвлөл.

Улсын ерөнхий прокурорын зарим зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг:

Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүрэг:

- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд мөрдөгдөж буй хууль, заавар, журмын хэрэгжилтийг нэг мөр хангуулах ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх;
- Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан, харьяа прокурорын газарт нэгдэн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг дангаараа болон Сургалтын төвтэй хамтран зохион байгуулах;
- Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд зөрчлийн хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан заавар, журмын хэрэгжилтийг дангаараа болон бусад газар, хэлтэстэй хамтран шалгах, судлах;
- Зөрчлийн хэрэгт олгох дугаарын хуваарилалтыг хийх, зөрчлийн хэргийн дугаар олголтод хяналт тавих, тайланг нэгтгэх;
- Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэгдсэн судалгааг тогтмол шинэчлэн, хяналтад бүрэн хамруулах арга хэмжээ авах;

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүрэг:

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Эрүүгийн хууль тогтоомж, удирдамжийн баримт бичгийг боловсронгуй болгох талаар Улсын ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг, материалыг хянах, танилцах;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд эрүүгийн хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан заавар, журмын хэрэгжилтийг дангаараа болон бусад газар, хэлтэстэй хамтран шалгах, судлах;
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос гаргасан гомдлын дагуу холбогдох эрүүгийн хэрэг, материалыг татаж, гомдлын үндэслэлийг хянан, дээд шатны прокурорт танилцуулж шийдвэрлүүлэх, шаардлагатай гэж үзвэл прокурорын даалгавар бичиж, биелэлтийг тооцох;

Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн чиг үүрэг:

- Шүүхэд төрийг төлөөлөх ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Шүүхэд төрийг төлөөлөх ажлын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын тушаалаар баталсан заавар, журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах;

- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцож, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хууль зүйн дүгнэлт гаргах, хэрэг хянан хэлэлцэх явцад илэрсэн мөрдөгч, прокурор, улсын яллагчийн гаргаж буй нийтлэг зөрчлийг тухай бүр судалж дүгнэн, харьяа прокурорын газарт ажлын чиглэл, зөвлөмж өгөх, мэдээлэл хүргүүлэх;
- Хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хууль зөрчсөн гэж үзвэл Улсын ерөнхий прокурорт танилцуулж, эсэргүүцэл бичих эсэх асуудлыг шийдвэрлүүлэх;
- Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанд оролцох Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн /бүрэн эрхээ шилжүүлсэн тохиолдолд/ шүүх хуралдаанд гаргах хууль зүйн дүгнэлтийн төслийг боловсруулж, шүүх хуралдаанд оролцох бэлтгэлийг хангах;

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүрэг:

- Ял эдлүүлэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажлыг боловсронгуй болгох бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Ял эдлүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хууль тогтоомж, удирдамж, баримт бичгийг боловсронгуй болгох талаар Улсын ерөнхий прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;
- Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох;
- Ял эдлүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан заавар, журмын хэрэгжилтийг дангаараа болон бусад хэлтэстэй хамтран шалгах, танилцах;
- Хяналтын чиглэлээр ирүүлсэн гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх;
- Ялтан шилжүүлэх тухай хууль тогтоомж, олон улсын гэрээний хэрэгжилтийг Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэстэй хамтран зохион байгуулах;

Хэрэг эрхлэх газрын чиг үүрэг:

- Прокурорын байгууллагын хүний нөөцийн бодлого, хөгжлийн асуудлыг хариуцан, хүний нөөц бүрдүүлэх, прокурор, ажилтныг чадавхжуулах ажлыг нэгтгэн зохион байгуулах;
- Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, тендерийн үйл ажиллагаа, аж ахуй, хангалт, үйлчилгээ, прокурор, ажилтны цалин хөлс, ажиллах нөхцөл боломж, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг нэгтгэн зохион байгуулах, энэ чиглэлээр гаргах Улсын ерөнхий прокурорын шийдвэр, бусад баримт бичгийн төслийг бэлтгэх, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцох;
- Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд прокурорын байгууллагын тухайн жилийн урсгал зардлын болон хөрөнгө оруулалтын төсвийн багцыг төлөвлөж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- Прокурорын байгууллагын нэгдсэн төсвийн хүрэлцээ, цаг үеийн шаардлага, инфляц зэргийг харгалзан нэмэгдэл төсөв батлуулах, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлүүлэх

санал боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

- Тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан прокурорын байгууллагын урсгал зардлын болон хөрөнгө оруулалтын төсвийн хуваарилалтын талаар санал боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулах;
- Батлагдсан төсвийн хүрээнд харьяа прокурорын газрын санхүүжилтийг сар бүр тооцох, олгогдоогүй санхүүжилтийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, санхүүжилтийг төлөвлөгөөний дагуу шийдвэрлүүлэх;

Сургалт, судалгааны хүрээлэнгийн чиг үүрэг:

- Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон харьяа прокурорын газраас сургалтын хэрэгцээ, шаардлагын талаарх саналыг авч нэгтгэн судалсны үндсэн дээр прокурор, ажилтанд зориулсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Прокурор, ажилтны анхан, үргэлжилсэн шатны болон давтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг хангах;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулан магадлан итгэмжлүүлсний үндсэн дээр тухайн сургалтыг дангаараа болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Эрдэм шинжилгээний байгууллага, хууль зүйн их, дээд сургууль, бусад байгууллагатай хамтран эрдэм шинжилгээ, онол, практикийн хурал зохион байгуулах, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, бүтээл эрхлэн гаргах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаарх судалгааг Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй хамтран гүйцэтгэх;
- Сургалтын гарын авлага, ном, товхимол эрхлэн гаргах;

2.Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавьсан хяналт

Улсын хэмжээнд 2024 онд зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулах 64 чиг үүргийн 851 нэгж байгууллагын 10207 эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд 86 прокурор хяналт тавьж ажилласан байна.

2.1.Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт


Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд 2024 онд 261524 зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авч, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, прокуророос хяналт тавьсан нь өмнөх оноос 31689 буюу 13.8%-иар өссөн байна.

Зураг 3.Гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан байгууллагаар нь харуулбал



Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн 168195 буюу 64.3%-д улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд, 93329 буюу 35.7%-д аймгийн прокурорын газруудаас хяналт тавин ажиллажээ.

График 1. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Гомдол, мэдээллийн 26.8%-ийг хүлээн авахаас татгалзаж, 22.1%-д зөрчлийн хэрэг нээж, 49.3%-ийг бүртгэлд авч хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэн, 0.9%-д хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 0.02%-д эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна.


2.2. Зөрчлийн хэргийн шийдвэрлэлт

Зөрчлийн нийт 3325634 хэрэг шалгагдсан нь өмнөх оноос 139766 буюу 4.4%-иар өсжээ.

Газар дээр нь хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчил өмнөх оноос 111910 буюу 3.7%-иар, гомдол, мэдээллийн бүртгэлд авч, хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн зөрчил 4903 буюу 3.9%-иар, зөрчлийн хэрэг нээн шалгасан хэрэг 22953 буюу 64.1%-иар тус тус өссөн байна.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан 58785 хэргийн 1.5% нь өмнөх оны үлдэгдэл, 0.1% нь өмнөх онд хэрэгсэхгүй болгосон, шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгож зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан, 98.5% нь 2024 онд шинээр зөрчлийн хэрэг нээж, шалгасан хэргүүд байна.

Зураг 4. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан байгууллагаар нь харуулбал




Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан нийт хэргийн 47990 буюу 81.6%-ийг үндсэн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн бол 10795 буюу 18.4%-д хугацаа сунган шалгуулсан нь өмнөх оноос 2.5%-иар буурсан байна.

Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан хэргийн 56992 буюу 96.9%-ийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 0.6%-иар буурчээ.

Хэргийн шийдвэрлэлт буурсан шалтгаан нь Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21 дэх хэсэгт заасан “Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчих” зөрчилд,

шалгавал зохих ажиллагааны цар хүрээнээс хамаарч зөрчлийн хэрэг нээн шалгаж байгаатай холбоотой байна.

График 2.Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан хэргийн шийдвэрлэлт



Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан хэрэг өмнөх оноос 17.5%-иар, шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах саналтай шүүхэд хүргүүлсэн хэрэг 80.5%-иар, шийтгэлээс чөлөөлсөн хэрэг 14.9%-иар, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэрэг 34.8%-иар, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 17.5%-иар тус тус өссөн бол, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хэрэг 5.8%-иар буурсан байна.

Хүснэгт 1.Улс, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хяналт тавьсан гомдол, мэдээлэл, хэрэг

№	Прокурорын газар	Гомдол, мэдээлэл	Өсөлт, бууралт	Хэрэг	Өсөлт, бууралт
1	Улсын ерөнхий прокурорын газар	168	+22.6%	153	+17.7%
2	Нийслэлийн прокурорын газар	7008	+1.6%	6809	+0.9%
3	Баянгол дүүргийн прокурорын газар	21250	-2.7%	122659	-40.2%
4	Баянзүрх дүүргийн прокурорын газар	38421	+15.6%	201593	-28.6%
5	Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар	35734	+10.2%	163837	-9.4%
6	Сүхбаатар дүүргийн прокурорын газар	19117	+5.6%	208841	-17.4%
7	Хан-Уул дүүргийн прокурорын газар	20999	+10.7%	141250	-24.3%
8	Чингэлтэй дүүргийн прокурорын газар	18285	-4%	1415422	48.5%
9	Багануур дүүргийн прокурорын газар	2145	+19.2%	38171	-16.3%
10	Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	3727	-12%	77586	-19.5%
11	Тээврийн прокурорын газар	1341	+13.9%	71704	-16.2%
Нийт		158874	6.5%	2448025	+6.7%

Дээрх үзүүлэлтээс харвал Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газрын хяналт тавьсан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг өссөн бол Баянгол, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар буурчээ.


Хүснэгт 2. Орон нутгийн прокурорын газрын хяналт тавьсан гомдол, мэдээлэл, хэрэг

№	Прокурорын газар	Гомдол, мэдээлэл	Өсөлт, бууралт	Хэрэг	Өсөлт, бууралт
1	Архангай аймгийн прокурорын газар	3425	+27.5%	38443	-16.2%
2	Баян-Өлгий аймгийн прокурорын газар	3651	+12.9%	20755	-32.6%
3	Баянхонгор аймгийн прокурорын газар	4869	+27.2%	32245	-14.8%
4	Булган аймгийн прокурорын газар	3063	+22.8%	41436	+9.1%
5	Говь-Алтай аймгийн прокурорын газар	2773	+22.2%	28397	+9.5%
6	Говьсүмбэр аймгийн прокурорын газар	1395	+41.9%	34208	+28.1%
7	Дархан-Уул аймгийн прокурорын газар	6989	+70.7%	59414	-1.3%
8	Дорноговь аймгийн прокурорын газар	7653	+49.7%	49135	+34.7%
9	Дорнод аймгийн прокурорын газар	4073	+21.3%	34096	+7.5%
10	Дундговь аймгийн прокурорын газар	1817	+54.9%	23221	+6.2%
11	Завхан аймгийн прокурорын газар	3292	+46.7%	31683	+2.5%
12	Орхон аймгийн прокурорын газар	4589	+2.4%	45252	-3.3%
13	Өвөрхангай аймгийн прокурорын газар	7194	+44.2%	63576	-9.7%
14	Өмнөговь аймгийн прокурорын газар	5774	+23.1%	78913	-6.4%
15	Сүхбаатар аймгийн прокурорын газар	2814	+6.2%	27241	+12.8%
16	Сэлэнгэ аймгийн прокурорын газар	7382	+18%	56507	+1.1%
17	Төв аймгийн прокурорын газар	4925	+51%	89579	-0.8%
18	Увс аймгийн прокурорын газар	3885	+22.9%	28600	-12%
19	Ховд аймгийн прокурорын газар	4323	+8.2%	26929	-22.2%
20	Хөвсгөл аймгийн прокурорын газар	3860	+34.4%	24334	-22.4%
21	Хэнтий аймгийн прокурорын газар	5583	+35.2%	43645	+28.4%
Нийт		93329	29.7%	877609	-1.5%

Орон нутгийн прокурорын газруудын хяналт тавьсан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл өссөн. Төв аймгийн прокурорын газар хамгийн их буюу 89579 (10.2%), Баян-Өлгийн аймгийн прокурорын газар хамгийн бага 20755 (2.3%) зөрчлийн хэрэгт хяналт тавьсан бол Дорноговь (34.7%-иар), Хэнтий (28.4%-иар), Говьсүмбэр (28.1%-иар) аймгийн прокурорын газрын хяналт тавьсан зөрчлийн хэрэг өмнөх оноос хамгийн их хувиар өсжээ.

Зөрчил үйлдсэн нийт 3.347.081 хүн, хуулийн этгээдэд 105.3 тэрбум төгрөгийн торгох шийтгэл, 32026 хүнд эрх хасах шийтгэл оногдуулсан бол 16556 хүнд баривчлах шийтгэл оногдуулсан байна.

График 3. Оногдуулсан шийтгэлийг 2023 онтой харьцуулан харуулбал



Торгох шийтгэл оногдуулсан хүн өмнөх оноос 159947 буюу 5.0%-иар өссөн бол эрх хасах шийтгэл 1459 буюу 4.6%-иар, баривчлах шийтгэл оногдуулсан хүн 3114 буюу 15.8%-иар буурчээ.

Шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд төлөөгүйгээс баривчлах шийтгэлээр солиулах 65 санал гаргасан нь өмнөх оноос 30 буюу 85.7%-иар өссөн байна.



Эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн санал өмнөх оноос 20.7%-иар, прокурор хүчинтэйд тооцсон тохиолдол 21.7%-иар тус тус өссөн бол, хүчингүйд тооцсон тохиолдол 66.7%-иар буурчээ.

2.5. Эрх хязгаарлах арга хэмжээ

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад 28829 эрх хязгаарлах арга хэмжээ авсны 11961 буюу 41.5%-д холбогдогчийн баримт бичгийг хураан авах, 16803 буюу 58.3%-д хүнийг саатуулах, 65 буюу 0.2%-д үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох арга хэмжээг тус тус авсан байна.

Эрх хязгаарлах арга хэмжээ өмнөх оноос 9.6%-иар буурсан бол хүнийг саатуулах арга хэмжээ 95.4%-иар, үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох арга хэмжээ 38.3%-иар тус тус өсжээ.

Зөрчлийн холбогдогчийг эрүүлжүүлж хууль тогтоомж зөрчиж байсныг илрүүлэн, нэгж прокурорын газруудад мэдээлэл хүргүүлсэн, нийслэл, дүүргийн хэмжээнд эрх бүхий албан тушаалтнаас хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээг холбогдох хууль, журамд заасан үндэслэл, журмын дагуу явуулж буй эсэхийг шалгаж, мэдээлэл хүргүүлэн, хүний эрхийг хангаж ажилласнаар эрүүлжүүлэх байранд зөрчлийн холбогдогчийг саатуулдаг зөрчил арилсан байна.

2.6. Зөрчлийн хэргийн улмаас учирсан хохирол, төлөгдсөн байдал

Зөрчлийн улмаас хүн, хуулийн этгээд, төр, нийтийн ашиг сонирхолд 95.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оноос 50.0 тэрбум төгрөг буюу 2.1 дахин өсжээ.

Учирсан хохирлын 47.9 тэрбум төгрөг буюу 50.2% нь хүнд, 2.9 тэрбум төгрөг буюу 3.1% нь хуулийн этгээдэд, 44.6 тэрбум төгрөг буюу 46.7% нь төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирол байна.

Хохирлын хэмжээ өссөн шалтгаан нь зөрчлийн хэрэг өмнөх оноос 139766 буюу 4.4% өссөнтэй холбоотой байна.

Зөрчлийн улмаас учирсан хохирлын 51.1% буюу 48.7 тэрбум төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн нь өмнөх оноос 10.5 тэрбум төгрөг буюу 27.5%-иар өсжээ.

Хүнд учирсан хохирлын 77.5%-ийг, хуулийн этгээдэд учирсан хохирлын 48.6%-ийг, төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлын 22.9%-ийг тус тус нөхөн төлүүлсэн байна.

2.7. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн байдал

Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.9-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын ерөнхий прокуророос 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зөвшөөрөл олгосон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны Албадан эрүүлжүүлэх (код 620) журамд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг албадан эрүүлжүүлдэг байсан зохицуулалтыг арилгаж хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх арга хэмжээ авсан.

Цагдаагийн ерөнхий газрын “Бэлэн бус торгуулийн систем”-д бүртгэгдсэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх хугацаанд хуульд заасны дагуу бэлэн бус хэлбэрээр оногдуулсан, шийтгэл биелэгдээгүй торгууль нь зөрчилд тооцохгүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийж, хууль буцаан хэрэглүүлэхээр 21872 дүгнэлт;

Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан “Жолооч нь жолоочийн даатгалд даатгуулалгүйгээр тээврийн хэрэгслээ ашиглан замын хөдөлгөөнд

оролцсон” зөрчлийг шийдвэрлэж буй байдал, шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг судалж, эрх бүхий албан тушаалтнаас даатгалыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авахгүйгээр Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан суурь хураамжийн 50%-иар тооцож, зөрчлийг газар дээр нь шийдвэрлэсэн шийдвэрийг хүчингүй болгуулахаар 18732 прокурорын дүгнэлт тус тус бичиж, 36717 хүний зөрчигдсөн эрхийг сэргээсэн байна.


2.8. Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах, өөрчлөлт оруулахаар бичсэн дүгнэлт

Эрх бүхий албан тушаалтны хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн болон зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулсан шийдвэрийг прокурор хянаад, 47519 дүгнэлт бичсэн нь өмнөх оноос 39285 буюу 4.7 дахин өссөн байна.

Бичсэн дүгнэлтийн 36823 буюу 77.5% нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулахаар, 10696 буюу 22.5% нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрт өөрчлөлт оруулахаар бичжээ.

Прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулж шийтгэл оногдуулсан 1052 зөрчлийг прокурор шалгалтаар илрүүлж, эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгуулахаар дүгнэлт бичсэн байна.

График 5. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хянаад бичсэн дүгнэлт



Шүүхээр прокурорын 37200 дүгнэлт хэлэлцэгдэж, 36755 буюу 98.8% нь биелсэн байна.

Энэ нь хяналт хариуцсан прокуроруудын хууль хэрэглээний ур чадвар дээшилсэн, эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг шалгалтын хүрээнд хянахдаа хууль, аргачилсан зааварт заасан хянавал зохих байдлыг бүрэн хамруулж, зөрчлийг илрүүлж зөвтгөх, дүгнэлт бичих байдлаар хүн, хуулийн этгээдийг зөрчигдсөн эрхийг сэргээх, хуулийг нэг мөр хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.


3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавьсан хяналт

Улсын хэмжээнд 2024 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий 3 байгууллагын 1961 мөрдөгчийн мөрдөн шалгах ажиллагаанд 296 прокурор хяналт тавьж ажилласан.

3.1. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллага 2024 онд нийт 126413 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хяналт тавьж ажилласан нь өмнөх оноос 16426 буюу 14.9%-иар өссөн байна.

Зураг 6. Гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан байгууллагаар нь харуулбал



Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн 99446 буюу 78.7%-д нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газруудаас, 26967 буюу 21.3%-д орон нутгийн прокурорын газруудаас хяналт тавин ажиллажээ.

Нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газруудын хяналт тавьсан гомдол, мэдээлэл өмнөх оноос 16.7%-иар, орон нутгийн прокурорын газруудын хяналт тавьсан гомдол, мэдээлэл 8.9%-иар тус тус өсжээ.

График 6. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн 50.4%-д хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 32.7%-д хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 11.4%-д эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 94.5%-ийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт өмнөх оноос 0.1%-иар өссөн байна.

3.2. Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт

Хэрэг бүртгэлт явуулсан 74438 хэрэгт хяналт тавьсан нь өмнөх оноос 10943 буюу 17.2%-иар өсжээ.

Хэрэг бүртгэлтийн хугацаа сунган шалгуулсан хэрэг өмнөх оноос 0.9%-иар буурсан байна.


Зураг 7.Хэрэг бүртгэлт явуулсан байгууллага тус бүрээр харуулбал



Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн 3 буюу 0.004%-ийг хамтарсан ажлын хэсгээр шалгасан байна.


Хэрэг бүртгэлтийн хэргийн 57741 буюу 77.6%-д нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд, 16697 буюу 22.4%-д орон нутгийн прокурорын газрууд хяналт тавин ажиллажээ.

Зураг 8.Хэрэг бүртгэлт явуулсан хэргийг төрлөөр нь ангилж үзвэл



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 44.6%-ийг залилах, хүний эрүүл мэнд, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 77.4%-ийг хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 76.4%-ийг хүчиндэх, авлигын гэмт хэргийн 82%-ийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг эзэлж байна.

График 7.Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт



Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн 16%-ийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 24.6%-ийг хааж, 40.6%-ийг шийдвэрлэсэн ба хэргийн шийдвэрлэлт өмнөх оноос 13.7%-иар буурчээ.

Хэрэг бүртгэлтийг хааж шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 19.6%-иар буурсан бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг 1.6%-иар өсжээ. Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт өмнөх оноос нийслэлийн хэмжээнд 15.7%-иар, орон нутгийн хэмжээнд 6.4%-иар буурсан байна.

Хэрэг бүртгэлтийн ажиллагаанд үлдэгдэл 43885 хэрэг шалгагдаж байгаагаас 98.1% нь цагдаагийн байгууллагаас, 1.8% нь авлигатай тэмцэх байгууллагаас, 0.06% нь тагнуулын байгууллагаас, 3 нь хамтарсан ажлын хэсгээс тус тус мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Эдгээр хэргүүдийн 81.9%-ийг нийслэл, тээвэр, дүүргийн, 18.1%-ийг орон нутгийн прокурорын газраас хяналт тавин ажиллаж байна.


3.3.Мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт

Мөрдөн байцаалт явуулсан 28543 хэрэгт хяналт тавьсан нь өмнөх оноос 943 буюу 3.4%-иар өссөн байна.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэргийн 11954 буюу 45.1%-ийг хэрэг бүртгэлтийн хэргээс, 14442 буюу 54.4%-ийг гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллээс, 133 буюу 0.5%-ийг зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, хэргээс тус тус эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татжээ.

2024 онд 18648 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсаны 2698 буюу 14.5% нь эмэгтэй, 1371 буюу 7.4% нь өсвөр насны яллагдагч байна.

Зураг 9.Мөрдөн байцаалт явуулсан байгууллага тус бүрээр нь харуулбал



Мөрдөн байцаалт явуулсан 1 хэргийг хамтарсан ажлын хэсгээр шалгасан байна.

Мөрдөн байцаалтын хэргийн 18583 буюу 65.1%-д нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрууд, 9960 хэрэг буюу 34.9%-д орон нутгийн прокурорын газрууд тус тус хяналт тавин ажиллажээ.

Хүснэгт 3. Мөрдөн байцаалт явуулсан хэргийг төрлөөр нь харуулбал

50%	Өмчлөх эрхийн эсрэг
26.5%	Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг
9.9%	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг
2.2%	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг
1.7%	Авлигын гэмт хэрэг
1.6%	Хүрээлэн байгаа орчны эсрэг
1.5%	Кибер аюулгүй байдлын эсрэг
1.4%	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг
0.9%	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг
0.8%	Эдийн засгийн гэмт хэрэг
0.7%	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг
2.2	Бусад

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 64.2%-ийг “Залилах”, хүний эрүүл мэнд, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 83.2%-ийг “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах”, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 78%-ийг “Хүчиндэх”, авлигын гэмт хэргийн 68%-ийг “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах”, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн 44%-ийг “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Мөрдөн байцаалт явуулсан хэрэг өмнөх оноос нийслэлийн хэмжээнд 1.1%-иар буурч, орон нутагт 13.2%-иар өсжээ.

Мөрдөн байцаалт явуулсан хэргийн 24624 буюу 86.3% нь хөнгөн, 3916 буюу 13.7% нь хүнд, 3 буюу 0.01% нь 2002 оны Эрүүгийн хуулийн зүйлчлэлтэй гэмт хэргүүд байна. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн 10%-д хугацаа сунгаж шалгуулсан нь өмнөх оноос 1.2%-иар өссөн байна.

Мөрдөн байцаалт явуулсан хэргийн 56%-д яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлэн, 2.2%-ийг хэрэгсэхгүй болгож, 0.9%-ийг түдгэлзүүлэн, 37.2%-ийг бусад хэрэгт нэгтгэн, 0.6%-ийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгон хэрэг бүртгэлтэд шилжүүлж, ажиллагаанд 3.3% нь шалгагдаж байна. Нэгтгэж шалгасан 10632 хэргийн 9293 буюу 87.4%-ийг шүүхэд шилжүүлжээ.

Мөрдөн байцаалт явуулсан хэргийн 90.7%-ийг эцэслэн шийдвэрлэж, хэргийн шийдвэрлэлт өмнөх оноос 0.6%-иар буурсан байна.

График 8. Яллах дүгнэлт үйлдсэн хэрэг



Яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хэргийн 32.1%-ийг хялбаршуулсан, 67.9%-ийг ердийн журмаар шийдвэрлэсэн ба хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 5.1%-иар буурч, ердийн журмаар шүүхэд шилжүүлсэн хэрэг 14.8%-иар өсжээ.

Мөрдөн байцаалт явуулсан хэргийн 2.2%-ийг хэрэгсэхгүй болгосон хэрэг өмнөх онтой ижил түвшинд, нийт 379 хэрэг түдгэлзээтэй байгаа нь өмнөх оноос 31.1%-иар өссөн байна.

Хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн 75.4%-ийг гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй, түдгэлзүүлсэн хэргийн 94.7%-ийг яллагдагч оргон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлжээ.

Хэргийн шийдвэрлэлт нийслэлийн хэмжээнд 57.9%-аас 96.3, орон нутгийн хэмжээнд 84.8%-иас 99.4 хүртэл хувьтай байна.

Хүснэгт 4. Нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газраас хяналт тавьсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг

№	Прокурорын газар	Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл		Хэрэг бүртгэлтийн Хэрэг		Мөрдөн байцаалтын хэрэг	
1	Нийслэлийн прокурорын газар	1408	-9.8%	1821	+3.7%	858	+1.2%
2	Баянгол дүүргийн прокурорын газар	17050	+16.5%	9724	+31.7%	2322	-5.8%
3	Баянзүрх дүүргийн прокурорын газар	25382	+18.7%	14291	+19.9%	4223	-0.2%
4	Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар	15669	+15.6%	7417	+10.3%	2074	-11.9%
5	Сүхбаатар дүүргийн прокурорын газар	13566	+5.6%	6999	+2.4%	2961	-16%
6	Хан-Уул дүүргийн прокурорын газар	12168	+32.9%	9813	+25.3%	2254	-5.1%
7	Чингэлтэй дүүргийн прокурорын газар	9010	+9.2%	4846	+23.2%	2219	+25%
8	Багануур дүүргийн прокурорын газар	745	+57.5%	377	+39.1%	189	+42.1%
9	Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	1493	+24.6%	850	+29.6%	320	-30.1%
10	Тээврийн прокурорын газар	2955	+37.1%	1603	+71.4%	1163	+83.4%
Нийт		99446	+16.7%	57,741	+19.7%	18583	-1.1%

Нийслэлийн хэмжээнд гэмт хэргийн талаарх 99446 гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн 57741, мөрдөн байцаалтын 18583 хэрэгт хяналт тавьсан нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн хэрэг өссөн. Харин зарим дүүргийн прокурорын газрын хяналт тавьсан мөрдөн байцаалтын хэрэг буурсан байна.

Баянзүрх дүүргийн прокурорын газар хамгийн өндөр статистик үзүүлэлттэй, Багануур дүүргийн прокурорын газар хамгийн бага үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Орон нутгийн прокурорын газраас хяналт тавьсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг


№	Прокурорын газар	Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл		Хэрэг бүртгэлтийн хэрэг		Мөрдөн байцаалтын хэрэг	
1	Архангай аймгийн прокурорын газар	1235	+11.4%	616	+15.8%	359	-3.2%
2	Баян-Өлгий аймгийн прокурорын газар	961	-2.7%	590	+1.9%	438	+16.8%
3	Баянхонгор аймгийн прокурорын газар	1607	+19.8%	970	+107.3%	431	+38.6%
4	Булган аймгийн прокурорын газар	806	-7%	625	-16%	288	=
5	Говь-Алтай аймгийн прокурорын газар	651	+19%	482	+27.9%	311	+46.7%
6	Говьсүмбэр аймгийн прокурорын газар	392	20.6%	251	+13.1%	140	+3.7%
7	Дархан-Уул аймгийн прокурорын газар	1752	15.8%	439	-19.9%	856	+34%
8	Дорноговь аймгийн прокурорын газар	1567	+9.4%	1191	+19.9%	638	+21.1%
9	Дорнод аймгийн прокурорын газар	1606	21.5%	1036	+21.7%	514	+17.6%
10	Дундговь аймгийн прокурорын газар	765	+18.2%	360	-15.5%	302	+21.8%
11	Завхан аймгийн прокурорын газар	544	-4.1%	412	-4.6%	232	-14.7%
12	Орхон аймгийн прокурорын газар	2223	+13.5%	1123	+11.1%	807	27.9%
13	Өвөрхангай аймгийн прокурорын газар	987	+27.2%	1072	+2.5%	553	20.7%
14	Өмнөговь аймгийн прокурорын газар	2107	+23.4%	1153	+9.7%	548	+7.5%
15	Сүхбаатар аймгийн прокурорын газар	1135	7.9%	768	+11.6%	373	15.1%
16	Сэлэнгэ аймгийн прокурорын газар	1789	-1.6%	1200	+4.1%	693	7.6%
17	Төв аймгийн прокурорын газар	1713	-1.8%	1178	+4.7%	555	-11.5%
18	Увс аймгийн прокурорын газар	829	+8.2%	393	-5.1%	324	23.2%
19	Ховд аймгийн прокурорын газар	1229	-4.7%	945	+27%	459	4.3%
20	Хөвсгөл аймгийн прокурорын газар	1238	7.7%	762	-9.7%	583	3.4%
21	Хэнтий аймгийн прокурорын газар	1831	-0.7%	1131	+13%	556	5.7%
Нийт		29967	+8.9%	16697	+9.5%	9960	+13.2%

Орон нутгийн прокурорын газруудын хяналт тавьсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл 8.9%-иар, хэрэг бүртгэлтийн хэрэг 9.5%-иар, мөрдөн байцаалтын хэрэг 13.2%-иар тус тус өссөн. Орхон аймгийн прокурорын газар хамгийн өндөр статистик үзүүлэлттэй, Говьсүмбэр прокурорын газар хамгийн бага үзүүлэлттэй байна.

3.4.Хяналтын ажлын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиглэлээр шалгалт, судалгаа, танилцах ажил хийж, илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар холбогдох газруудад прокурорын шаардлага бичиж, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна.

График 9.Хяналтын ажлын явцад авсан арга хэмжээ



Прокурор мөрдөн шалгах тодорхой ажиллагаа хийлгэхээр мөрдөгчид 26878 даалгавар бичсэн нь өмнөх оноос 7.9%-иар өссөн бол эрэн сурвалжлах ажиллагаа хийлгэхээр 3016 даалгавар бичсэн нь 29.8%-иар буурсан байна.

Мөрдөн шалгах ажиллагаанд прокурор 5617 удаа оролцсоноос 83%-д нь шүүхээс зөвшөөрөл авах, шүүхийн шийдвэр гаргуулах, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой шүүхийн хэлэлцүүлэгт, 17%-д нь мэдүүлэг авах ажиллагаанд оролцжээ.

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах ажиллагаа 6 удаа авсан нь өмнөх оноос 1 буюу 14.3%-иар бага байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад прокуророос 37152 зөвшөөрөл олгосон нь өмнөх оноос 19.8%-иар өсжээ.

Шүүхийн зөвшөөрлөөр 54, хойшлуулшгүйгээр 466 буюу нийт 520 сэжигтнийг баривчилсан нь өмнөх оноос шүүхийн зөвшөөрөлтэй баривчилсан сэжигтэн 1.6 дахин нэмэгдэж, хойшлуулшгүйгээр баривчилсан тохиолдол 46.7%-иар буурсан байна. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон сэжигтнийг баривчлах үндэслэл, журмыг зохих ёсоор хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.

2024 онд 18909 яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсны 1386 буюу 7.3%-д Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох, 1268 буюу 6.7%-д цагдан хорих, 16255 буюу 86%-д бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авчээ.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ 9.2%-иар буурсан бол хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ 5.2%-иар, бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ 4.6%-иар тус тус өссөн байна.

3.5.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хохирол нөхөн төлүүлсэн байдал

2024 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэгт 45358 хүнийг хохирогчоор тогтоогдсоны 20874 буюу 46% нь эмэгтэй, 3102 буюу 6.8% нь насанд хүрээгүй хохирогч байна.

Гэмт хэргийн улмаас 3.740.537.047.000 /гурван их наяд долоон зуун дөчин тэрбум таван зуун гучин долоон сая дөчин долоон мянга/ төгрөгийн эд хөрөнгийн хохирол,

133.502.857.000 /нэг зуун гучин гурван тэрбум таван зуун хоёр сая найман зуун тавин долоон мянга/ төгрөгийн хор уршиг учирчээ.

Зөрчигдсөн эрхийг хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх, торгох болон эд хөрөнгө хураах ялын биелэлтийг хангуулах зорилгоор мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт 157.599.957.000 /нэг зуун тавин долоон тэрбум таван зуун ерэн есөн сая есөн зуун тавин долоон мянга/ төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн бүртгэл, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, 304.090.314.000 /гурван зуун дөрвөн тэрбум ерэн сая гурван зуун арван дөрвөн мянга/ төгрөгийн хөрөнгө хамгаалж битүүмжилсэн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоос 1.783.030.279.000 /нэг их наяд долоон зуун наян гурван тэрбум гучин сая хоёр зуун далан есөн мянга/ төгрөгийн хохирол нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 31.4%-иар, 4.975.849.000 /дөрвөн тэрбум есөн зуун далан таван сая найман зуун дөчин есөн мянга/ төгрөгийн хор уршигийг арилгуулсан нь 16.8%-иар тус тус буурсан байна.

Төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан 1637 хэргийг шийдвэрлэж, 30.680.392.000 /гучин тэрбум зургаан зуун наян сая гурван зуун ерэн хоёр мянга/ төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна.

3.6.Зарим төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт

Авлига, мөнгө угаах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой, кибер аюулгүй байдал, цэргийн албаны эсрэг, хүүхэд хохирсон, холбогдсон зэрэг гэмт хэрэгт хяналт тавих прокуроруудыг мэргэшүүлэн ажиллуулж байна.

Хүснэгт 6.Өсөлт, бууралтыг харуулбал

№	Зарим төрлийн гэмт хэрэг	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт		Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт			Мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт			
		Хэргийн тоо	Өсөлт, бууралт	Хаасан	ЭХҮЯТ	Нэгтгэсэн	Шүүхэд шилжүүлсэн	Хэрэгсэхгүй болгосон	Түдгэлзүүлсэн	Нэгтгэсэн
1	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	453	+12%	43	195	-	184	1	-	51
2	Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг	33	+13.7%	13	9	1	7	-	-	-
3	Хүн худалдаалах гэмт хэрэг	35	+34.6%	5	7	-	10	-	-	1
4	Мөнгө угаах гэмт хэрэг	294	+4.5%	40	41	-	60	3	-	21
5	Авлигын гэмт хэрэг	1742	+4.9%	434	251	44	306	7	-	-
6	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	769	-0.5%	102	316	1	480	4	-	43
7	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	863	-10%	176	188	16	428	3	-	18
8	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1281	+12.9%	145	169	1	62	-	-	347
9	Хүнийг алах гэмт хэрэг	199	+3.1%	1	-	-	131	2	-	-
10	Төрийн албан хаагчаас үйлдсэн гэмт хэрэг	1047	+8.9%	-	-	-	935	8	-	-
11	Гадаад улсын иргэн холбогдсон гэмт хэрэг	94	-17.7%	6	34	-	62	2	-	-
12	Гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэрэг	4013	+17%	840	828	-	1174	272	-	2
13	Сонгуультай холбоотой гэмт хэрэг	61	-	16	1	2	-	-	-	-

3.7. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажил

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд 2018, 2024 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 56/39 дүгээр зөвлөмж, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 127 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивд байгаа улс төрийн хэргүүдийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг үүсгэн шалгах, 1998 оноос хойш шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэн шалгаад улс төрийн хилс хэрэгт холбогдсон гэх нотлох баримт тогтоогдоогүйгээс мөрдөн байцаалтыг зогсоосон болон орон нутгийн архивуудаас 2017-2019 онд татан төвлөрүүлсэн хэргүүдээс сэргээж, дахин шалгуулах, прокурорын дүгнэлт бичиж Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх ажлыг Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газартай хамтран хэрэгжүүлсэн.

Хяналт тавьсан 192 хэргээс 153 хэргийг хэрэгсэхгүй болгож, 16 хэрэгт прокурорын дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлж, одоо мөрдөн байцаалтад 13 хэрэг шалгагдаж, прокурорын хяналтад 10 хэрэг хянагдаж байна.

Шийдвэрлэсэн 192 хэргийн 153 буюу 79.7%-ийг прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсний 10 буюу 6.5%-ийг гэмт хэргийн шинжгүй, 143 буюу 93.5%-ийг өмнөх шийдвэр хүчин төгөлдөр байгаа буюу шинэ нөхцөл байдал тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Шийдвэрлэсэн хэргээс 10 хэргийн 10 хүнийг улс төрийн хэрэгт хилсээр мөрдөгдөж, шалгагдсан болохыг тогтоож, прокурорын тогтоолоор улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэнд тооцсон.

Шүүх болон шүүхийг орлосон Тусгай комисс, Онцгой бүрэн эрхт комиссын тогтоолоор хорих болон цаазаар авах ял хилсээр шийтгүүлсэн гэж үзсэн 16 хэргийн 22 хүнийг цагаатгуулахаар шинээр илэрсэн нөхцөл байдлаар прокурорын дүгнэлт бичсэн.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар дээрх 16 хэргийг хянан хэлэлцэхэд прокурор оролцон дүгнэлт гаргаснаар 13 хэргийн 18 хүнийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн болохыг тогтоож, цагаатгасан ба 4 хүнд холбогдох 3 дүгнэлтийг шүүх хүлээж авахаас татгалзсан байна.


Нотлох баримт тогтоогдоогүйгээс мөрдөн байцаалтыг зогсоосон болон төв, орон нутгийн архивуудаас 2017-2019 онд Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивд татан төвлөрүүлсэн хэргүүдийг бүрэн шалгаж дуусгасан байна.

4. Шүүхэд төрийг төлөөлөх ажил

4.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцсон байдал


Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийн хүрээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаанд шүүгдэгчийн гэм буруу, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын дүгнэлт гаргаж, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд шүүхийн шийдвэр, оногдуулсан эрүүгийн хариуцлага үндэслэлтэй эсэх талаар хууль зүйн дүгнэлт гарган оролцсон байна.

График 10.Шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг




Анхан шатны шүүхээр 15000 эрүүгийн хэрэг хянан хэлэлцэгдсэн нь өмнөх оноос 931 буюу 6.6%-иар өссөн байна.

График 11.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг




Анхан шатны шүүхэд ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан 9915 хэргийн 21%-д урьдчилсан хэлэлцүүлэг явагдсан нь өмнөх оноос 0.6%-иар, 2086 хэргийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцож, санал гаргасан нь өмнөх оноос 302 буюу 16.9%-иар тус тус өсжээ.

График 12.Прокурор гэм буруугийн шүүх хуралдаанд оролцсон байдал



Прокурор шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хэлэлцэх шүүх хуралдаанд оролцож дүгнэлт гаргасан байдлыг өмнөх онтой харьцуулбал, анхан шатны шүүхээр хэлэлцэгдсэн хэрэг 932 буюу 6.8%-иар, давж заалдах шатны шүүхээр хэлэлцэгдсэн хэрэг 370 буюу 17.8%-иар тус тус өссөн бол хяналтын шатны шүүхээр хэлэлцэгдсэн хэрэг 28 буюу 18.4%-иар буурсан байна.

График 13. Прокурор эрүүгийн хариуцлагын шүүх хуралдаанд оролцсон байдал




Анхан шатны шүүх эрүүгийн хариуцлага оногдуулах 14464 шүүх хуралдаан явуулсан нь өмнөх оноос 903 буюу 6.6%-иар өсжээ.

Эрүүгийн хариуцлагын хуралдаанаар 16664 хүн, 24 хуулийн этгээдэд холбогдох хэргийг хянан хэлэлцэж, 15930 шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь өмнөх оноос 3.7%-иар өссөн байна.

Шүүх 2516 хүнд хорих, 8759 хүнд торгох, 1260 хүнд нийтэд тустай ажил хийлгэх, 1667 хүнд зорчих эрх хязгаарлах ял тус тус оногдуулж, 2287 хүнд эрх хасах ялыг нэмэгдэл ял болгон хэрэглэж, 1539 шүүгдэгчийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 157 шүүгдэгчийг ялаас чөлөөлж, 21 шүүгдэгчид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, 60 шүүгдэгчийн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулж шийдвэрлэсэн байна.

График 14. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг



Шүүх 5085 хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 232 буюу 4.4%-иар буурсан бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийг 707 хэрэгт хэрэглэсэн нь өмнөх оноос 97 буюу 16%-иар өссөн байна. Үүнээс 157 шүүгдэгчийг ялаас чөлөөлж, 500 шүүгдэгчид хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, үүрэг хүлээлгэн, 50 шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг хөнгөрүүлж шийдвэрлэжээ.


Шүүхээр хэлэлцэгдсэн нийт 15000 хэргийн 7.3%-ийг прокурорт буцааж, 1.4%-ийг зүйлчлэл өөрчлөн, 0.6%-ийг цагаатгах тогтоолоор хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

4.2. Прокурорын эсэргүүцэл

Давж заалдах шатны шүүхээр 843, хяналтын шатны шүүхээр 39, нийт 882 прокурорын эсэргүүцэл хэлэлцэгдсэнээс 668 буюу 75.7% нь биелсэн нь өмнөх оноос 8.7%-иар өссөн байна.

Давж заалдах шатны шүүхээр 843 эсэргүүцэл хэлэлцэгдэж 633 буюу 75% нь биелсэн нь өмнөх оноос 8.6%-иар, хяналтын шатны шүүхэд прокурорын 133 эсэргүүцэл бичсэнээс 39 буюу 29.3% нь хэлэлцэгдэж, 35 буюу 89.7% нь биелсэн нь 16.7%-иар тус тус өсжээ.

График 15. Шүүхээр хэлэлцэгдсэн эсэргүүцэл



Давж заалдах шатны шүүхээр хэлэлцэгдсэн эсэргүүцлийн 49.6%-ийг хэргийг прокурорт буцаасан шийдвэрт, 12.2%-ийг хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгасан шийдвэрт, 4.7%-ийг зүйлчлэл өөрчилсөн шийдвэрт, 3.7%-ийг шийтгэх тогтоолоор шүүгдэгчийг цагаатгасан шийдвэрт, 29.8%-ийг шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр тус тус бичжээ.

Шүүхийн алдаатай шийдвэрийг залруулахаар 306 санал гаргасан нь өмнөх оноос 130 буюу 73.8%-иар өссөн ба үүнээс анхан шатны шүүхийн шийдвэрийг залруулахаар 286, давж заалдах шатны шүүхийн магадлалыг залруулахаар 20 санал бичсэн байна.

4.3.Зарим төрлийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлүүлсэн байдал

Авлига, албан тушаалын гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” 121 хэргийн 204 хүн, 22.4 дүгээр зүйлд заасан “Хахууль авах” 64 хэргийн 91 хүн, 22.5 дугаар зүйлд заасан “Хахууль өгөх” 67 хэргийн 121 хүн, 1 хуулийн этгээдэд тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ.

Шүүхээс оногдуулж буй ял шийтгэлийн хувьд зүйлчлэл давхардсан тоогоор 247 хэргийн 401 хүн, 1 хуулийн этгээдэд шүүх эрүүгийн хариуцлага хүлээлгэснийг өмнөх онтой харьцуулбал хэрэг 2 буюу 0.8%-иар, хүн, хуулийн этгээд 31 буюу 7.2%-иар тус тус буурсан байна.

Ялын төрлөөр авч үзвэл, 32 хүнд хорих ял, 278 хүн, 1 хуулийн этгээдэд торгох ял, 38 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял, 35 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, албадлагын арга хэмжээ авч, 19 хүнийг ялаас чөлөөлжээ. Өмнөх оноос хорих ялаар шийтгүүлсэн хүн 8 буюу 25%-иар, зорчих эрх хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүн 22 буюу 1.3 дахин, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хүн 24 буюу 2.2 дахин тус тус өссөн бол торгох ял шийтгүүлсэн хүн 77 буюу 21.6%-иар буурсан байна.

Шүүх Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болох 2.120.957.685 төгрөг, 48.500 ам.доллар, 1 автомашин, гар утас зэргийг хурааж, улсын орлого болгохоор шийдвэрлэжээ.

Мөнгө угаах гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл “Мөнгө угаах” 42 хэргийн 70 хүнд шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь өмнөх оноос хэрэг 1-ээр буурсан бол хүн 11 буюу 18.6%-иар өссөн.

Шүүхээс оногдуулж буй ял шийтгэлийн хувьд 26 хүнд хорих ял, 5 хүнд торгох ял, 26 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял, 11 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, албадлагын арга хэмжээ авч, 2 хүнийг ялаас чөлөөлсөн байна.

Өмнөх онтой харьцуулахад, хорих ялаар шийтгүүлсэн хүн 14 буюу 1.2 дахин, торгох ялаар шийтгүүлсэн хүн 1-ээр тус тус өссөн, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хүн 6 буюу 35.2%-иар буурчээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” 179 хэргийн 253 хүнд шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь өмнөх онтой ижил түвшинд байна.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн хувьд, 159 хүнд хорих ял, 77 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял, 17 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, албадлагын арга хэмжээ авсан байна. Өмнөх онтой харьцуулахад, хорих ялаар шийтгүүлсэн хүн 15 буюу 10.4%-иар өссөн бол зорчих эрх хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүн 4 буюу 4.9%-иар, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хүн 8 буюу 32%-иар тус тус буурчээ.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт заасан хүрээлэн байгаа орчны эсрэг 369 хэргийн 507 хүн, 7 хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Өмнөх онтой харьцуулбал, хэрэг 52 буюу 12.3%-иар, хүн, хуулийн этгээд 76 буюу 13%-иар тус тус буурчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн хувьд 5 хүнд хорих ял, 6 хүнд нийтэд тустай ажил хийлгэх ял, 41 хүнд зорчих эрх хязгаарлах ял, 303 хүн, 7 хуулийн этгээдэд торгох ял, 13 хүнийг ялаас чөлөөлж, 139 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, албадлагын арга хэмжээ авсан байна.

Өмнөх онтой харьцуулбал, хорих ялаар шийтгүүлсэн хүн 6 буюу 83.3%-иар, зорчих эрх хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүн 4 буюу 8.9%-иар, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хүн 105 буюу 43%-иар тус тус буурч, торгох ялаар шийтгүүлсэн хүн, хуулийн этгээд 33 буюу 11.9%-иар, ялаас чөлөөлсөн хүн 12-оор тус тус өсжээ.

Шүүх Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, ашиг, хөрөнгө, 5.4 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгсэл, эд зүйл, байгалийн бүтээгдэхүүнийг улсын орлого болгохоор шийдвэрлэсэн нь өмнөх оноос 773.000 төгрөгөөр буурсан байна.

Хүчиндэх гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн” гэмт хэрэгт шүүхээс нийт 130 хэргийн 139 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь өмнөх оноос хэрэг 12 буюу 8.4%-иар, хүн 7 буюу 4.8%-иар тус тус буурчээ.

Шүүхээс 36 хүнд 12 жил хүртэлх хорих, 101 хүнд 12-25 жилийн хорих, 2 хүнд бүх насаар нь хорих ял тус тус оногдуулсан байна.

Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан “Эрүү шүүлт тулгах” гэмт хэрэгт шүүхээс 2 хэргийн 2 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь өмнөх онтой ижил түвшинд байна. Шүүхээс дээрх шүүгдэгч нарт торгох ял оногдуулжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” 172 хэрэгт 172 шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ.

Шүүхээс 43 хүнд хорих ял, 52 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял, 47 хүнд торгох ял, 23 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, 6 хүнийг ялаас чөлөөлж, 1 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авчээ.

Хүүхэд хохирсон гэмт хэрэг

Улсын хэмжээнд хүүхэд хохирсон 689 гэмт хэрэгт 737 шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Шүүхээс 171 хүнд хорих ял, 275 хүнд торгох ял, 89 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял, 67 хүнд нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулж, 97 хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, 30 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 8 насанд хүрээгүй хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна.

4.4.Прокурор зөрчил хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанд оролцсон байдал

Захиргааны хэргийн шүүхийн зөрчил хянан шийдвэрлэх анхан шатны хуралдаанаар прокурорын 473 дүгнэлт хянан хэлэлцэгдсэнээс 446 дүгнэлт буюу 94.2% нь биелж, өмнөх оноос дүгнэлт 228 буюу 32.5%-иар буурч, биелэлт 3.2%-иар өссөн байна.

График 16.Зөрчил хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцсон байдал



Шүүх прокурорын дүгнэлтийг хүлээн авч, эрх бүхий албан тушаалтны 222 шийдвэрийг хүчингүй болгож, 224 шийдвэрт өөрчлөлт оруулан шийдвэрлэжээ.

График 17.Зөрчил хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцсон байдал



Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зөрчил хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанд прокурор 79948 оролцсон нь өмнөх оноос 1.5 дахин өсжээ.

Үүнээс прокурорын дүгнэлтээр 36724, оролцогчийн гомдлоор 133, эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авхуулах саналаар 43091 удаа тус тус оролцсон байна.

Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулах 31046, өөрчлөлт оруулахаар 5675, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг хүчингүй болгохоор бичсэн 3 прокурорын дүгнэлт тус тус хэлэлцэгдэж, 36304 буюу 98.8%-ийг шүүх хүлээн авч шийдвэрлэсэн нь өмнөх оноос дүгнэлт 30933 буюу 5.3 дахин, биелэлт 3.5%-иар тус тус өсжээ.

Зөрчил хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүх хуралдаанд 745 удаа оролцсон, прокурорын 221 эсэргүүцэл хэлэлцэгдэж, 72.8% нь биелсэн нь өмнөх оноос 1.3%-иар буурсан байна.

4.5.Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр

Прокурор төрийн байгууллагаас ирүүлсэн хүсэлт болон өөрийн санаачилгаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд 64.0 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн үнийн дүн бүхий төрийн ашиг сонирхол зөрчигдсөн 588, нийтийн эрх ашиг зөрчигдсөн 348, төр болон нийтийн эрх ашиг давхар зөрчигдсөн 1037, нийт 1973 хэрэг хянан шийдвэрлэж ажиллагаанд оролцсон байна.

Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон маргааны дийлэнх хувийг дараах төрлийн маргаан эзэлж байна.

Засгийн газрын тусгай сангуудаас олгосон 2.5 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсны улмаас төрд учруулсан 206.6 сая төгрөг, гэмт хэрэг, зөрчлийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан 330.3 сая төгрөг, төсөвт төлөгдөөгүй нийгмийн даатгал, татвар, газрын өр, төлбөр 28.4 тэрбум төгрөг, гэрээний үүргийн гүйцэтгэлийн төлбөр 4.2 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санд учирсан 603.4 сая төгрөг гаргуулах тухай маргаанууд байна.

Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажлын хүрээнд прокурор 25.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1335 нэхэмжлэл гаргасан нь өмнөх оноос 284 буюу 17.5%-иар буурч, мөнгөн дүн 15.4 тэрбум төгрөгөөр өсжээ.


Иргэний 1223 хэрэгт талууд шүүх хуралдаанаас өмнөх шатанд эвлэрснээр буюу хариуцагч төлбөрийг хүлээн зөвшөөрч төлөхөө илэрхийлснээр хэргийг хэрэгсэхгүй болгож, 3.9 тэрбум төгрөгийг төрд ашигтайгаар шийдвэрлүүлсэн нь өмнөх оноос 4.5 тэрбум төгрөгөөр буурсан.

Прокурор анхан болон давах, хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн 201 хэргийн шүүх хуралдаанд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж тайлбар гарган оролцсоноос 176 буюу 87.6%-ийг хангаж шийдвэрлэсэн нь өмнөх оноос 1.6%-иар өссөн байна.

4.6.Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, шийдвэрлүүлсэн хэрэг, үнийн дүнгийн байдал

Прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, 33.7 тэрбум төгрөгийг төр, нийтэд ашигтайгаар шийдвэрлүүлжээ.

Түүнчлэн, прокурор эрүүгийн 1615 хэргийн шүүх хуралдаанд төр, нийтийн ашиг сонирхолд учирсан 4.8 тэрбум төгрөгийн хохирлыг гэм буруутай этгээдээс гаргуулах хууль зүйн дүгнэлт гаргаснаас шүүх 4 тэрбум төгрөгийн хохирол, иргэний нэхэмжлэлийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлүүлсэн нь өмнөх оноос 150 хэргээр буюу 10.2%-иар өссөн байна.



Прокурор иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар төрийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учирсан эсэхэд дүгнэлт хийж, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

5. Ял эдлүүлэх ажиллагаанд тавьсан хяналт

5.1. Шалгалт, судалгаа, танилцах ажиллагаа

Прокурорын байгууллага нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 20 хорих анги, 1 сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, 28 цагдан хорих байр, 27 баривчлах байр, 25 саатуулах байрны үйл ажиллагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа, аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн 104 шийдвэр гүйцэтгэгчийн зөрчлийн шийдвэр гүйцэтгэх болон хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Прокурорын байгууллагаас ял эдлүүлэх ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа эсэхтэй 6740 удаа танилцаж, 901 шалгалт, 211 судалгаа хийж, шалгах, танилцах ажиллагааны явцад 2765 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 196 прокурорын шаардлага бичиж, 90 алба хаагчид сахилгын арга хэмжээ тооцуулжээ.

График 18. Ял эдлүүлэх ажиллагаатай танилцсан байдал



График 19. Ял эдлүүлэх ажиллагааг шалгасан байдал




Прокурорын байгууллагаас хийсэн шалгалт, судалгаа, танилцах ажиллагаа түүний мөрөөр авсан арга хэмжээг өмнөх онтой харьцуулбал, шалгалт 2.7%-иар, танилцах ажиллагаа 3.3%-иар, үүнээс гэнэтийн байдлаар танилцах ажиллагаа 1.3%-иар, илрүүлсэн зөрчил 21.1%-иар, хариуцлага тооцуулсан хүн 73%-иар тус тус өсөж, хийсэн судалгаа 30%-иар, бичсэн шаардлага 2.9%-иар тус тус буурчээ.

Шалгах, танилцах ажиллагаа нэмэгдэж, илрүүлсэн зөрчил, хариуцлага тооцуулсан хүний тоо өссөн нь шалгах, танилцах ажиллагааны чанар, үр дүнд анхаарч, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилласантай холбоотой байна.

5.2. Хорих ял эдлүүлэх ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст нийт 7226 хоригдол хорих ял эдэлснээс нээлттэй дэглэмд 5839, хаалттай дэглэмд 1304, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад өсвөр насны 83 хоригдол ял эдэлсэн ба нийт хоригдлын 481 буюу 6.6% нь эмэгтэй байна. Хоригдлын тоо өмнөх оноос 284 буюу 4.1%-иар өсжээ.


График 20. Хорих ял эдэлсэн хоригдлын тоо



5.3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа

Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн нийт 19117 ялтан, хуулийн этгээдийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж ажилласан нь өмнөх оноос 2285 буюу 13.5%-иар өсжээ.

График 21.Хорихоос өөр төрлийн ял эдэлсэн ялтны тоо



Энэ нь хуульд орсон нэмэлт өөрчлөлтэй холбоотой шүүхээс торгох ялаар шийтгүүлсэн 305, нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 297, эрх хасах ялаар шийтгүүлсэн 25, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн 91 ялтанд холбогдох шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүнгүй хүлээн авсантай холбоотой байна.

Торгох ялаар шийтгүүлсэн 10418 ялтан, хуулийн этгээдийн 23.8 тэрбум төгрөгийн торгох ялын биелэлтэд хяналт тавьж ажилласнаас 8051 ялтан, хуулийн этгээдийн 13 тэрбум төгрөгийн торгох ял бүрэн биелж, ялын биелэлт 100%-тай байна.

Зураг 10.Хорихоос өөр төрлийн бусад ялын биелэлтийг төрөл тус бүрээр нь харуулбал



Хорихоос өөр төрлийн ялыг биелүүлээгүй, биелүүлэхээс зайлсхийсэн торгох ял шийтгүүлсэн 107, нийтэд тустай ажил хийлгэх ялтай 246, зорчих эрх хязгаарлах ялтай 247 ялтны ялыг хорих ялаар солиулжээ.

Шүүхээс тогтоосон ялыг биелүүлэх хугацаа болоогүй 10.4 тэрбум төгрөгийн торгох ялтай 2177 ялтан, 9 хуулийн этгээд, нийтэд тустай ажил хийлгэх ялтай 583, зорчих эрх хязгаарлах ялтай 1242, эрх хязгаарлах ялтай 3343 ялтан хяналтад байна.

5.4.Тэнсэх, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, албадлагын арга хэмжээ

Тэнсэх, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, албадлагын арга хэмжээ авагдсан 7863 этгээдийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьсан нь өмнөх оноос 734 буюу 10.2%-иар өсжээ.

Тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн үндэслэлээр ял оногдуулахаар бичсэн дүгнэлт 12 байгаа нь өмнөх оноос 2 буюу 14.2%-иар буурсан бол ялаас чөлөөлөх дүгнэлт 20 буюу 1.8 дахин өссөн байна.

5.5.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

2024 онд зөрчлийн торгох шийтгэлээр шийтгүүлсэн 5474 хүн, 366 хуулийн этгээд, эрх хасах шийтгэлтэй 5461 хүн, 1 хуулийн этгээд, албадлагын арга хэмжээ авагдсан 5761 хүн, 111 хуулийн этгээдийн зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж ажилласан нь өмнөх оноос 797 буюу 4.8%-иар өссөн байна.

Дээрх хугацаанд 5474 хүний 1.7 тэрбум төгрөгийн торгох шийтгэлээс 5006 хүний 1.0 тэрбум төгрөгийн, 366 хуулийн этгээдийн 9.7 тэрбум төгрөгийн торгох шийтгэлээс 237 хуулийн этгээдийн 1.3 тэрбум төгрөгийн шийтгэл биелэгдсэн.

Нийт гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх хуудасны 89.7%, мөнгөн дүнгийн 21% биелэгдсэн нь өмнөх оноос биелүүлсэн гүйцэтгэх хуудас 2.9%-иар өсөж, мөнгөн дүн 32.9%-иар буурчээ.

5.6.Цагдан хорих, баривчлах, албадах байрны үйл ажиллагаа

Цагдан хорих төв /байр/-нд 2023 оны жилийн эцэст 1056, шинээр 4219, нийт 5275 хүн цагдан хоригдсон нь өмнөх оноос 206 буюу 3.7%-иар, Баривчлах төв /байр/-нд 2023 оны жилийн эцэст 555 хүн баривчлах шийтгэл эдэлж байсан бол шинээр 16184 хүн хүлээн авч нийт 16,739 хүн баривчлах шийтгэл эдэлсэн нь өмнөх оноос 2267 буюу 11.9%-иар тус тус буурсан байна.

Саатуулах байранд 2023 оны жилийн эцэст 6 хүн саатуулагдаж байсан бол шинээр 25,868 хүн хүлээн авч нийт 25,874 хүнийг эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг үндэслэн саатуулсан нь өмнөх оноос 4,597 буюу 21%-иар өсжээ.

Энэ нь зөрчилд холбогдсон согтуурсан хүнийг саатуулах тогтоолгүйгээр эрүүлжүүлдэг байсныг таслан зогсоож эрх бүхий албан тушаалтны саатуулсан тогтоолыг үндэслэн байранд хүлээн авч байгаатай холбоотой байна.

5.7.Прокурорын дүгнэлт, тогтоол, зөвшөөрөл

Прокурорын байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлүүлэх болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх, ял эдлүүлэх ажиллагааны явцад зөвшөөрөл авах, зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журмыг өөрчлөх зэрэг 4726 саналыг хянаж шийдвэрлэсэн нь өмнөх оноос 214 буюу 4.7%-иар өсжээ.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлүүлэхээр 2205 дүгнэлт бичиж шүүхээр шийдвэрлүүлсэн нь өмнөх оноос 10 буюу 0.4%-иар өссөн байна.

Хүснэгт 7.Прокурорын дүгнэлт

№	Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр бичсэн дүгнэлт		Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр бичсэн дүгнэлт		Тэнсэх, тогтоолын биелэлтийг хойшлуулсан, албадлагын арга хэмжээний чиглэлээр бичсэн дүгнэлт		
1	Хорих хугацаанаас суллаж, тогтоох	ялаас өмнө хяналт	1235	Хорих ялаар солих	600	Шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн хүнд ял оногдуулах	12
2	Хорих ял эдлүүлэх дэглэмийг солих		153	Өвчний учир ялаас чөлөөлөх	10	Шүүхийн тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийг ялаас чөлөөлөх	31
3	Өвчний учир ялаас чөлөөлөх		25	Бусад	60	Бусад	39
4	Бусад		40				
Нийт			1453		670		82

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журмыг түр өөрчлөх 341 зөвшөөрөл, ял эдлүүлэх нөхцөл журмыг өөрчлөх 388 тогтоол гаргаж шийдвэрлэсэн нь өмнөх оноос зөвшөөрөл 11.4%-иар, тогтоол 31.1%-иар тус тус өссөн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан уучлал үзүүлэхийг хүссэн 5 хоригдлын холбогдох материалыг хянаж, дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/10, А/03 дугаар тушаалаар хамтран баталсан “Хоригдлын ял эдлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ангийг солих тухай санал гаргах журам”-ын дагуу дэглэм, зэрэглэл өөрчлөхгүйгээр хорих анги солих тухай санал, танилцуулга нэгж прокурорын газраас 6 ирүүлснийг хянаж, 4 хоригдлын хорих анги солих зөвшөөрөл олгож, 2 хоригдлын хорих анги солих саналыг шаардлага хангаагүй үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.

Хоригдлыг хорих ангийн гадна хөдөлмөрлүүлэхээр прокурор 2218 зөвшөөрөл олгосон нь өмнөх оноос 322 буюу 16.9%-иар өссөн байна. Прокурорын зөвшөөрөлгүй хорих ангиас гадуур ажиллуулсан 34 хоригдлыг хорих ангид нь татан оруулсан.

Прокурор хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад 529 хоригдлын ял эдлэх зэрэглэлийг өөрчлөн тогтоосон нь өмнөх оноос 75 буюу 16.5%-иар өссөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны ял эдлүүлэх ажиллагаатай холбогдуулан гаргасан 1454 тушаал, шийдвэрийг прокурор хянаад, хууль зөрчсөн 23 тушаалыг хүчингүй болгож, 8 тушаалыг хуульд нийцүүлж зөвтгүүлэх арга хэмжээ авсан нь өмнөх оноос хянасан тушаал 5.2%-иар өссөн бол зөвтгүүлсэн тушаал 33.3%-иар, хүчингүй болгосон тушаал 41%-иар буурсан байна.


6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил

Прокурорын байгууллага Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Прокурорын тухай хуульд заасан эрх, үүргийн хүрээнд дараах ажил арга хэмжээг авч ажиллалаа.

6.1. Прокурорын мэдэгдэл

Гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар прокурор 1861 мэдэгдэл бичсэн нь өмнөх оноос 76 буюу 4.2%-иар өссөн байна.

График 22. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бичсэн мэдэгдэл



6.2. Хийсэн шалгалт, судалгаа

Прокурор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн шалгалтад 282 удаа оролцсон нь өмнөх оноос 30 буюу 11.9%-иар өсжээ.

График 23. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн шалгалт



Улсын болон орон нутгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн гаралт, түүний шалтгаан нөхцөлийг тогтоох судалгааг 200 хийсэн нь өмнөх оноос 33 буюу 14.1%-иар буурчээ.

График 24. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн судалгаа



Прокурорын байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн гаралт, түүний шалтгаан нөхцөлийг судалж, дүгнэлт хийн холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн байдал, гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан, нөхцөл”-ийг сүүлийн 2 жилийн байдлаар судалж, “Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа” гарын авлага гарган, нийслэл, дүүргийн прокуроруудад “Цахим орчин дахь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт, анхаарах асуудал” сэдвээр, Хүн худалдаалахтай тэмцэх хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох журмын талаар хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны асуудал эрхэлсэн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан;

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шийдвэрлэлт”-ийг сүүлийн 4 жилийн байдлаар судалж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд яриа, таниулга хийж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, цагдаагийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын хамтарсан багийн төлөөллийг хамруулан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд судалгаагаар тогтоогдсон нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал хүргүүлсэн;

“Хүүхдийн эсрэг болон хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шийдвэрлэлт”-ийн байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар судалж, гэмт хэрэг ихээр үйлдэгдсэн хороод, ерөнхий боловсролын сургуулиудад мэдэгдэл бичиж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага гарган тарааж, богино хэмжээний шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээсэн;

“Мансуурах” зөрчлийн гаралт, шийдвэрлэлтийн байдлыг сүүлийн 7 жилийн байдлаар судалж, судалгааны дүнг үндэслэн Улсын ерөнхий прокурорын тушаалаар Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн мансуурах зөрчлийг шалгах эрх бүхий байгууллагыг Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газарт, хяналт тавих харьяаллыг Нийслэлийн прокурорын газарт тогтоосон, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн засаг даргын тамгын газарт Улаанбаатар хотын хэмжээнд худалдаа эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд будаг шингэлэгчийг худалдан авах насны хязгаарт хяналт тогтоох, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон шийдвэр гаргах, хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох тогтолцоог бий болгох талаар санал хүргүүлсэн;

“Виртуал хөрөнгийн үйлчилгээний дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулан ашиглах” гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөл”-ийг сүүлийн 2 жилийн байдлаар судалж, сургалт зохион байгуулсан;

Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт заасан “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт, гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, түүний үр дүн”-г сүүлийн 3 жилийн байдлаар судалж, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн алба, Нийслэлийн байгаль орчны газар, Дэлхийн байгаль хамгаалах сан, Нийслэл, дүүргийн прокурорын газрын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан хүрээлэн буй орчны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ярилцлага хийж, постер бэлтгэн цахим сайтуудаар олон нийтэд хүргэсэн;

Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэгт заасан “Соёлын өвийн эсрэг” гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцөлийг 2018-2024 оны байдлаар судалж, Нийслэл, дүүргийн прокурорын газар, Соёлын яам, Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Соёлын өвийн үндэсний төв, Чингис хааны үндэсний музей, Гаалийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрыг тус тус хамруулан “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Дээрх үйл ажиллагаатай холбоотой шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн түүх соёлын дурсгалт зүйл болон эд мөрийн баримтаар хураан авч шинжээчийн дүгнэлтээр соёлын биет өв болох нь тогтоогдсон эд өлгийн зүйлсийг дэлгэсэн “Аврагдсан өв” тусгай үзэсгэлэнг Чингис хааны Үндэсний музейд дэлгэж танилцуулан, “Соёлын өвийн гэмт хэргийн шийдвэрлэлт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр олон нийтэд мэдээлэл хүргэсэн;

7.Прокурорын байгууллагаас авч хэрэгжүүлсэн зарим ажил, арга хэмжээ

Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хуульд зааснаар прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2024 онд хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан.

- “Монгол Улсын прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахаар прокурорын байгууллагын 2024 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, стратеги зорилтын 73.7%-ийг биелүүлсэн.

- Хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжийн зохицуулалт зэрэг тодорхой

сэдвээр мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор “Прокурор-Сэтгүүлч 2024” сургалтыг зохион байгуулж, сэтгүүлч, олон нийтэд үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд нээлттэй байдлаар мэдээлсэн.

- Харааны бэрхшээлтэй болон сул хараатай иргэдэд зориулан байгууллагын үйл ажиллагаа, гомдол, хүсэлт гаргах эрхтэй холбоотой мэдээллийг брайл үсгээр бэлтгэн гарын авлага, мэдээллийн хайрцгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

- Прокурорын байгууллагад гомдол, хүсэлт гаргах эрхтэй холбоотой мэдээллийг цахим брайл төхөөрөмжийн дейзи форматаар бэлтгэж, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран харааны бэрхшээлтэй иргэдийн ашигладаг цахим төхөөрөмжид суулгасан. Мөн байгууллагын цахим хуудсанд дэйзи форматтай ярьдаг ном, дохионы хэлмэрчтэй видео мэдээтэй танилцах боломж бүхий “Дохионы хэлтэй мэдээ” тусгай цонхыг ажиллуулж байна.

- Прокурорын байгууллагын талаарх олон нийтийн сэтгэл ханамжийн судалгааг судалгаа, зөвлөх үйлчилгээний байгууллагаар хийлгэж, хөндлөнгийн байгууллагын зөвлөмж гаргуулсан. Энэхүү судалгаагаар байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, прокурорт итгэх олон нийтийн итгэлийн дүн, индекс 5.1 оноогоор үнэлэгдэж өмнөх үнэлгээнээс 0.5%-иар өссөн эерэг үр дүн гарсан.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган прокурорын хяналтын ажлын чиглэл тус бүрээр статистик мэдээллийг улирал бүр prosecutor.mn, opendata.gov.mn сайтад байршуулж, нээлттэй, ил тод болгон иргэд, олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

- Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 57 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтын хөтөлбөрт 220 хичээл орсон байна.

- Улсын хэмжээнд бүх шатны прокурорын газруудаас байгууллагын дотоод үйл ажиллагаа, Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 879 судалгаа хийж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн 12 тушаал, журмыг шинээр болон шинэчлэн баталж, мөрдүүлснээс 5 журмыг бусад эрх бүхий байгууллагатай хамтран баталсан байна. Тухайлбал, Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/01 дүгээр тушаалаар “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн баталж, насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний шаардлагад гэрч, хохирогч хүүхэд, өсвөр насны сэжигтэн, яллагдагчтай ярилцах, мэдүүлэг авах ажиллагааг тэдгээрийн нас, бие, сэтгэл зүйн онцлогт тохирсон, хүүхдэд ээлтэй, тав тухтай орчинд явуулах, ярилцлага, мэдүүлгийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаас гадна Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын харьяа байгууллагуудад байгуулж болох зохицуулалтыг шинээр нэмж тусган олон улсын гэрээ, конвенцод нийцүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас байгуулсан хууль тогтоомж боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгүүдэд Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөл оролцож ажилласан ба 2024 онд прокурорын байгууллагаас 61 хуулийн төсөл, 13 заавар, журмын төсөлд санал боловсруулж, хууль санаачлагчид хүргүүлсэн байна.

Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хүрээнд. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны Албадан эрүүлжүүлэх журамд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан этгээдийг эрүүлжүүлэх байранд хүлээн авдаг зохицуулалттай байсныг

Зөрчлийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн батлуулж, хүний эрхийг хангах арга хэмжээ авсан.

Эрх бүхий албан тушаалтнаас хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээг холбогдох хууль, журамд заасан үндэслэл, журмын дагуу явуулж буй эсэхийг шалгаж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн хүнийг саатуулсан хугацааг хэзээнээс тооцох, шүүхийн саатуулах шийдвэрийг прокурорт хэрхэн хүргэх зохицуулалтын талаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих зөрчлийн гаралт, шийдвэрлэлтийн байдлыг судлахад, эрх бүхий албан тушаалтнууд нь иргэний үнэмлэхээ хаясан, гээгдүүлсэн, хулгайд алдсан зэрэг тохиолдолд “Монгол Улсын иргэний үнэмлэхийн дүрэм”-ийн 2.7-д заасан “иргэний үнэмлэхийг цэвэр гамтай эзэмших, хадгалах” үүргээ биелүүлээгүй, “Иргэний улсын бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн” гэж дүгнэн Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шийтгэл оногдуулж хууль буруу хэрэглэж буй нөхцөл байдал тогтоогдсон тул прокурорын дүгнэлт бичиж Улсын дээд шүүхээр хянан хэлэлцүүлж хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоолгосон.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын хамтын нийгэмлэг (GIZ), “Ай Ти Зон” ХХК-тай хамтран Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд мэдээлэл дамжуулах, улсын хэмжээнд зөрчлийн статистикийн нэгдмэл байдлыг хангах Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хүрээнд. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн хүрээнд Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/58 дугаар тушаалаар Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст Авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх албыг байгуулсан.

Тус албанаас авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянаж шийдвэрлэхэд прокуроруудыг мэргэшүүлэх чиглэлээр гадаад улс орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж, энэ төрлийн гэмт хэргийг шалгах, шийдвэрлэхэд анхаарах асуудлаар аргачлал гаргаж, авлигын гэмт хэрэг ба хөрөнгө буцаах ажиллагаа сэдэвт хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургагч багш бэлтгэн үе шаттай сургалтууд зохион байгуулж, прокурор, мөрдөгч нарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн.

Улсын ерөнхий прокурорын газраас санаачлан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба, Азийн сан, Ханнс-Зайделийн сантай хамтран “Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд НҮБ, ХБНГУ, АНУ-ын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн алба хаагч, эрдэмтэн судлаачдаас гадна Улсын дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газраас илтгэл хэлэлцүүлсэн ба мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, олон улсын сайн туршлага, мэдээллийг харилцан солилцож, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэн, нийтийн хүртээл болгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа”-ны “Шувуу” ажиллагааны хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гадаад улс руу оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлсний үр дүнд 108 сэжигтэн, яллагдагчийн байгаа газрыг тогтоож, гадаад улсаас 32 хэргийн 36 сэжигтэн, яллагдагчийг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулж, прокурор 27 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн, шүүхэд шилжүүлсэн.

Шүүхэд төрийг төлөөлөх ажлын хүрээнд. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор “Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон хэргийн шийдвэрлэлт, түүний хууль зүйн үндэслэл”-ийг улсын хэмжээнд судалж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудал” уулзалт, хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл хийсэн.

Хяналтын шатны шүүхээс 2020-2024 оны I улирлын байдлаар хэрэг хянан шийдвэрлэхдээ хийсэн дүгнэлт, тайлбар, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой төрлийн ажиллагааны шүүхийн практик, хуулийн үзэл баримтлал, онол, гадаад орны туршлага зэргийг цогцоор нь судалж, гаргасан судалгааны тайлан, зөвлөмжийг тусгасан “Гарын авлага” боловсруулан гаргасныг прокурорууд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хүрээнд. “Ял эдлүүлэх ажиллагаанд хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар зохицуулсан Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцын хэрэгжилт”-ийг шалгаж, Олон Улсын гэрээ конвенц, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хугацаатай албан бичиг, холбогдох хуульд нэмэлт оруулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад тус тус хүргүүлсэн.

Шалгалтын явцад хорих анги, байрны орох, гарах хэсэгт налуу шат хийх, хөдөлгөөн болон хэл яриа, харааны хөгжлийн бэрхшээлтэй хоригдол, ялтан, этгээдийг тусгай хэрэглэгдэхүүнээр хангах зэргээр орчин нөхцөл сайжирсан.

Шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.4 дүгээр зүйлд заасан хугацаанд харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлээгүй шийдвэрийг улсын хэмжээнд нэгтгэн судалж, хуульд заасан хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргэгдээгүй байсан 1299 гүйцэтгэх хуудсыг нөхөн бичүүлэх арга хэмжээ авсан.

“Хоригдлын түр, удаан хугацааны уулзалт хийх, захидал, илгээмж авах, утсаар ярих эрхийн хэрэгжилт”-ийг 2023, 2024 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд шалгаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга нарын хууль тогтоомж зөрчсөн зарим тушаал, шийдвэрийг хүчингүй болгож, хоригдлын зөрчигдсөн эрхийг сэргээсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны ял эдлүүлэх ажиллагаатай холбогдуулан гаргасан 1454 тушаал, шийдвэрийг прокурор хянаад, хууль зөрчсөн 23 тушаалыг хүчингүй болгож, 8 тушаалыг хуульд нийцүүлж зөвтгүүлэх арга хэмжээ авсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 789 удаа яриа таниулга, 195 сургалт зөвлөгөөн, 18 хэлэлцүүлэг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 215 мэдээ, мэдээлэл өгч, 180 гарын авлага гаргаж, олон нийтэд хүргэсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ШҮҮХ – COURT

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ
3. ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ



ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ ШИЙДВЭРЛЭЛТ



АНХАН ШАТНЫ ШҮҮХ



Оногдуулсан ял, шийтгэл



ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ



ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ



1.Товч танилцуулга


1.1.Шүүхийн байгууллагын үндсэн чиг үүрэг

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долоо дугаар зүйлийн 1-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” хэмээн заасан нь Монгол Улсад шүүх эрх мэдлийг шүүхээс өөр ямар ч төрийн байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх ёсгүйг хуульчлан тунхагласан явдал юм.

1.2.Шүүхийн тогтолцоо

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин найм дугаар зүйлд “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж хуульчилсан байдаг. Монгол Улсад нийт 117 шүүх байдаг ба дараах байдлаар зохион байгуулагддаг.

График 1.Монгол Улсын шүүхийн байгууллагын тогтолцоо



1.2.1.Анхан шатны шүүх

2024 онд УИХ-аас 2013 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Шүүх байгуулах тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж байлаа.

Хүснэгт 1.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх дүүрэг
2	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг
3	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг
4	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол дүүрэг
5	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Хан-Уул дүүрэг
6	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг

7	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багануур дүүрэг
8	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Налайх дүүрэг
9	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багахангай дүүрэг

Хүснэгт 2. Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 268 дугаар зүйлийн хүрээнд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх талаарх гомдлыг шийдвэрлэх, тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хяналт тавих ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа бусад байгууллагын ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээний талаар санал боловсруулах, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх зэрэг болно.

2.Хорих ялын гүйцэтгэл

2024 онд нийт 4586 хоригдол хорих ял эдэлсэн нь 2023 онд хорих ял эдэлсэн хоригдлын тоотой харьцуулахад 60 буюу 1.3%-иар өссөн байна.

Хүснэгт 1.Хорих ял эдлэгсдийн судалгаа

№	Өсөлт, бууралт			
	2023	2024	Тоо	Хувь
1	4526	4586	60	1.3%

2024 онд нийт хорих ял эдлэгсдийн 91.8% буюу 4208 хоригдол нь эрэгтэй, 7.2% буюу 330 нь эмэгтэй хоригдол, 1% буюу 48 хоригдол өсвөр насны хоригдол ял эдэлсэн байна.

Хүснэгт 2.Хорих ял эдлэгсдийн хүйсийн судалгаа

№	Хүйс	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Эрэгтэй	4211	4208	-3	-0.1
2	Эмэгтэй	279	330	51	+15.5
3	Өсвөр нас	36	48	12	+33.3

2024 онд нийт хоригдлын боловсролын түвшнийг судлахад 514 хоригдол дээд /доктор, магистр, дипломын дээд/ боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 38 буюу 7.98%-иар, 254 хоригдол тусгай мэргэжлийн дунд боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 26 буюу 11.4%-иар, 1725 хоригдол бүрэн дунд боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 17 буюу 1%-иар, 595 хоригдол бага боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 4 буюу 0.68%-иар тус тус өссөн, 24 хоригдол техникийн болон мэргэжлийн боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 4 буюу 14.29%-иар, 937 хоригдол суурь боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 5 буюу 0.53%-иар, 537 хоригдол ямар нэг боловсролгүй байсан нь урьд оныхтой харьцуулахад 16 буюу 2.89%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 3.Хорих ял эдлэгсдийн боловсролын судалгаа

№	Боловсролын зэрэг	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Дээд /доктор, магистр, дипломын дээд/	476	514	38	7.98
2	Тусгай мэргэжлийн дунд	228	254	26	11.4
3	Техникийн болон мэргэжлийн	28	24	-4	-14.29
4	Бүрэн дунд	1708	1725	17	1

5	Суурь	942	937	-5	-0.53
6	Бага	591	595	4	0.68
7	Боловсролгүй	553	537	-16	-2.89

Хорих байгууллагад хоригдож буй хоригдлуудын нийт эдлэх ялын хугацааг судлан үзэхэд 0-5 жил хүртэл хоригдох хугацаатай хоригдлын тоо урьд оныхтой харьцуулахад 110 буюу 5.3%-иар, 6-19 жил хоригдох хугацаатай хоригдлын тоо урьд оныхтой харьцуулахад 159 буюу 6.53%-иар тус тус буурсан, 20 ба түүнээс дээш жил хорих ял эдлэх хоригдлын тоо урьд оныхтой харьцуулахад 11 буюу 6.25%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4.Хорих ял эдлэх хугацааны судалгаа

№	Эдлэх хорих ялын хугацаа	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	0-1 жил	535	480	-55	-10.28
2	2 жил	500	450	-50	-10.00
3	3 жил	459	435	-24	-5.23
4	4 жил	299	304	5	1.67
5	5 жил	280	294	14	5.00
Нийт		2073	1963	110	-5.3
6	6 жил	347	360	13	3.75
7	7 жил	169	186	17	10.06
8	8 жил	264	254	-10	-3.79
9	9 жил	151	187	36	23.84
10	10 жил	181	199	18	9.94
11	11 жил	54	70	16	29.63
12	12 жил	277	300	23	8.30
13	13 жил	197	202	5	2.54
14	14 жил	116	134	18	15.52
15	15 жил	195	186	-9	-4.62
16	16 жил	112	120	8	7.14
17	17 жил	59	66	7	11.86
18	18 жил	115	122	7	6.09
19	19 жил	40	50	10	25.00
Нийт		2436	2277	159	6.53
20	20 ба түүнээс дээш	176	187	11	6.25

Нийт хорих ял эдлэгсдийн 23.35% нь хүний амьд явах эрхийн эсрэг, 26.58% нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 30.04% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд эзэлж байна.

Хүснэгт 5.Хорих ял эдлэгсдийн ял шийтгээгдсэн зүйлчлэлийн судалгаа

№	Гэмт хэргийн зүйлчлэл	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1056	1071	15	1.42
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	441	481	40	9.07
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1104	1219	115	10.42
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	26	24	-2	-7.69
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	3	2	200
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	16	60	44	275
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1576	1378	-198	-12.56
8	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	40	22	-18	-45

9	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	14	22	8	57.14
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	134	159	25	18.66
11	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	6	4	200
12	Авлигын гэмт хэрэг	11	25	14	127.27
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	6	2	-4	-66.67
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	13	5	-8	-61.54
15	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		1	1	
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	3	-2	-40
17	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	80	103	23	28.75
18	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	2	1	100

Нийт хорих ял эдлэгсдийн 34.82% нь Улаанбаатар хотын харьяат, 65.54% нь орон нутгийн харьяат, 0.63% нь гадаад улсын харьяат байна.

Хүснэгт 6.Хорих ял эдлэгсдийн орон нутгийн харьяаллын судалгаа

№	Орон нутаг	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Архангай	168	163	-5	-2.98
2	Баян-Өлгий	58	78	20	34.48
3	Баянхонгор	154	134	-20	-12.99
4	Булган аймаг	110	107	-3	-2.73
5	Говь-Алтай	104	97	-7	-6.73
6	Говьсүмбэр	46	44	-2	-4.35
7	Дархан	176	194	18	10.23
8	Дорнод	235	207	-28	-11.91
9	Дорноговь	138	127	-11	-7.97
10	Дундговь	100	96	-4	-4.00
11	Завхан	123	114	-9	-7.32
12	Орхон	156	148	-8	-5.13
13	Хэнтий	227	218	-9	-3.96
14	Ховд	118	128	10	8.47
15	Өвөрхангай	168	183	15	8.93
16	Өмнөговь	88	86	-2	-2.27
17	Сэлэнгэ	213	229	16	7.51
18	Төв	211	211	0	-
19	Хөвсгөл	156	154	-2	-1.28
20	Увс	124	146	22	17.74
21	Сүхбаатар	106	96	-10	-9.43
22	Улаанбаатар	1518	1597	79	5.20
23	Гадаад улсын харьяат	29	29	0	-

Нийт хорих ял эдлэгсдийн 44.2% нь анх удаа ял шийтгэгдсэн 55.8% нь хоёр ба түүнээс дээш удаа ял шийтгэгдсэн хоригдлууд байна.

Хүснэгт 7.Хорих ял эдлэгсдийн шүүхээр хэдэн удаа ял шийтгүүлсэн талаарх судалгаа

№	Хэдэн удаа	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Анх удаа	2029	2029	-	-
2	2 удаа	958	1014	56	5.85
3	3 удаа	544	565	21	3.86
4	4 удаа	358	350	-8	-2.23
5	5 удаа	268	254	-14	-5.22
6	6 удаа	160	148	-12	-7.50
7	7 удаа	102	112	10	9.80
8	8 удаа	55	59	4	7.27
9	9 удаа	27	25	-2	-7.41
10	10-ээс дээш удаа	25	30	5	20.00

2024 онд гадаад улсын харьяат 29 хоригдол ял эдэлснээс 18 буюу 62% нь БНХАУ-ын иргэн байжээ.

Хүснэгт 8.Хорих ял эдлэгсдийн иргэний харьяалал

№	Харьяалал	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Монгол Улс	4497	4557	60	1.33
2	БНХАУ	19	18	-1	-5.26
3	ОХУ	2	1	-1	-50
4	Бусад улс	8	10	2	25

2024 онд ШШГЕГ-ын харьяа хорих анги, цагдан хорих байрнаас 3 хоригдол оргосон нь урьд оны мөн үетэй харьцуулахад 2 буюу 200%-иар өссөн байна.

Хүснэгт 9.Хорих анги, цагдан хорих байрнаас оргосон хоригдол, хоригдогчийн судалгаа

№	Оргодлын тоо	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1		1	3	2	300

3. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний гүйцэтгэл

3.1.Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн дараах ялыг гүйцэтгэж байна. Үүнд:

Нэг.Хорихоос өөр төрлийн ял:

1. Торгох ял;
2. Нийтэд тустай ажил хийлгэх ял;
3. Зорчих эрхийг хязгаарлах ял;
4. Эрх хасах ял.

Хүснэгт 10.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэсэн хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл

Шүүхийн шийдвэрийн төрөл			Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
				2023	2024	2023	2024	2023	2024
Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн			Нийт ялтны тоо	16281	18611	11314	11677	4967	6934
Үүнээс:	Торгох ял шийтгүүлсэн	Хүнд	Ялтны тоо	9544	10295	7979	8185	1565	2110
			Мөнгөн дүн	17535376.8	22966674.9	10350882.9	13289676.3	7184493.9	9676998.6
			тоо	14	22	5	12	9	10

	Хуулийн этгээдэд	Мөнгөн дүн	337523.0	759944.8	174578.2	303929.3	162944.8	456015.5
Зорчих эрхийг хязгаарлах ял		Ялтны тоо	2834	2785	1669	1597	1165	1188
		Хоног	991043	893300	592918	523151	398125	370149
Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн		Ялтны тоо	1420	1693	1137	1145	283	548
		Цаг	492474	609014	406506	407306	85968	201708
Эрх хасах ял шийтгүүлсэн		Ялтны тоо	2469	3816	524	738	1945	3078
		Хоног	1883909	2717824	646242	837761	1237667	1880063

3.1.1. Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг (*нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү*) байхаар шүүх тогтоох ба шүүхийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй байдаг. Хэрэв шүүхээс оногдуулсан торгуулийг төлөөгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтны хөрөнгөөс албадан гаргуулах журмаар гүйцэтгэж байна.

Хүснэгт 11. Торгох ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	
			Нийт	Үүнээс ял сольсон		Нийт	Үүнээс ял сольсон
1	Архангай	196	168	2	210	176	1
2	Баян-Өлгий	149	98	-	241	181	-
3	Баянхонгор	119	97	-	160	138	-
4	Булган	145	116	-	166	138	-
5	Говь-Алтай	119	99	3	129	98	2
6	Говьсүмбэр	70	54	-	100	79	1
7	Дархан-Уул	323	265	7	337	262	4
8	Дорноговь	153	119	1	177	123	2
9	Замын-Үүд	80	66	-	108	90	-
10	Дорнод	257	220	5	283	212	2
11	Дундговь	108	87	-	149	141	-
12	Завхан	104	86	-	94	75	-
13	Тосонцэнгэл	50	49	-	36	35	-
14	Орхон	295	253	1	414	347	-
15	Өвөрхангай	139	134	-	185	169	1
16	Өмнөговь	105	88	-	127	97	-
17	Сүхбаатар	180	156	1	171	146	-
18	Сэлэнгэ	143	94	2	206	141	2
19	Хөтөл	57	45	-	62	46	-
20	Төв	231	207	2	226	190	1
21	Увс	148	110	-	182	155	-
22	Ховд	221	167	1	273	232	1
23	Хөвсгөл	259	226	2	338	274	-
24	Хэнтий	220	181	6	223	162	3
25	НШШГГ	5167	4367	111	5149	4061	86

26	Налайх	161	145	1	156	121	3
27	Багануур	105	85	3	120	91	1
28	Хархорин	82	74	1	85	58	-
29	Мандал	100	80	-	113	85	-
30	Ханбогд	58	43	1	75	62	2
Дүн		9544	7979	150	10295	8185	112

Хүснэгт 12.Торгох ял (хуулийн этгээдэд оногдуулсан)-ын гүйцэтгэлийн судалгаа
(аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	
			Нийт	Үүнээс ял сольсон		Нийт	Үүнээс ял сольсон
1	Баянхонгор	2	-	-	2	2	-
2	Дархан-Уул	1	-	-	2	2	-
3	Өвөрхангай	-	-	-	1	-	-
4	Төв	1	-	-	1	-	-
5	Налайх	-	-	-	1	-	-
6	НШШГГ	10	5	-	15	8	-
Дүн		14	5	-	22	12	-

3.1.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нийтэд тустай ажил хийлгэх ялыг гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлсгүйгээр хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар хийлгэх үйл явцад хяналт тавин, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүснэгт 13.Нийтэд тустай ажил хийлгэх ялын гүйцэтгэлийн судалгаа
(аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	
			Нийт	Үүнээс ял сольсон		Нийт	Үүнээс ял сольсон
1	Архангай	11	8	3	20	15	5
2	Баян-Өлгий	31	21	4	27	26	3
3	Баянхонгор	37	36	5	18	14	7
4	Булган	12	10	-	8	6	-
5	Говь-Алтай	8	5	2	9	7	-
6	Говьсүмбэр	7	6	3	10	8	1
7	Дархан-Уул	29	25	7	37	28	6
8	Дорноговь	26	21	11	14	13	5
9	Замын-Үүд	9	7	2	11	9	1
10	Дорнод	20	19	8	22	17	5
11	Дундговь	11	9	2	8	8	2
12	Завхан	17	16	-	15	12	2
13	Тосонцэнгэл	3	3	-	8	8	-
14	Орхон	22	17	7	22	17	5
15	Өвөрхангай	17	15	-	30	26	6
16	Өмнөговь	11	10	2	12	7	-
17	Сүхбаатар	12	9	1	10	6	3
18	Сэлэнгэ	20	16	1	28	18	4
19	Хөтөл	5	5	-	6	1	-

20	Төв	31	23	8	47	40	4
21	Увс	39	33	1	30	16	2
22	Ховд	33	27	4	23	19	2
23	Хөвсгөл	40	31	1	50	42	6
24	Хэнтий	49	31	9	47	29	6
25	НШШГГ	858	686	146	1098	687	188
26	Налайх	33	29	3	39	31	7
27	Багануур	11	8	2	16	10	3
28	Хархорин	7	7	1	6	4	1
29	Мандал	8	3	-	16	15	3
30	Ханбогд	3	1	-	6	6	2
Дүн		1420	1137	233	1693	1145	279

3.1.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхээс оногдуулсан нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглосон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 14.Эрх хасах ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл
1	Архангай	64	15	49	83	12	71
2	Баян-Өлгий	93	21	72	111	24	87
3	Баянхонгор	39	9	30	61	16	45
4	Булган	39	6	33	68	12	56
5	Говь-Алтай	33	7	26	79	11	68
6	Говьсүмбэр	18	3	15	33	5	28
7	Дархан-Уул	94	14	80	145	31	114
8	Дорноговь	37	9	28	77	13	64
9	Замын-Үүд	29	11	18	38	2	36
10	Дорнод	86	31	55	124	24	100
11	Дундговь	36	9	27	42	6	36
12	Завхан	26	6	20	36	9	27
13	Тосонцэнгэл	23	7	16	26	6	20
14	Орхон	74	10	64	134	22	112
15	Өвөрхангай	34	11	23	75	11	64
16	Өмнөговь	41	10	31	68	14	54
17	Сүхбаатар	47	16	31	74	17	57
18	Сэлэнгэ	41	8	33	71	10	61
19	Хөтөл	16	2	14	22	3	19
20	Төв	73	11	62	101	24	77
21	Увс	55	6	49	85	9	76
22	Ховд	85	26	59	122	19	103
23	Хөвсгөл	85	19	66	128	27	101
24	Хэнтий	39	10	29	79	14	65
25	НШШГГ	1148	221	927	1721	350	1371

26	Налайх	34	5	29	51	13	38
27	Багануур	12	4	8	30	4	26
28	Хархорин	21	4	17	60	10	50
29	Мандал	21	9	12	31	7	24
30	Ханбогд	26	4	22	41	13	28
Дүн		2469	524	1945	3816	738	3078

3.1.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэмт хэрэг үйлдсэн хүнийг өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэх шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 15.Зорчих эрхийг хязгаарлах ялын гүйцэтгэлийн судалгаа
(аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл
1	Архангай	64	37	27	48	29	19
2	Баян-Өлгий	74	50	24	65	39	26
3	Баянхонгор	55	35	20	64	38	26
4	Булган	30	22	8	34	24	10
5	Говь-Алтай	27	15	12	21	11	10
6	Говьсүмбэр	15	7	8	32	21	11
7	Дархан-Уул	81	48	33	107	47	60
8	Дорноговь	38	20	18	49	32	17
9	Замын-Үүд	20	15	5	23	12	11
10	Дорнод	134	96	38	98	68	30
11	Дундговь	22	14	8	21	12	9
12	Завхан	45	29	16	26	17	9
13	Тосонцэнгэл	17	14	3	14	7	7
14	Орхон	169	119	50	140	86	54
15	Өвөрхангай	62	38	24	63	43	20
16	Өмнөговь	11	9	2	17	6	11
17	Сүхбаатар	42	23	19	36	21	15
18	Сэлэнгэ	28	20	8	46	23	23
19	Хөтөл	20	16	4	20	14	6
20	Төв	87	59	28	68	47	21
21	Увс	79	31	48	69	41	28
22	Ховд	56	33	23	50	29	21
23	Хөвсгөл	64	33	31	70	40	30
24	Хэнтий	106	44	62	96	58	38
25	НШШГГ	1372	779	593	1361	739	622
26	Налайх	45	25	20	45	25	20
27	Багануур	26	18	8	35	27	8
28	Хархорин	18	9	9	25	19	6
29	Мандал	12	4	8	21	12	9

30	Ханбогд	15	7	8	21	10	11
Дүн		2834	1669	1165	2785	1597	1188

3.2.Албадлагын арга хэмжээний гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан дараах албадлагын арга хэмжээг гүйцэтгэж байна. Үүнд:

- 1. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
- 2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
- 3. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ;
- 4. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах;
- 5. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ.

Хүснэгт 16.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэсэн хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл

Албадлагын арга хэмжээний төрөл		Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
			2023	2024	2023	2024	2023	2024
			7671	8627	3777	4443	3894	4184
Үүнээс:	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	Этгээдийн тоо	2899	3194	1319	1500	1580	1694
	Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан	Этгээдийн тоо	181	176	75	109	106	67
	Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон	Этгээдийн тоо	2157	2263	1089	1159	1068	1104
	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	409	452	196	231	213	221
	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	63	56	25	18	38	38
	Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	1951	2471	1067	1420	884	1051
	Эрх хасах албадлагын арга хэмжээ авагдсан	Хуулийн этгээдийн тоо	11	15	6	6	5	9

3.2.1.Шүүхээс оногдуулсан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнссэн шийдвэрийг гүйцэтгэхдээ ялтны түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгж хяналт тавьж байна.

Хүснэгт 17. Тэнссэн этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он				2024 он			
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн	Одоо хяналтад байгаа	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн	Одоо хяналтад байгаа
1	Архангай	29	1	-	26	24	1	-	44
2	Баян-Өлгий	20		-	18	24	1	4	19
3	Баянхонгор	42	1	-	22	18	-	-	28
4	Булган	23	1	-	54	45	2	-	56
5	Говь-Алтай	32	1	-	35	39	-	1	64
6	Говьсүмбэр	4	1	-	3	4	-	1	5
7	Дархан-Уул	66	-	1	88	93	3	3	90
8	Дорноговь	24	-	1	26	21	1	-	50
9	Замын-Үүд	15	-	-	11	9	-	-	6
10	Дорнод	49	-	1	55	57	-	-	47
11	Дундговь	18	-	-	14	14	-	-	13
12	Завхан	28	2	-	31	31	-	1	15
13	Тосонцэнгэл	35	-	-	17	19	-	-	25
14	Орхон	52	1	2	53	51	-	1	37
15	Өвөрхангай	21	-	-	38	35	-	1	30
16	Өмнөговь	36	-	-	28	25	-	-	26
17	Ханбогд	20	-	-	14	12	-	-	5
18	Сүхбаатар	34	1	-	45	42	-	-	61
19	Сэлэнгэ	28	-	1	39	36	-	1	36
20	Хөтөл	8	-	-	12	7	-	-	11
21	Төв	48	-	-	41	34	1	1	46
22	Увс	46	1	-	36	37	-	-	48
23	Ховд	38	-	1	74	74	2	-	77
24	Хөвсгөл	64	-	2	68	62	-	1	93
25	Хэнтий	21	-	-	56	44	-	2	69
26	НШШГГ	435	10	13	612	585	3	6	604
27	Налайх	12	-	-	17	12	-	-	17
28	Багануур	5	-	-	5	6	-	-	13
29	Хархорин	19	-	-	23	23	-	-	33
30	Мандал	47	-	-	19	17	-	-	26
Дүн		1319	20	22	1580	1500	14	23	1694

3.2.2. Шүүхээс анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулсан шийдвэрийг ялтны оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас хяналт тавьж хэрэгжүүлж байна.

Хүснэгт 18.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1	Архангай	2	-	-	4	-	-
2	Баян-Өлгий	3	-	-	3	-	-
3	Баянхонгор	3	-	-	16	-	2
4	Булган	2	-	-	8	-	-
5	Говь-Алтай	-	-	-	-	-	-
6	Говьсүмбэр	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул	2	-	-	6	-	1
8	Дорноговь	-	-	-	1	-	-
9	Замын-Үүд	-	-	-	1	-	-
10	Дорнод	1	-	-	-	-	-
11	Дундговь	-	-	-	2	-	-
12	Завхан	-	-	-	-	-	-
13	Тосонцэнгэл	-	-	-	6	-	-
14	Орхон	5	-	-	5	-	-
15	Өвөрхангай	2	-	1	1	-	-
16	Өмнөговь	-	-	-	-	-	-
17	Ханбогд	1	-	-	-	-	-
18	Сүхбаатар	1	-	-	-	-	-
19	Сэлэнгэ	-	-	-	-	-	-
20	Хөтөл	-	-	-	1	-	-
21	Төв	5	-	-	5	-	-
22	Увс	1	-	-	1	1	-
23	Ховд	6	-	-	6	-	-
24	Хөвсгөл	2	-	1	-	-	-
25	Хэнтий	-	-	-	2	-	-
26	НШШГГ	35	-	2	38	1	1
27	Налайх	2	-	1	-	-	-
28	Багануур	-	-	-	1	-	-
29	Хархорин	-	-	-	2	-	1
30	Мандал	2	-	-	-	-	-
Дүн		75	0	5	109	2	5

3.2.3. Хорих анги нь хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийн талаарх тодорхойлолтыг шүүгчийн захирамжийн хамт түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлж, тухайн алба хяналтыг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 19.Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон этгээдүүдийн судалгаа
(аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1	Архангай	43	-	1	57	-	-
2	Баян-Өлгий	25	1	-	20	-	-
3	Баянхонгор	35	-	-	55	-	1
4	Булган	29	-	1	22	1	1
5	Говь-Алтай	16	1	1	17	2	1
6	Говьсүмбэр	9	-	-	11	-	-
7	Дархан-Уул	26	-	-	29	1	3
8	Дорноговь	17	-	-	14	-	-
9	Замын-Үүд	12	-	-	9	-	-
10	Дорнод	34	-	1	44	-	-
11	Дундговь	18	1	-	11	-	-
12	Завхан	15	-	-	13	-	-
13	Тосонцэнгэл	10	-	-	11	-	1
14	Орхон	33	-	3	38	-	2
15	Өвөрхангай	19	-	-	19	-	-
16	Өмнөговь	16	-	-	17	-	-
17	ханбогд	4	-	-	9	-	-
18	Сүхбаатар	8	-	1	20	-	-
19	Сэлэнгэ	18	-	1	22	-	-
20	Хөтөл	6	-	-	5	-	-
21	Төв	19	-	1	30	-	1
22	Увс	34	-	-	37	-	-
23	Ховд	20	-	-	25	-	1
24	Хөвсгөл	23	-	-	38	-	-
25	Хэнтий	34	-	2	48	-	-
26	НШШГГ	508	5	11	497	4	7
27	Налайх	16	-	-	14	-	1
28	Багануур	19	3	-	5	-	-
29	Хархорин	12	-	2	18	-	-
30	Мандал	11	1	-	4	-	-
Дүн		1089	12	25	1159	8	19

3.2.4.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэсэн шийдвэрийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, нэгдсэн тоо бүртгэл хөтөлж байна.

Хүснэгт 20. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа
(аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1	Архангай	1	-	-	17	-	-
2	Баян-Өлгий	6	-	-	7	-	-
3	Баянхонгор	4	-	-	8	-	-
4	Булган	-	-	-	6	-	-
5	Говь-Алтай	2	-	1	6	-	-
6	Говьсүмбэр	-	-	-	5	-	-
7	Дархан-Уул	3	-	-	7	-	1
8	Дорноговь	7	-	1	13	1	-
9	Замын-Үүд	4	-	-	5	-	-
10	Дорнод	2	-	-	4	-	1
11	Дундговь	2	-	-	3	-	-
12	Завхан	-	-	-	2	-	-
13	Тосонцэнгэл	-	-	-	-	-	-
14	Орхон	4	-	1	15	-	1
15	Өвөрхангай	5	-	-	2	-	-
16	Өмнөговь	2	-	-	8	-	-
17	Ханбогд	1	-	-	1	-	1
18	Сүхбаатар	1	-	-	1	-	-
19	Сэлэнгэ	1	-	-	7	-	1
20	Хөтөл	1	-	-	-	-	-
21	Төв	1	-	-	4	-	-
22	Увс	1	-	-	6	-	-
23	Ховд	1	-	-	5	-	1
24	Хөвсгөл	6	-	-	9	-	-
25	Хэнтий	4	-	-	5	-	-
26	НШШГГ	28	-	-	77	-	2
27	Налайх	1	-	-	4	-	-
28	Багануур	1	-	-	1	-	-
29	Хархорин	-	-	-	3	-	-
30	Мандал	-	-	-	-	-	-
Дүн		89	0	3	231	1	8

3.2.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

Хүснэгт 21.Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан этгээдүүдийн судалгаа
(аймаг, орон нутгаар)

№	Үзүүлэлт	2023 он			2024 он		
		Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Одоо хяналтад байгаа	Гүйцэтгэвэл зохиx	Гүйцэтгэсэн	Одоо хяналтад байгаа
1	Архангай	140	101	39	111	85	26
2	Баян-Өлгий	73	45	28	57	25	32
3	Баянхонгор	49	33	16	62	39	23
4	Булган	47	35	12	56	41	15
5	Говь-Алтай	78	30	48	96	56	40
6	Говьсүмбэр	8	1	7	17	10	7
7	Дархан-Уул	50	29	21	75	44	31
8	Дорноговь	62	35	27	70	29	41
9	Замын-Үүд	12	5	7	15	13	2
10	Дорнод	101	57	44	136	58	78
11	Дундговь	23	13	10	12	8	4
12	Завхан	62	47	15	30	22	8
13	Тосонцэнгэл	38	35	3	23	21	2
14	Орхон	45	35	10	26	20	6
15	Өвөрхангай	42	23	19	33	15	18
16	Ханбогд	10	3	7	11	4	7
17	Өмнөговь	12	6	6	16	6	10
18	Сүхбаатар	44	21	23	50	22	28
19	Сэлэнгэ	106	74	32	106	62	44
20	Хөтөл	32	23	9	40	33	7
21	Төв	51	29	22	100	77	23
22	Увс	91	57	34	93	67	26
23	Ховд	65	32	33	90	71	19
24	Хөвсгөл	93	55	38	139	106	33
25	Хэнтий	105	46	59	130	51	79
26	НШШГГ	409	122	287	730	336	394
27	Налайх	13	5	8	25	5	20
28	Багануур	14	10	4	13	7	6
29	Хархорин	42	33	9	28	15	13
30	Мандал	34	27	7	28	19	9
Дүн		1951	1067	884	2418	1367	1051

Хүснэгт 22.Хуулийн этгээдэд эрх хасах, татан буулгах албадлагын арга
хэмжээ авсан судалгаа

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он			2024 он		
			Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан
1	Баянхонгор	Этгээдийн тоо	1	1	1	1	-	1
2	Дархан-Уул	Этгээдийн тоо	-	1	-	1	1	1
3	Өвөрхангай	Этгээдийн тоо	-	-	-	-	1	-

4	Налайх	Этгээдийн тоо	-	-	-	-	1	-
5	Дорноговь	Этгээдийн тоо	2	-	-	-	-	-
6	Төв	Этгээдийн тоо	1	-	-	1	-	1
7	НШШГГ	Этгээдийн тоо	3	2	3	2	7	3
Дүн			7	4	6	5	10	6

Хүснэгт 23.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он			2024 он		
			Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан
1	НШШГГ	Этгээдийн тоо	44	19	25	38	18	18
Дүн			44	19	25	38	18	18

4.Баривчлах шийтгэлийн гүйцэтгэл

Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэж байна.

Хүснэгт 24.Баривчлагдсан этгээдийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)

№	Шийтгэлийн төрөл		Өсөлт, бууралт			
			2023	2024	Тоо	Хувь
1	Баривчлагдсан этгээд	Монгол Улсын иргэн	11016	9882	-1134	-10.3
		Гадаад улсын иргэн	11	13	2	18.9

Зөрчлийн тухай хуулийн:

5.1 дүгээр зүйл. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах;

5.2 дугаар зүйл. Танхайрах;

5.3 дугаар зүйл. Хүний биед халдах;

5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих;

5.8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих;

6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих;

6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах;

8.6 дугаар зүйл. Хулгайлах;

8.7 дугаар зүйл. Хөрөнгө завших;

14.7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зэрэг зөрчилд баривчлах шийтгэл ногдуулахаар тусгасан байна.

Хүснэгт 25.Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн судалгаа
(Улаанбаатар хотын хэмжээнд)

№	Зөрчлийн тухай хуулийн заалт	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах-Мансуурах /Зөрчлийн тухай хуулийн 5.1.3/	110	163	53	48.18
2	Танхайрах /Зөрчлийн тухай хуулийн 5.2.1 олон нийтийн газар/	696	897	201	28.88
3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /Зөрчлийн тухай хуулийн 5.4.4/	5490	5598	108	1.97
4	Хүний биед халдах /Зөрчлийн тухай хуулийн 5.3.1/	0	1	0	-

5	Жагсаал цуглаан зохион байгуулах журам зөрчих /Зөрчлийн тухай хуулийн 5.8.6/	1	0	0	-100.00
6	Хүүхдийн эрх зөрчих /Зөрчлийн тухай хуулийн 6.20.6/	9	10	1	11.11
7	Бэлгийн дарамт учруулах /Зөрчлийн тухай хуулийн 6.26/	13	15	2	15.38
8	Хулгайлах /Зөрчлийн тухай хуулийн 8.6.1/	383	256	-127	-33.16
9	Хөрөнгө завших /Зөрчлийн тухай хуулийн 8.7.1/	5	9	4	80.00
10	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /Зөрчлийн тухай хуулийн 14.7.5 эрхгүй үедээ согтуугаар/	4009	2618	-1391	-34.70

5.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй зэрэг үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийг ШШГЕГ-ын харьяа цагдан хорих төв, байрууд хэрэгжүүлж байна.

Хүснэгт 26.Цагдан хоригдсон хоригдогсдын судалгаа

№	Цагдан хорих байр	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Шүүгдэгч	3936	3536	-400	-10.16
2	Яллагдагч	2908	2791	-117	-4.02
3	Сэжигтэн	975	534	-441	-45.23

--oOo--

ТАВДУГААР БҮЛЭГ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР - ANTI-CORRUPTION AGENCY

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
3. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА
4. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ,
ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ
5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН
ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ
6. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС, ТҮҮНИЙ
ҮР ДҮН
7. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ



ГЭМТ ХЭРГИЙН
ШИНЖТЭЙ

1513

ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ
БҮРТГЭЛД ОРУУЛАН ШАЛГАСАН

ХУУЛЬД ЗААСАН ХАРЬААЛЛЫН

2216 үйлдэлтэй
1436 холбогдогчтой
1863 хэрэгт



ХЭРЭГ БҮРТГЭЛТ,
МӨРДӨН БАЙЦААЛТЫН
АЖИЛЛАГАА ЯВУУЛАВ

ШҮҮХЭЭР 216 хэрэг эцэслэн
шийдвэрлэгдсэн



МӨРДӨН ШАЛГАХ
АЖИЛЛАГААНЫ
ЯВЦАД



23.589.470.251
ТӨГРӨГИЙГ БИТҮҮМЖЛЭН
ХАМГААЛАВ



240.940.060.451
ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ
НӨХӨН ТӨЛҮҮЛЭВ

1.Товч танилцуулга

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулдаг.

Тус газар нь Авлигын эсрэг хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд дараах хэлтэс, албадаас бүрдэнэ.

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтэс;
- Гүйцэтгэх ажлын хэлтэс;
- Мөрдөн шалгах хэлтэс;
- Судалгаа шинжилгээний алба;
- Тамгын хэлтэс;
- Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс;
- Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс.

Авлигатай тэмцэх газар дараах чиг үүрэгтэй:

1.Олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;

- Авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх;

- Төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

- Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаа дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх;

- Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.

1. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах;

- Мэдүүлэг гаргагчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.

Авлигатай тэмцэх газар дараах бүрэн эрхтэй:

- Авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

- Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;

- Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадалгаа гаргуулах;

- Авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

- Авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах;

- Хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

- Чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах;


- Өөрийн байгууллага, ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

- Гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулан авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

- Хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, авлигын эсрэг хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх.

2. Гомдол, мэдээлэл

2024 онд гэмт хэргийн талаарх 1789 гомдол, мэдээллийг хүлээн авч, өмнөх оны үлдэгдэл 114 буюу нийт 1903 гомдол, мэдээллээс 390 гомдол, мэдээллийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-д заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлж, 1513 гомдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

График 1. Хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

2024 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан өмнөх оны үлдэгдэл 58, энэ оны 1455, нийт 1513 гомдол, мэдээллээс 676 гомдол, мэдээлэл буюу 44.7%-д хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 789 гомдол, мэдээлэл буюу 52.1%-д хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 40 гомдол, мэдээлэл буюу 2.6%-ийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 8 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 99.5%-тай байна.

Хүснэгт 1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гомдол, мэдээллийн сүүлийн 5 жилийн шийдвэрлэлтийн харьцуулсан тоо

№	Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	487	594	684	870	789
2	Харьяаллын дагуу шилжүүлсэн	27	44	52	44	40
3	Эрүүгийн хэрэг үүсгэсэн болон хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	462	460	621	701	676
4	Ажиллагаанд	44	46	56	55	8
5	Нийт шалгасан гомдол мэдээлэл	1020	1144	1413	1670	1513

Нийт хүлээн авсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдох албан тушаалын ангиллаар нь авч үзвэл, төрийн улс төрийн 238, төрийн захиргааны 470, төрийн тусгай 706, төрийн үйлчилгээний 147, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 170, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 172 байна.

Хүснэгт 2. Гомдол, мэдээлэлд холбон шалгасан этгээдийн албан тушаалын байдал

№	Үзүүлэлт	Тоо	Хувь
1	Төрийн тусгай	706	37.1
2	Төрийн захиргааны	470	24.7
3	Төрийн улс төрийн	238	12.5
4	Бусад хуулийн этгээдийн	172	9.0
5	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн	170	8.9
6	Төрийн үйлчилгээний	147	7.7
7	Нийт	1903	100

3. Мөрдөн шалгах ажиллагаа

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл:

Мөрдөн шалгах хэлтсээс хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оноос 253 нэгжээр буюу 11.7%-иар буурсан үзүүлэлттэй байна.

График 2.Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тоо





График 3.Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1513 гомдол, мэдээллийн 883 буюу 58.4%-ийг Улаанбаатар, 630 буюу 41.6%-ийг орон нутгийн гомдол, мэдээлэл эзэлж байна.

Эрүүгийн хэргийн талаар:

2024 онд хуульд заасан харъяаллын 2216 үйлдэлтэй, 1436 холбогдогчтой, 1863 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх онтой харьцуулбал 1.4%-иар өссөн байна (2023 онд 1837 хэрэг шалгасан).

Шалгагдсан гэмт хэргийн үйлдэл өмнөх оноос 1.5%-иар, холбогдсон хүн хуулийн этгээд 2.4%-иар өссөн байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 54.1%-тай, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн тоо өмнөх оноос 3.1%-иар өссөн байна. Мөн 2024 онд шүүхээр 216 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 12.5%-иар өссөн байна (2023 онд 192 хэрэг шүүхээр шийдвэрлэсэн).

График 4.Шүүхээс шийдвэрлэгдсэн хэрэг




График 5.Хэргийн шийдвэрлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)





График 6.Ажиллагаанд байгаа хэргийн тоо (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Хүснэгт 3.Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал

№	Эрүүгийн хуулийн зүйл хэсэг	2023 он	2024 он
1	22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	1249	1327
2	22.4 дүгээр зүйл. Хахууль авах	290	270
3	22.5 дугаар зүйл. Хахууль өгөх	161	183
4	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	32	23
5	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүй хөрөнгөжих	67	66
6	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	53	36
7	18.6 дугаар зүйл. Мөнгө угаах	55	63
8	21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	24	46
9	Бусад	252	202

2024 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт холбогдон шалгагдсан хүний 133 буюу 9.3%-ийг төрийн улс төрийн, 290 буюу 20.2%-ийг төрийн захиргааны, 241 буюу 16.8%-ийг

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2024

төрийн тусгай, 205 буюу 14.3%-ийг төрийн үйлчилгээний, 106 буюу 7.4%-ийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 461 буюу 32.1%-ийг бусад албан тушаалтан эзэлж байна.

Хүснэгт 4.Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн албан тушаалын ангилал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)


№	Албан тушаалын байдал	2023 он	2024 он
1	Төрийн үйлчилгээний албан тушаалтан	159	205
2	Төрийн захиргааны албан тушаалтан	229	290
3	Төрийн тусгай албан тушаалтан	206	241
4	Төрийн улс төрийн албан тушаалтан	144	133
5	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн	105	106
6	Бусад	559	461
7	Нийт	1402	1436

4.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хохирол нөхөн төлүүлэлт, авлигын хэмжээ, улсын орлого болгосон хөрөнгө

2024 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 417.247.706.374.04 (дөрвөн зуун арван долоон тэрбум хоёр зуун дөчин долоон сая долоон зуун зургаан мянга гурван зуун далан дөрөв) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 240.940.060.451.75 (хоёр зуун дөчин тэрбум есөн зуун дөчин сая жаран мянга дөрвөн зуун тавин нэг) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 23.589.470.251.00 (хорин гурван тэрбум таван зуун наян есөн сая дөрвөн зуун далан мянга хоёр зуун тавин нэг) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Нийт учирсан хохирлын 57.7%-ийг нөхөн төлүүлж, хахуулийн 50.201.714.856.00 (тавин тэрбум хоёр зуун нэг сая долоон зуун арван дөрвөн мянга найман зуун тавин зургаа) төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан байна. Хохирол нөхөн төлүүлэлт өмнөх оноос 0.9%-иар, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 38.0%-иар өссөн үзүүлэлттэй байна.

График 7.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



5.Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил

Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах,

хэрэгжилтэд нь хяналт тавих, авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг судлан авлигыг олон нийтэд мэдээлэх, судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй гүйцэтгэж, үр дүнг тооцон ажилладаг.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Авлигын гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэх бүрэн эрхийн хүрээнд 2023 онд 63 дүрэм, журам, тушаал шийдвэрийг хянан үзэж, 44-ийг нь хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулах, хүчингүй болгуулах зорилгоор 17 албан бичиг хүргүүлсэн. Үүнээс 8 шийдвэр хүчингүй болж, 1 шийдвэрийг хуульд нийцүүлж, 2 шийдвэрийг хуульд нийцүүлэн өөрчлөн найруулсан. 2024 онд нийт 17 салбарт хамаарах 68 шийдвэр, дүрэм, журам, тогтоол хянасан ба 7 шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгож, 1 журмын холбогдох хэсгийг хүчингүй болгон, хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулсан.

2. Авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, авлигын шинжтэй үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр 2023 онд 38 байгууллага, албан тушаалтанд нийт 45 зөвлөмжийг боловсруулан хүргүүлсэн бол 2024 онд 26 байгууллагад 32 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3. Эрсдэлийн түвшнийг харгалзан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг ялгавартай зохион байгуулж, багц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын удирдлагаас баталсан удирдамжийн дагуу 2023 онд 44 төрийн байгууллагад, 2024 онд 14 төрийн байгууллагад хяналт шалгалт хэрэгжүүлж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хүрээнд 7 зөвлөмж, 2 албан бичгийг хүргүүлсэн.

Соён гэгээрүүлэх чиглэлээр:

Авлигын нийгмийн хор аюулын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй явуулах, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран цахим болон танхимын нийт 286 удаагийн сургалтыг зохион байгуулж, тухайн сургалтуудад нийт 36866 хүнийг хамруулснаас төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 272 удаагийн сургалтад 35738 ажилтан, албан хаагч, хувийн хэвшлийн байгууллагад 6 удаагийн сургалтад 717 ажилтан, албан хаагч, мөн 8 удаагийн сургалтад 411 оюутан, залуус, иргэдийг хамруулсан.

Авлигын эсрэг хуулиар төрийн байгууллагад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх, сургагч багш бэлтгэх, чадавхжуулах, мэдээлэл, арга зүйгээр хангах, тэднийг авлигын эсрэг үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор 2023 онд эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хамгаалал, батлан хамгаалах салбарын болон төрийн өмчит компанийн төлөөлөл бүхий нийт 90 ажилтан, албан хаагчийг “Сургагч багш” бэлтгэх анхан шатны сургалтад хамруулж, гэрчилгээ олгосон бол 2024 онд нийт 36 салбар байгууллагын 42 ажилтан, албан хаагчийг сургагч багшаар бэлтгэн, гэрчилгээ олгосон байна.

Иргэдэд авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийн хажуугаар дуугүй өнгөрөхгүй байх, авлигын гэмт хэргийг мэдээлэхийг уриалах, авлигатай тэмцэхэд хүн бүрийн оролцоо чухлыг сурталчлах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдэл, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэлийг бууруулах, шүгэл үлээхийг уриалсан.

Төрийн нийт 23 байгууллагатай хамтран үйл ажиллагааны онцлог, төрийн үйлчилгээний хүнд суртал чирэгдлийг бууруулах, ил тод байдлыг сайжруулах, шүгэл үлээх болон авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах агуулгатай, бодит кейс, жишээн дээр тулгуурласан нийт 51 контент (шторк, рийлс, видео гэх мэт) бүтээж тухайн байгууллагын цахим хуудас болон нийгмийн цахим сүлжээний хуудаснуудад байршуулан сурталчилсан.

Монгол Улсын Хүүхэлдэйн театрт хамтран “Хаалган хадны нууц” нэртэй хүүхэлдэйн жүжгийг мэргэжлийн түвшинд тайзны бүтээл болгон зорилтот бүлгийн болон ерөнхий боловсролын 1-5 дугаар ангийн 1154 хүүхэд, багачуудад үнэ төлбөргүйгээр үзүүлж, тэдэнд шударга ёсны үзэл хандлагыг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулсан.

Улсын хэмжээнд нэгдсэн хөтөлбөр, удирдамжийн дагуу Авлигын эсрэг өдрийг угтан “Авлигын эсрэг нэгдье” сургалт-өдөрлөгийг нийслэлийн 9 дүүрэг болон 21 аймагт зохион байгуулж, нийт 10558 албан тушаалтныг авлигаас урьдчилан сэргийлэх цогц сургалтад хамруулж, чадавхжуулсан.

Нийгмийн амьдралд оюутан, залуусын бодит оролцоо, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, тэднийг дэмжиж хамтран ажиллах замаар шударга, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх зорилготой “Түлхүүр” уралдааныг төрийн болон төрийн өмчийн бус 56 их, дээд сургуулиудын дунд зохион байгуулсан.

2024 онд нийт 85 контент (шторк, контент, рийлс, подкаст, нэвтрүүлэг) бэлтгэн, олон нийтэд хүргэсэн. Үүнд: Авлигатай тэмцэх газраас 23 мэдээ, нэвтрүүлгийг бэлтгэн МҮОНТВ, цахим сувгуудаар, “110 подкаст”-ын 11 дугаар, сурталчилгааны богино шторк 25, богино видео рийлс 27-г бэлтгэн, байгууллагын фейсбүүк дэх цахим хуудсанд байршуулсан. 7 радио нэвтрүүлэг, 160 богино мэдээллийн цувралыг бэлтгэн 3 сувгаар дамжуулсан. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн болон байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийг нийт 20 сэдвийн хүрээнд, 240 цуврал болгон бэлтгэж Дэлхийн монголчуудын радио “MGL” радиогийн “Нэг дусал” контентоор сар бүр тогтмол дамжуулсан. Сувгийн тоог нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд “Зохист аялгуу” 89.7, Авто радио 96.3 радиотой хамтран авлигын эсрэг сурталчилгааны контент, байгууллагын онцлох контентыг түгээх ажлыг эхлүүлээд байна. Дээрх ажлын хүрээнд Авто радио 96.3-аар “Авлигатай тэмцэх газрын цаг” тусгай нэвтрүүлгийг санаачлан 14 дугаарыг олон нийтэд хүргэсэн.

6. Монгол Улсын авлигын индекс, түүний үр дүн

“Транспэрэнси интернэшнл” олон улсын байгууллага жил бүр Авлигын төсөөллийн индексийг тооцон гаргадаг бөгөөд энэ нь дэлхийн 180 гаруй улсыг хамарсан үзүүлэлт юм. Тус индексийг 13 байгууллагын судалгаа, үнэлгээг эх сурвалж болгон, авлига болон түүнд холбогдох тодорхой үзүүлэлтийг сонгон авч 0-100 оноогоор тодорхойлдог. Монгол Улсын хувьд 2023 онд 7 эх сурвалжийн үнэлгээг ашиглан тооцсон бол 2024 онд 8 эх сурвалжийн үнэлгээгээр Авлигын төсөөллийн индексийг гаргасан байна.

Манай улсын авлигын төсөөллийн индексийн сүүлийн таван жилийн оноо, байр:

2020 онд 35 оноо авч, 180 улсаас 111 дүгээр байрт;

2021 онд 35 оноо авч, 180 улсаас 110 дугаар байрт;

2022 онд 33 оноо авч, 180 улсаас 116 дугаар байрт;

2023 онд 33 оноо авч, 180 улсаас 121 дүгээр байрт;

2024 онд 33 оноо авч, 180 улсаас 114 дүгээр байрт.

Авлигын төсөөллийн индексийн дэлхийн дундаж үзүүлэлт 43 оноотой байх ба сүүлийн 13 жилийн хугацаанд өөрчлөлтгүй хэвээр байна. Нийт улс орнуудын гуравны хоёр нь 50-с

доош оноотой үнэлэгдсэн нь дэлхий дахинд авлигын түвшин өндөр хэвээр байгааг харуулахаас гадна авлигыг бууруулах хүчин чармайлт суларч байгааг илэрхийлж байна.

7. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авхуулахаар мөрдөгчийн мэдэгдлийг бичиж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу 2023 онд 167 мөрдөгчийн мэдэгдэл бичиж 125 хариуг, 2024 онд 224 мөрдөгчийн мэдэгдэл бичиж 187 хариуг хүлээн авч, үр дүнг тооцсон. Мөн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хууль хэрэгжүүлэх, зөрчил арилгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авхуулахаар 2023 онд 83, 2024 онд 60 албан бичгийг хүргүүлж, хариуг авч ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2024 оны 5 дугаар сард Авлигатай тэмцэх газарт ажиллаж, байгууллагын үйл ажиллагаатай танилцсан. Монгол Улсад Авлигатай тэмцэх төрийн тусгай байгууллага үүсэн байгуулагдсанаас хойш анх удаа Монгол Улсын Төрийн тэргүүн байгууллагын үйл ажиллагаатай танилцахаар ирсэн түүхэн үйл явдал болсон бөгөөд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "Авлигын гэмт хэргийг илрүүлэх, гадаад улс руу оргон зайлсан этгээд болон гадаад руу хууль бусаар шилжүүлсэн хөрөнгийг буцаан авчрах чиглэлээр ажиллаж байгааг сайшааж, цаашид улс төр, бизнесийн явцуу ашиг сонирхолд үйлчлэх, улс орныхоо язгуур эрх ашгаас урвах, гэмт этгээдэд ял завшуулах, төрийн албаны нэр хүндийг бусдад худалдах, гэмгүй хүнийг хэлмэгдүүлэх, өөрсдөө бусдад худалдагдахын эсрэг байх, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын арга барилаа өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа"-г онцолсон.

Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар болон УИХ-ын нэр бүхий гишүүд 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцаж хууль, эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд санал солилцож, УИХ-ын дарга Д.Амарбаясгалан "...авлига бол хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил гэдгийг тодотгоод Монгол Улсад өргөн хэрэглэгдэж байгаа 318 хуулийн зүйл, заалт тус бүрд судалгаа хийхэд хүний эрхийн зөрчилтэй 800 гаруй заалт байгааг тогтоосон учраас энэ парламент тэдгээр зүйл заалтыг засахаар ажиллаж эхэлсэн..." талаар, нийгмийн харилцааны 70%-ийг журмаар зохицуулж байгаа нь авлига үүсэх, албан тушаалаа урвуулан ашиглах үндэс суурь болж буйг дурдсан. УИХ-аас 2023 онд баталсан 2023-2030 онд хэрэгжих "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", 2024 онд баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа УИХ-д, олон нийтэд илүү мэдээлж байх, авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд анхаарлаа хандуулан ажиллах талаар чиглэл болгосон байна.

Авлигын гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэхийн тулд гэмт хэргийн замаар олсон гадаад улс дахь хууль бус хөрөнгийг буцаах ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод үндэслэн хэрэгжүүлснээр 2020 оноос хойш нийт 13.9 сая ам.долларын хөрөнгийг Монгол Улсад буцаан авчирч, улсын орлого болгосон.

Дэлхийн банкны 19.5 сая ам.долларын санхүүжилттэй "Цахим эрүүл мэнд" төсөл 6 жил үргэлжилсэн ч үр дүн гараагүй бөгөөд аудитын дүгнэлтээр хангалтгүй үнэлэгдсэнтэй холбогдуулан Дэлхийн банкнаас уг төслийг зогсоож, улмаар Монгол Улсын Засгийн газраас

нийт 1.7 сая ам.долларыг нэхэмжилсэн. Тус газрын Гүйцэтгэх ажлын хэлтэс, Мөрдөн шалгах хэлтсээс Дэлхийн банктэй мэдээлэл солилцох замаар гадаад улсын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажилласнаар төслийн гүйцэтгэгч БНСУ-ын “Taihan Cable & Solution” компани нь хуурамч баримт бичиг бүрдүүлэх замаар төслийн сонгон шалгаруулалтад шалгарч, улмаар гэрээнд тусгагдсан төслийн хөрөнгийг үр дүнгүй захиран зарцуулан улсад их хэмжээний хохирол учруулсан болохыг тогтоон тус компаниас 1.7 сая ам.долларын хохирлыг Монгол Улсад эргүүлэн төлүүлж, төсвөөс дээрх зээлийн төлбөрийн хүүг төлж байсныг зогсоосон.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн баталж тус хорооны дэд даргаар Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга ажиллаж байна. Уг хороо нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг баталж, тус журамд нийцүүлэн “Мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт нөхөх заавар”, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт нөхөх заавар”, “Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт нөхөх заавар”-ыг мөн баталсан.

Гадаад харилцааны чиглэлээр:

Самоа Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II, V бүлгийн хэрэгжилтийн хоёрдугаар шатны үнэлгээний багийн бүрэлдэхүүнд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), Папуа Шинэ Гвиней Улсын шинжээчидтэй хамтран ажиллаж, Самоа Улсын хөрөнгө буцаах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаарх тайланг үнэлж, үнэлгээний тайлан, зөвлөмжид тусгуулах саналыг бэлтгэн НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-нд хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр:

Монгол Улсын Их хурлын 2024 оны 46 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсантай холбогдуулан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, улсын хэмжээнд хэрэгжүүлэгч байгууллагуудын болон хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны 2 удаагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэл ажлыг хангаж, дараах асуудлуудыг шийдвэрлүүлсэн. Үүнд:

➤ ISO37001: Авлигын эсрэг менежментийн тогтолцоог төрийн өмчит хуулийн этгээдэд нэвтрүүлэх тухай;

- Төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах тухай;
- Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах тухай;
- Алдагдалтай ажилласан төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны аудитын үнэлгээнд үндэслэн авах арга хэмжээний тухай;
- Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах тухай;
- Үндэсний шударга байдлын тогтолцооны үнэлгээ хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах Зөвлөлдөх хороо байгуулах тухай;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах тухай.

Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр:

“Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээлэл цуглуулах, тайланг бэлтгэж, үр дүнг олон нийтэд мэдээлэх” ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд судалгаанд төрийн 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн болон нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийт 81 байгууллага хамрагдсан бөгөөд үнэлгээний 2024 оны дундаж 72.6 оноотой гарч, өмнөх оноос 4.0 оноогоор буурсан үзүүлэлттэй байна. “Шударга байдлын үнэлгээ”-ээр доогуур үнэлэгдсэн байгууллагуудын үзүүлэлтүүдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулсан.

“Хүүхдийн шударга байдлын үнэлгээ” 2024 оны судалгааг 21 аймаг, нийслэлийн төрийн өмчийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 6670 сурагч, 789 багш, албан хаагч, 1293 эцэг, эхийг хамруулан зохион байгуулсан. Судалгааны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин 2024 онд 4.05 оноотой гарсныг 2023 онтой харьцуулбал 0.08 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Судалгаагаар хүүхдийн насны онцлогт тохирсон шударга ёсыг таниулах, шударга байх талаарх сургалт, сурталчилгааг тогтмол явуулах, сургуулийн орчноос гадна эцэг эхчүүдийн дэмжлэг, хамтын ажиллагааг чухал шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарчээ.

“Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага” (IDLO)-тай хамтран “Авлига ба жендер” судалгааг гүйцэтгэсэн. Энэхүү судалгаа нь Монгол Улсад анх удаа хийгдсэн бөгөөд судалгаагаар авлига нь жендертэй тодорхой хамааралтай байна гэсэн үр дүн гарсан. Судалгааны үр дүнд үндэслэн хэлэлцүүлгийг зохион байгуулж, дүнг олон нийтэд нээлттэй мэдээлсэн.

Хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын талаар:

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээнээс үзэхэд 717 албан тушаалтан “Хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, 35951 албан тушаалтан “Тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл”, 656 албан тушаалтан “Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан байна.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3 дахь заалтыг хэрэгжүүлэх, төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтэд мэдээлэл авах боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуйг <http://www.хасхот.iaас.mn> цахим хуудсанд 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр нээлттэйгээр байршуулсан.

Хянан шийдвэрлэсэн 281 мэдүүлгийн 154 буюу 54.8%-ийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 97 буюу 34.5%-ийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр, 30 буюу 10.7%-ийг иргэдээс гаргасан гомдол, мэдээллийн мөрөөр шалгасан байна.

Хяналт шалгалтаар нийт 49 албан тушаалтанд, үүнээс Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар 7 мэдүүлэг гаргагчид сануулах, тус зүйлийн 13.8.2-т зааснаар 24 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл 30%-иар бууруулах, 13.8.3-т зааснаар 16 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг тодорхой хугацаагаар тодорхой хувиар бууруулах, 1 мэдүүлэг гаргагчид 13.8.4-т зааснаар ажлаас халах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолтыг зөрчсөн 1 албан тушаалтанд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т зааснаар албан тушаал бууруулах сахилгын хариуцлагыг тооцуулсан байна.

Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн 3 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар Татварын ерөнхий газарт шилжүүлсэн. Уг шалгалтаар нийт 2.132.072.560 (*хоёр тэрбум нэг зуун гучин хоёр сая далан хоёр мянга таван зуун жар*) төгрөгийн татварын зөрчил илэрч, нийт 136.380.970 (*зуун гучин зураан сая гурван зуун наян мянга есөн зуун дал*) төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан байна.

Зөрчил гаргасан нийтийн албан тушаалтанд сахилгын хариуцлага оногдуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжилснаар нийт 44 нийтийн албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Үүнд: Авлигын эсрэг хуулийн 13.8.1-д зааснаар сануулах шийтгэлийг 5 албан тушаалтанд, 13.8.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр бууруулах шийтгэлийг 2 албан тушаалтанд, 33.1.1-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30%-иар бууруулах шийтгэлийг 1 албан тушаалтанд, 33.1.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр бууруулах сахилгын шийтгэлийг 5 албан тушаалтанд, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах шийтгэлийг 26 албан тушаалтанд, 29.2.3-т зааснаар албан тушаал бууруулах сахилгын шийтгэлийг 3 албан тушаалтанд, 29.2.4-т зааснаар нийтийн албанаас халах сахилгын шийтгэлийг 2 албан тушаалтанд тус тус оногдуулсан байна.

Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар зөвлөмж, чиглэлийг Сангийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сонгуулийн ерөнхий хороо, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Эрчим хүчний зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хөдөлмөрийн халамж, үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Авто тээврийн үндэсний төв, Нийслэлийн “Өргөө” амаржих газар, Баянгол дүүргийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, “Эрдэнэс таван толгой” ХК, “Нийслэлийн Орон сууцны корпорац” ХХК, “Дэлүүн” бүрэн дунд сургууль, Архангай аймгийн Байгаль орчин, аялал, жуулчлалын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Засаг дарга, Говь-Алтай аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар, Сэлэнгэ аймгийн Баянгол, Цагааннуур сумын Засаг

даргын Тамгын газар, Увс аймгийн Засаг даргын Тамгын газар, Увс аймгийн Түргэн сумын Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 53 байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан.

Цаашид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн хангах, Монгол Улсад хэрэгжүүлэх мега төслүүдэд авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын арга барилыг өөрчлөн шинэчлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх, авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй олон улсын үр дүнтэй арга хэрэгсэл, туршлагыг судлан нэвтрүүлэхэд анхааран ажиллаж байна.

--oOo--



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭ – FORENSIC

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ШИНЖИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ
3. ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН
БАЙДАЛ
4. САН БАЯЖУУЛАЛТ, АШИГЛАЛТЫН
СТАТИСТИК
5. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ





1.Товч танилцуулга

Шүүх шинжилгээний байгууллага нь шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд тулгуурлан нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын зэрэгцээ аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгт авагдсан ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй, хараат бусаар дүгнэлт гаргаж, хэрэг маргааныг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.


Шүүх шинжилгээний тухай хуульд заасны дагуу эрүү, иргэн, захиргаа, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр жилд дунджаар 35 мянга орчим хэргийн газрын үзлэгт оролцож, 70 мянга орчим шинжилгээг тусгай мэдлэгийн хүрээнд шинжлэх ухаанд тулгуурлан хийж, техник технологийн дэвшил ашиглан нотолгооны эх сурвалж болох дүгнэлт гарган хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Шүүх шинжилгээний байгууллага нь бүтэц, зохион байгуулалтын хувьд “Шүүх шинжилгээний ерөнхий газар”, “Нийслэлийн шүүх шинжилгээний газар, хэлтэс”, “Бүсийн шүүх шинжилгээний төв” болон “Аймгийн шүүх шинжилгээний хэлтэс, хэсэг”-тэй бөгөөд үндсэн чиг үүргийн Байгалийн ухаан, Шүүх анагаах ухаан, Инженер-техник, Криминалистик, Эдийн засгийн шинжилгээний газруудтай бөгөөд ДНХ, Митохондрийн ДНХ, Хими, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, Физик, Биологи, Шүүх сэтгэцийн болон Шүүх эд эс, Санхүү, бүртгэл, Хөрөнгийн үнэлгээний тасаг, Цахим технологи, Барилга-инженерийн байгууламж, Хэргийн газрыг сэргээн дүрслэх, Авто техник, Галын техник, Гарын мөр, Мөр судлал, Бичиг баримт, Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх хэрэгсэл, Гэрэл зураг боловсруулах, Хүрээлэн буй орчин, экологийн зэрэг нийт 21 төрлийн шинжилгээний лаборатори, 4 тасаг, 1 амбулаторитойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өргөжиж, шинэ төрлийн (Галын техникийн шинжилгээний лаборатори, Барилга-инженерийн байгууламжийн шинжилгээний лаборатори, Митохондрийн ДНХ шинжилгээний лаборатори, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лаборатори, Шүүх микробиологийн шинжилгээний лаборатори) шинжилгээний лабораториудыг байгуулж, олон улсын төсөл хэрэгжүүлж, шинэ төрлийн шинжилгээнүүдийг хийх орчин нөхцөл бүрдсэн.

Зураг 1.Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо





2. Шинжилгээний тоон мэдээ

Шүүх шинжилгээний байгууллага 2024 онд улсын хэмжээнд нийт 68851 шинжилгээ хийсэн ба үүнээс 42801 буюу 62%-ийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 18202 буюу 26.5%-ийг тусгай шинжилгээ, 6683 буюу 10%-ийг криминалистикийн шинжилгээ, 166 буюу 0.25%-ийг шүүх эдийн засгийн шинжилгээ эзэлж байна.

Энэ нь өмнөх оны шинжилгээний статистик үзүүлэлтээс 4585 шинжилгээгээр их буюу 7.0%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт шинжилгээний 65%-ийг шүүх шинжилгээний төв байгууллага, 31.4%-ийг орон нутгийн шүүх шинжилгээний хэлтсүүд, 4.0%-ийг нийслэлийн шүүх шинжилгээний газрын хэргийн газрын үзлэгийн багууд хийжээ.

Хүснэгт 1. Улсын хэмжээнд Шүүх шинжилгээний ерөнхий газарт хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 5 жилээр)

Шинжилгээний чиглэл, төрөл		2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Криминалистикийн шинжилгээ	Гарын мөр	6660	5384	5249	3486	4041
	Мөр судлал	1556	1394	1300	1349	1369
	Бичиг судлал, бичиг техник	915	684	902	1513	626
	Дүр зураг	37	15	21	32	33
	Галт зэвсэг	877	677	736	632	574
	Тэсрэх төхөөрөмж	13	2	6	18	1
	Дүрс бичлэг	244	243	204	178	188
	Авто техник	215	226	261	490	565
	Компьютер судлал	119	77	100	43	57
	Дуу авиа	23	15	17	14	16
	Материал судлал	5	40	48	19	28
	Бусад	29	5	33	8	44
	Бүгд	10693	8762	8877	7782	7542
Байгалийн ухааны шинжилгээ	Хими	6976	6931	8091	7814	8658
	Физик	249	133	150	179	233
	Биологи	6125	5977	6504	6360	6215
	ДНХ	2030	1757	2240	1797	2786
	Хүрээлэн буй орчин	-	4	92	247	310
	Бүгд	15380	14802	17077	16397	18202
Шүүх анагаах ухааны шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	4455	4561	5353	5231	5605
	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох	25919	22949	29010	26337	27226
	Хэргийн материалаар хийх	1504	1178	1401	1398	1571
	Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	1734	1686	1401	2122	2087
	Шарилд хийсэн шинжилгээ	17	11	10	14	12
	Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ				395	1159
	Гистологийн шинжилгээ	3345	3246	3823	2990	3722
	Бичил амь судлалын шинжилгээ	1062	1038	1379	1394	1419
	Бүгд	38036	34669	42377	39881	42801
Эдийн засгийн шинжилгээ	Татвартай холбоотой	11	7		7	13
	Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой	14	8	1	8	3
	Бэлэн мөнгөтэй холбоотой	75	51	61	21	48
	Эд хогшил, бараа	46	35	31	28	27
	Бусад зөрчил	20	16	14	18	19
	Буцсан	94	74	62	29	56
	Бүгд	260	191	169	111	166
Экологийн шинжилгээ	Мод	-	-	-	106	189
	Ургамал	-	-	-	15	26
	Амьтан	-	-	-	95	48
	Бусад	-	-	-	21	11
	Бүгд	-	-	-	237	274
Нийт		64369	58424	68500	64408	68985

График 1.Шүүх шинжилгээний ерөнхий газарт 2024 онд хийсэн шинжилгээний тоо (шинжилгээний төрлөөр)




График 2.Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээ (сүүлийн 5 жилээр)




График 3.Шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 5 жилээр)



Хүснэгт 2.2024 онд хийсэн шүүх шинжилгээ (аймаг, шинжилгээний төрлөөр)

№	Шинжилгээний газар, хэлтэс, алба	Нийт шинжилгээ	Шүүх анагаах ухааны шинжилгээ	Криминалистикийн шинжилгээ	Инженер техникийн шинжилгээ	Эдийн засгийн шинжилгээ	Байгалийн ухааны шинжилгээ
1	Архангай	1065	598	97		-	370
2	Баян-Өлгий	1156	994	50		-	112
3	Баянхонгор	759	709	49		-	1
4	Булган	795	494	128		-	173
5	Говь-Алтай	538	389	17		-	132
6	Говьсүмбэр	424	409	15		-	-
7	Дархан-Уул	1644	1199	88		-	357
8	Дорноговь	820	749	71		-	-
9	Дорнод	1805	982	93		-	730
10	Дундговь	537	480	57		-	-

11	Завхан	597	551	46		-	-
12	Орхон	1282	1142	140		-	-
13	Өвөрхангай	1033	960	73		-	-
14	Өмнөговь	836	799	37		-	-
15	Сүхбаатар	596	499	70		-	27
16	Сэлэнгэ	921	813	108		-	-
17	Төв	1341	1209	132		-	-
18	Увс	949	717	72		-	160
19	Ховд	1770	1405	125		-	240
20	Хөвсгөл	986	767	48		-	171
21	Хэнтий	1026	818	208		-	-
22	НШШГ	21479	1092	4658		-	15729
23	ШШЕГ	25493	25026	301	999	166	
Бүгд		68851	42801	6683	999	166	18202

2.1.Криминалистикийн шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллага 2024 онд криминалистикийн шинжилгээний 37755 объектой, 6683 шинжилгээ хийгдэж, өмнөх оныхоос 5.0%-иар буурсан бөгөөд 4658 шинжилгээ буюу 69.7%-ийг Нийслэлийн шүүх шинжилгээний газрын үзлэгийн багууд, 301 буюу 4.5%-ийг Криминалистикийн шинжилгээний газар, хэлтэст, 1724 буюу 25.8%-ийг Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн лабораторид хийсэн байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 6077, иргэний 164, захиргааны 17, зөрчлийн 425 хэрэг эзэлж байна.

Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 204, мөрдөгч, прокурорын тогтоолоор 6403, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 76 шинжилгээ хийсэн.

График 4.Криминалистикийн шинжилгээ



Хүснэгт 3.2024 оны криминалистикийн шинжилгээний тоо (шинжилгээний төрөл, аймгаар)

№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл											
			Гарын мөр	Мөр судлал	Баримт бичиг	Галт зэвсэг	Тэсрэх төхөөрөмж	Дүр зураг	Дүрс бичлэг	Авто техник	Компьютер	Дуу авиа	Материал судлал	Бусад
1	Архангай	97	37	14	7	-	-	-	-	-	-	-	-	39
2	Баян-Өлгий	50	13	26	10	1	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	49	20	14	7	7	1	-	-	-	-	-	-	-
4	Булган	128	107	16	5	-	-	-	-	-	-	-	-	-

5	Говь-Алтай	17	7	6	3	1	-	-	-	-	-	-	-	-
6	Говьсүмбэр	15	4	11	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул	88	40	26	22	-	-	-	-	-	-	-	-	-
8	Дорноговь	71	60	10	1	-	-	-	-	-	-	-	-	-
9	Дорнод	93	74	18	-	-	-	-	-	1	-	-	-	-
10	Дундговь	57	46	10	1	-	-	-	-	-	-	-	-	-
11	Завхан	46	22	21	2	1	-	-	-	-	-	-	-	-
12	Орхон	140	77	46	16	-	-	-	1	-	-	-	-	-
13	Өвөрхангай	73	49	18	4	1	-	-	-	-	-	-	-	1
14	Өмнөговь	37	21	14	1	-	-	-	-	-	1	-	-	-
15	Сүхбаатар	70	58	9	3	-	-	-	-	-	-	-	-	-
16	Сэлэнгэ	108	91	13	4	-	-	-	-	-	-	-	-	-
17	Төв	132	120	11	1	-	-	-	-	-	-	-	-	-
18	Увс	72	35	27	10	-	-	-	-	-	-	-	-	-
19	Ховд	125	75	33	17	-	-	-	-	-	-	-	-	-
20	Хөвсгөл	48	30	7	6	5	-	-	-	-	-	-	-	-
21	Хэнтий	208	179	26	3	-	-	-	-	-	-	-	-	-
22	НШШГ	4658	2820	985	466	358	-	-	-	-	-	-	28	1
23	КШГ	301	56	8	37	200	-	-	-	-	-	-	-	-
Бүгд		6683	4041	1369	626	574	1	0	1	1	1	0	28	41

2.2.Шүүх анагаах ухааны шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд шүүх анагаах ухааны чиглэлээр 42801 шинжилгээ хийсэн бөгөөд энэ нь өмнөх оныхоос 7.3%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эдгээрийн 27226 буюу 63.6% нь хүний биед хийсэн шинжилгээ, 5605 буюу 13.1% нь цогцос болон шарилд хийсэн шинжилгээ, 3722 буюу 8.7% нь эд эсийн, 1571 буюу 3.6% нь хэргийн материал, 1419 буюу 3.3 хувийг бичил амь судлал, 1159 буюу 2.7% нь сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ тус тус эзэлж байна.

Шүүх эмнэлгийн нийт шинжилгээний 25026 буюу 95.8%-ийг Шүүх анагаах ухааны шинжилгээний хэлтэст, 1092 буюу 4.1%-ийг Нийслэлийн шүүх шинжилгээний газар, 16683 буюу 38.9%-ийг аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн шүүх шинжилгээний хэлтэст тус тус хийжээ. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 34034, иргэний 76, зөрчлийн 4969 хэрэг эзэлж байна.

Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 185, мөрдөгч, прокурорын тогтоолоор 33575, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 3948, илгээх бичгээр 1371 шинжилгээ хийсэн.

Хүснэгт 4.Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн шүүх анагаах ухааны шинжилгээ

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ	5605
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	27226
Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	2087
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1571
Эксгумац	12
Эд эсийн шинжилгээ	3722
Бичил амь судлалын шинжилгээ	1419
Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ	1159
Нийт	42801

График 5.Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ (төрлөөр)



Шүүх шинжилгээний байгууллагаас сүүлийн 7 жилд хийсэн нийт шинжилгээний 59.8%-г шүүх эмнэлгийн шинжилгээ дангаараа эзэлж байна.

Хүснэгт 5.Улсын хэмжээнд хийсэн шинжилгээ (сүүлийн 7 жилээр)


Он	Нийт хийсэн шинжилгээний тоо	Шүүх анагаах ухааны шинжилгээний тоо	Шүүх анагаах ухааны шинжилгээний эзлэх хувь
2018	71263	40828	57.3%
2019	71861	41144	57.2%
2020	64369	38036	59.1%
2021	58424	34669	59.3%
2022	68500	42377	61.8%
2023	64266	39881	62.0%
2024	68851	42801	62.1%

2.3.Эдийн засгийн шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн дагуу эдийн засгийн 166 хэрэг хүлээн авснаас 28 аж ахуйн нэгж, байгууллага, 86 иргэдэд холбогдох өмчийн болон татварын маргаантай хавтаст хэрэг, санхүүгийн баримт материалд шинжилгээ хийж, 375.167.258.0 төгрөг, 23.010.3 валютын хохирлын хэмжээ, шалтгааныг тогтоож, шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 146, иргэний 14, захиргааны 6 хэрэг эзэлж байна. Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл 13.9% нь шүүх, шүүгчийн захирамжаар, 86.1% нь мөрдөгч, прокурорын тогтоолоор шинжилгээ хийсэн.

Үүнээс 166 шинжилгээний дүгнэлт гаргасан бөгөөд шинжээч томилох эрх бүхий этгээдийн хүсэлтээр, санхүүгийн баримт ирүүлээгүй, эрх бүхий байгууллагын акт дүгнэлт гараагүй зэрэг шалтгаанаар 52 шинжилгээ буцсан байна.

График 6.Эдийн засгийн шинжилгээ (хэргийн төрлөөр)



2.4.Байгалийн ухааны шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд байгалийн ухааны шинжилгээний чиглэлээр нийт 18202 шинжилгээ хийснийг өмнөх жилтэй харьцуулахад 11.0%-иар өссөн байна. Нийт шинжилгээний 86.4%-ийг байгалийн ухааны шинжилгээний газарт, 13.6%-ийг аймаг дахь бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн шүүх шинжилгээний хэлтсүүдэд хийгджээ.

Тус онд байгалийн ухааны шинжилгээний чиглэлээр хийгдсэн нийт шинжилгээний 8658 буюу 47.6%-ийг химийн шинжилгээ, 6215 буюу 34.1%-ийг биологийн шинжилгээ, 2786 буюу 15.3%-ийг ДНХ-ийн шинжилгээ, 310 буюу 1.7%-ийг хүрээлэн буй орчин, 233 буюу 1.3%-ийг физикийн шинжилгээ тус тус эзэлж байна. Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 508, мөрдөгч, прокурорын тогтоолоор 8084, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 110, тогтоолыг үндэслэж ирүүлсэн шинжээч эмчийн илгээх бичгээр 9500 шинжилгээ хийсэн.

Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн шинжээчид хэргийн газрын үзлэгт 227 удаа оролцож, “ДНХ-ийн мэдээллийн сан”-г 1243 хүний мэдээллээр баяжуулсан байна.

Шүүх шинжилгээний байгууллагын ДНХ-ийн шинжилгээний лабораторид өнөөдрийн байдлаар хорих ангид ял эдэлж буй хоригдол, өршөөлийн хуулиар суллагдсан ялтан, орон гэргүй тэнэмэл, захиргааны хяналтад байгаа зэрэг нийт 17128 орчим хүний генетикийн дээж хадгалагдаж байна.

График 7.Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд хийсэн тусгай шинжилгээ(хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ)



Хүснэгт 6.Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд хийсэн байгалийн ухааны шинжилгээ (шинжилгээний төрөл, аймаг)ар)


№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл				
			Хими	Физик	Биологи	ДНХ	Хүрээлэн буй орчин
1	Архангай	370	239	-	131	-	-
2	Баян-Өлгий	112	112	-	-	-	-
3	Баянхонгор	1	-	-	-	-	1
4	Булган	173	173	-	-	-	-
5	Говь-Алтай	132	117	-	15	-	-
6	Говьсүмбэр	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул	357	215	-	142	-	-
8	Дорноговь	-	-	-	-	-	-
9	Дорнод	730	377	-	328	4	21

10	Дундговь	-	-	-	-	-	-
11	Завхан	-	-	-	-	-	-
12	Орхон	-	-	-	-	-	-
13	Өвөрхангай	-	-	-	-	-	-
14	Өмнөговь	-	-	-	-	-	-
15	Сүхбаатар	27	27	-	-	-	-
16	Сэлэнгэ	-	-	-	-	-	-
17	Төв	-	-	-	-	-	-
18	Увс	160	138	-	22	-	-
19	Ховд	240	221	-	5	-	14
20	Хөвсгөл	171	171	-	-	-	-
21	Хэнтий	-	-	-	-	-	-
22	БУШГ	15729	6868	233	5572	2782	274
Бүгд		18202	8658	233	6215	2786	310

2.5. Экологийн шинжилгээ

Шүүх шинжилгээний байгууллагад 2024 онд 20312 объектод 274 шинжилгээ буюу мод судлалын 103, амьтан судлалын 48, ургамал судлалын 26, модны үр судлалын 86, байгаль орчинд учруулсан хохирлын 11 шинжилгээг хүлээн авч 256 шинжилгээ хийж, дүгнэлт гарган 2486 гэрэл зургийн үзүүлэлт хийн 25.067.722.944 төгрөгийн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоосон байна.

График 8. Экологийн шинжилгээ (эрүүгийн хэргийн төрлөөр)



3. Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал

Шүүх шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчид 2024 онд нийт 25813 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бол шинжээч эмч нар 6333 хэргийн газрын үзлэгт оролцсон байна.


Криминалистикийн шинжилгээний газрын шинжээчид 6, Нийслэлийн шүүх шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид 18382, аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн шинжээчид 7425 удаа хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцжээ.

Криминалистикийн шинжээчид хэргийн газрын үзлэгээр биологийн гаралтай ул мөр 3953, бичил мөр 155, бусад ул мөр, эд мөрийн баримт 34929, гарын мөр 12111, гутлын мөр 2736, тээврийн хэрэгслийн мөр 4197, эвдлэгч багажийн мөр 1047 илрүүлэн бэхжүүлж, шинжилгээний материалд хавсаргасан байна.

Хүснэгт 7.Хэргийн газрын үзлэг (хэргийн өнгөөр)

№	Хэргийн өнгө	Хэргийн тоо
1	Хүний амь нас хохирсон	7642
2	Хулгайлах	5589
3	Дээрэмдэх	408
4	Зам тээврийн осол	4937
5	Бусад	7237
Нийт		25813

График 9.Хэргийн газрын үзлэг (хэргийн өнгөөр)



Хүснэгт 8.2024 онд хэргийн газрын үзлэгт оролцсон байдал (хэргийн өнгө, аймагээр)


№	Аймаг	Нийт хэргийн газрын үзлэг	Хэргийн өнгө				
			Хүний амь нас хохирсон	Хулгайлах	Дээрэмдэх	Зам тээврийн осол	Бусад
1	Архангай	216	144	22	-	25	25
2	Баян-Өлгий	360	49	60	-	118	133
3	Баянхонгор	366	136	49	1	132	48
4	Булган	211	103	52	-	25	31
5	Говь-Алтай	164	67	28	-	47	22
6	Говьсүмбэр	255	41	23	-	64	127
7	Дархан-Уул	391	125	58	1	122	85
8	Дорноговь	403	144	68	2	108	81
9	Дорнод	597	164	154	1	148	130
10	Дундговь	322	120	58	2	81	61
11	Завхан	275	82	42	-	74	77
12	Орхон	313	74	98	2	21	118
13	Өвөрхангай	386	145	52	2	146	41
14	Өмнөговь	330	185	31	-	56	58
15	Сүхбаатар	187	63	40	-	43	41
16	Сэлэнгэ	596	203	71	2	240	80
17	Төв	500	233	47	6	180	34
18	Увс	274	90	41	-	49	94
19	Ховд	384	75	77	-	141	91
20	Хөвсгөл	315	185	67	1	30	32
21	Хэнтий	580	160	118	42	170	90
22	НШШГ	18382	5050	4333	346	2917	5736
23	Криминалистикийн шинжилгээний газар	6	4				2
Бүгд		25813	7642	5589	408	4937	7237

Хэргийн газрын үзлэгээр нийт ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлсэн ба шинжилгээний 51271, хэргийн газрын үзлэгийн 349701, цогцсын үзлэг, задлан шинжилгээний 117434, бусад 218068 зураг буюу нийт 736474 гэрэл зургаар үзлэг шинжилгээний явцыг бэхжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 9.Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт төрлөөр

№	Илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт	Ул мөр, эд мөрийн баримтын тоо
1	Гарын мөр	12111
2	Гутлын мөр	2736
3	Тээврийн хэрэгслийн мөр	4197
4	Бичил мөр	155
5	Эвдлэгч багаж хэрэгслийн мөр	1047
6	Биологийн гаралтай ул мөр	3953
7	Бусад ул мөр, эд мөрийн баримт	34929
Нийт		59128

График 10.Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт (төрлөөр)



Хүснэгт 10.2024 онд хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт (аймаг тус бүрээр)

№	Аймаг	Нийт ул мөр, эд мөрийн баримт	Ул мөр, эд мөрийн баримт						
			Гарын мөр	Гутлын мөр	Тээврийн хэрэгслийн мөр	Бичил мөр	Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр	Биологийн гаралтай ул мөр	Бусад ул мөр, эд мөрийн баримт
1	Архангай	571	102	23	191	-	22	62	171
2	Баян-Өлгий	574	71	54	85	17	3	114	230
3	Баянхонгор	532	172	43	117	1	12	69	118
4	Булган	1008	126	75	129	4	33	198	443
5	Говь-Алтай	255	19	9	73	-	6	50	98
6	Говьсүмбэр	491	10	19	88	-	9	45	320
7	Дархан-Уул	526	166	34	31	-	-	3	292
8	Дорноговь	473	179	68	58	-	-	18	150
9	Дорнод	840	216	87	237	-	1	63	236



10	Дундговь	668	141	79	169	-	15	39	225
11	Завхан	594	56	58	88	-	2	63	327
12	Орхон	1129	473	109	35	11	11	141	349
13	Өвөрхангай	1028	216	102	253	4	47	89	317
14	Өмнөговь	490	120	53	97	-	3	42	175
15	Сүхбаатар	567	71	73	118	-	-	4	301
16	Сэлэнгэ	1021	223	107	224	24	19	161	263
17	Төв	873	178	54	307	-	18	80	236
18	Увс	455	89	27	59	-	-	127	153
19	Ховд	1698	346	125	250	26	7	121	823
20	Хөвсгөл	628	102	44	61	-	1	71	349
21	Хэнтий	1722	160	111	296	-	57	164	934
22	НШШГ	42942	8867	1378	1231	68	781	2222	28395
23	КШГ	43	8	4	-	-	-	7	24
Бүгд		59128	12111	2736	4197	155	1047	3953	34929

4. Сан баяжуулалт, ашиглалтын статистик

Шүүх шинжилгээний байгууллага нь галт зэвсгийн хонгио хошууны Арсенал болон гарын мөр, дардасны Папилон сан, ДНХ-ийн мэдээллийн санг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд 2024 онд галт зэвсгийн Арсенал санд 1869 сумны хонгионы мөрөөр, 1503 сумны хошууны мөрөөр буюу 3372 мөрөөр баяжуулсан. Мөн гарын мөр, дардасны Папилон санг 11450 гарын дардсаар, 6514 гарын мөрөөр буюу нийт 17964 мөр, дардсаар баяжуулж, гэмт хэрэг илрүүлэх чиглэлээр үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нийслэлийн Засаг даргын 627 дугаар захирамжаар баталсан “Эзэнгүй цогцос оршуулах журам”, 2013 оны А/117 дугаар захирамжаар баталсан “Захирамжид өөрчлөлт оруулах журам”-ыг тус тус үндэслэн тус хүрээлэнгийн Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын цогцос хадгалах байранд хадгалагдаж байгаа хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй 111 цогцсыг холбогдох журмын дагуу оршуулсан.

График 11, 12. 2024 оны сангийн баяжуулалт (Арсенал, Папилон)



Хүснэгт 11.2024 оны сан баяжуулалт, ашиглалтын статистик (аймаг тус бүрээр)

№	Аймаг	Арсенал			Папилон		
		Сумын хонгио	Сумын хошуу	Нийт	Гарын хээний дардас	Гарын мөр	Нийт
1	Архангай	-	-	-	99	13	112
2	Баян-Өлгий	-	-	-	210	4	214
3	Баянхонгор	24	-	24	458	48	506
4	Булган	-	-	-	176	75	251
5	Говь-Алтай	4	2	6	240	-	240
6	Говьсүмбэр	-	-	-	99	3	102
7	Дархан-Уул	-	-	-	271	43	314
8	Дорноговь	24	-	24	240	58	298
9	Дорнод	12	8	20	168	34	202
10	Дундговь	12	-	12	188	42	230
11	Завхан	-	-	-	107	32	139
12	Орхон	36	36	72	498	289	787
13	Өвөрхангай	4	2	6	172	37	209
14	Өмнөговь	-	-	-	314	58	372
15	Сүхбаатар	-	-	-	669	52	721
16	Сэлэнгэ	8	6	14	240	56	296
17	Төв	45	83	128	299	269	568
18	Увс	32	28	60	276	13	289
19	Ховд	48	26	74	263	169	432
20	Хөвсгөл	42	8	50	192	50	242
21	Хэнтий	24	-	24	412	50	242
22	НШШГ	1517	1279	2796	5856	5000	10856
23	КШГ	37	25	62	3	74	77
Бүгд		1869	1503	3372	11450	6514	17964

5.Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангах, криминалистик, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулан, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, Олон Улсын стандартад нийцүүлэн техник, технологи, тоног төхөөрөмжөөр ханган, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах зорилгоор БНСУ-ын “Эксим банк”-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Монгол Улсын шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл” болон “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний лабораториудад засвар, үйлчилгээ хийх, стандартад нийцүүлэн шинэчлэн тоноглох, шинжилгээний лабораториудыг шинээр байгуулах, шинжээчдийг урт, богино хугацааны сургалтад хамруулах, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж сургалт зохион байгуулах зэрэг ажлыг үе шаттайгаар амжилттай зохион байгуулж байна.

2024 онд Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 92.0 сая төгрөгийн өртөг бүхий “Зөөврийн дижитал рентген аппарат”, Физикийн шинжилгээний лабораторид натригаас уран хүртэлх химийн элементийг тодорхойлдог, нэг удаад 16 дээж хэмжих хүчин чадалтай 199.7 сая төгрөгийн өртөг бүхий “EDX-7200” маркийн рентген спектрометр, мөн экологийн үзлэг шинжилгээ хийхэд шаардлагатай 216.2 сая төгрөгийн өртөг бүхий нийт 23 нэр төрлийн техник, тоног төхөөрөмжийг тус тус худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн санхүүжилтээр Биологийн шинжилгээний лабораторид “Olympus” DX-53 маркийн 3 ширхэг микроскопыг худалдан авч шинжилгээ хийж байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIMINAL DAMAGE

1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГЫН
СТАТИСТИК
3. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
4. ШҮҮХИЙН СТАТИСТИК
5. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК



ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ (2024)

НИЙТ ХОХИРОГЧ

42912 +21.6%

НИЙСЛЭЛД

31297 +27.1%

ОРОН НУТАГТ

11606 +9.0%



52.7%

22630

+17.4%

ЭРЭГТЭЙ

ЭМЭГТЭЙ

НАС

1267

60+

1236

4431

45-59

4462

6460

35-44

5878

8916

18-34

7326

1556

0-17

1380



47.3%

20282

+26.6%



ХҮҮХЭД

2936 +32.6%



НАС БАРСАН

991 +16.9%



ГЭМТСЭН

10603 +9.5%

УЧИРСАН ХОХИРОЛ



697044.4 САЯ

НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН

306257.6 САЯ

ХУВЬ

43.9% -3.2%

Гэмт хэргийн хохирол

Монгол Улсад 2024 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, түүний бүтэц, нөхөн төлүүлэлт, нийгэмд үзүүлж буй нөлөөллийн талаар олон байгууллага (цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх газар, прокурорын байгууллага, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага) хамтран статистик мэдээллийг нэгтгэн гаргасан нь эрх зүйн бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах, хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Улсын хэмжээнд 2024 онд нийт 42912 иргэн, 122 хуулийн этгээд гэмт хэргийн улмаас хохирч, тэдгээрээс 991 хүний амь нас хохирч, 10603 хүний эрүүл мэндэд хохирол учирсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нийт хохирогч 21.6%-иар, эрүүл мэндэд хохирол хүн 9.5%-иар, нас барсан хүн 16.9%-иар тус тус өссөн нь үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл нэмэгдэж байгааг илтгэж байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан нийт 697.1 тэрбум төгрөгийн хохирлоос 306.3 тэрбум төгрөг буюу 43.9%-ийг нөхөн төлүүлж, 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна. Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ өмнөх оноос 44.8%-иар өссөн боловч битүүмжилсэн хөрөнгийн хэмжээ 27.9%-иар буурсан нь гэмт хэргийн улмаас учирсан эдийн засгийн хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгө хамгаалах ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.


Энэхүү үзүүлэлтүүд нь зөвхөн цагдаагийн байгууллагын хүрээнд төдийгүй авлигатай тэмцэх байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистик мэдээллээр ч баталгаажиж байгаа бөгөөд зөвхөн нэг жилийн хугацаанд тав орчим их наяд төгрөгийн хохирол учирсан нь улс орны эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Үүнээс үзэхэд, гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг үнэлэхдээ эрх зүйн зохицуулалт, криминологийн судалгаа, виктимологийн дүн шинжилгээг нэгтгэн авч үзэх шаардлага бий болсон. Энэ нь гэмт явдлыг зөвхөн тоон үзүүлэлтээр хэмжихээс гадна нийгэм, эдийн засгийн өргөн хүрээний үр дагавартай нь хамтатган судлах нь төрийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулахад ач холбогдолтой.

1.Цагдаагийн байгууллагын статистик


Улсын хэмжээнд 2024 онд үйлдсэн гэмт хэргийн улмаас 42912 хүн, 122 хуулийн этгээд хохирч, үүнээс 991 хүн нас барж, 10310 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 7620 буюу 21.6%-иар, гэмтсэн хүн 922 буюу 9.5%-иар, нас барсан хүн 143 буюу 16.9%-иар тус тус өссөн байна.

График 1.Хохирсон хүн, хуулийн этгээдийн байдал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 697077.4 сая төгрөгийн хохирлын 306257.6 сая төгрөг буюу 43.9%-ийг нөхөн төлүүлж, 5011.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 247922.2 сая төгрөг буюу 55.2%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 94721.8 сая төгрөг буюу 44.8%-иар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 1941.6 сая төгрөг буюу 27.9%-иар буурсан байна.

График 2.Нийт хохирол, нөхөн төлүүлсэн байдал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



2024 оны байдлаар орон нутгийн хэмжээнд гэмт хэргийн улмаас 11615 иргэн, 46 хуулийн этгээд хохирч, үүнээс 464 хүн нас барж, 4566 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 949 буюу 8.9%-иар, гэмтсэн хүн 509 буюу 12.5%-иар, нас барсан хүн 10 буюу 2.2%-иар, хуулийн этгээд 4 буюу 9.5%-иар тус тус өссөн байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 74037.9 сая төгрөгийн хохирлын 44008.7 сая төгрөг буюу 59.4%-ийг нөхөн төлүүлж, 2162.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 871.1 сая төгрөг буюу 1.2%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 4304.8 сая төгрөг буюу 8.9%-иар, битүүмжилсэн хөрөнгө 401.6 сая төгрөг буюу 15.7%-иар тус тус буурсан байна.

Харин нийслэл, дүүргүүдэд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2024 оны байдлаар 31297 иргэн, 76 хуулийн этгээд хохирч, үүнээс 527 хүн нас барж, 6037 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 6671 буюу 27.1%-иар, хохирсон хуулийн этгээд 12 буюу 18.8%-иар, гэмтсэн хүн 413 буюу 7.3%-иар, нас барсан хүн 133 буюу 33.8%-иар тус тус өссөн байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 623039.5 сая төгрөгийн хохирлын 42.1%-ийг нөхөн төлүүлж, 2849.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 248793.3 сая төгрөг буюу 66.5%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 99026.6 буюу 60.7%-иар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 1539.9 сая төгрөг буюу 35.1%-иар буурсан байна.

Энэхүү тоон мэдээллийг дараах хүснэгтээр өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулж харуулав.

Хүснэгт 1.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

№	Бүс	Аймаг, нийслэл, дүүрэг	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол												
			Хохирсон			Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Нийт хохирлын хэмжээ /сая.төг/		Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/	
			Иргэн		Хуулийн этгээд										
			2023	2024	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
1	Орон нутаг		10666	11615	46	4057	4566	454	464	74909.1	74037.9	48313.6	44008.7	2563.6	2162.0
2	Баруун бүс	Баян-Өлгий	406	423		122	151	8	13	896.9	1623.0	575.1	816.4	102.2	69.7
3		Говь-Алтай	270	362	1	86	105	9	12	1305.4	1557.0	917.8	576.3	107.9	6.9
4		Завхан	317	266	2	123	112	14	14	1899.2	1765.7	1200.6	1251.5	794.1	809.7
5		Увс	333	309	2	106	136	9	15	1638.4	2485.2	1268.6	2064.1	158.0	161.0
6		Ховд	623	640	3	227	253	21	13	2265.8	2317.5	1245.4	1277.9	55.0	139.5

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIMINAL DAMAGE

7	Хангайн бүс	Архангай	411	450	1	158	163	22	22	1393.7	3393.9	671.7	2486.0	111.9	0.0
8		Баянхонгор	409	534	1	170	181	14	23	3092.4	2393.2	786.3	625.6	90.3	57.6
9		Булган	398	379		134	157	15	22	2577.9	2159.5	833.8	1338.2	183.5	298.2
10		Орхон	772	936	2	317	405	16	12	2195.2	3955.9	1578.7	2889.2	21.0	
11		Өвөрхангай	514	593	3	238	279	16	28	936.5	1280.1	712.2	852.1	0.9	
12		Хөвсгөл	609	657	1	254	283	24	26	5120.1	3101.5	3870.4	1855.9	9.1	16.3
13	Төвийн бүс	Говьсүмбэр	146	168		83	103	7	9	779.0	476.6	185.7	247.1		
14		Дархан-Уул	688	886	6	229	272	18	26	3030.0	10266.2	1541.3	7793.1	33.3	22.5
15		Дорноговь	649	757	12	228	263	31	34	3918.5	6789.8	1521.9	3989.8	36.3	75.1
16		Дундговь	256	263		141	181	13	6	1057.2	808.5	573.9	530.7	34.8	8.0
17		Өмнөговь	709	717	1	212	244	44	34	26015.5	8354.5	20954.0	2879.9		
18		Сэлэнгэ	726	814	3	274	287	32	32	3022.5	5482.9	1787.2	2182.1	238.0	71.2
19	Зүүн бүс	Төв	706	774	2	327	350	55	58	4171.9	4151.8	2429.2	3044.0	173.1	250.6
20		Дорнод	538	608		236	267	19	22	2819.1	3513.3	1919.6	2510.1	175.6	17.9
21		Сүхбаатар	474	437	4	185	170	10	15	1631.2	1508.6	858.6	525.0	238.0	153.3
22		Хэнтий	696	633	1	204	203	57	28	4139.6	6315.8	2586.7	4272.5	0.7	4.7
23		Нийслэл	24626	31297	76	5624	6037	394	527	374246.1	623039.5	163222.2	262248.9	4389.3	2849.3
24		Баянгол	4364	5813	10	929	1069	49	68	61423.3	74338.7	49294.4	33213.1	4005.5	4.0
25	Баянзүрх	6008	8518	15	1261	1155	126	136	75511.8	99037.3	21818.8	45433.8	79.5	37.1	
26	Сүхбаатар	3734	4315	20	676	902	41	67	80541.5	163642.9	22697.2	31136.4	53.3	2541.9	
27	Сонгинохайрхан	3359	3820	6	1291	1151	66	112	16399.3	17511.6	5126.3	6810.8	137.8	198.6	
28	Хан-Уул	3884	4999	17	651	746	79	80	107021.2	128821.6	55526.7	86338.2	44.5	29.7	
29	Чингэлтэй	2559	3230	4	549	717	18	50	29369.8	133433.1	6162.4	55156.7	68.6	38.0	
30	Багануур	179	272	1	91	115	5	6	452.3	718.2	265.8	311.4			
31	Багахангай	24	19		13	10		1	68.6	29.725	66.4	29.2			
32	Налайх	515	311	3	163	172	10	7	3458.3	5506.4	2264.2	3818.1			
33	Улсын дүн	35292	42912	122	9681	10603	848	991	449155.2	697077.4	211535.8	306257.6	6952.9	5011.3	
Өсөлт бууралт/тоогоор/			7620		922		143		247922.2		94721.8		-1941.5		
Өсөлт бууралт /хувиар/			21.6		9.5		16.9		55.2		44.8		-27.9		

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2.Тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол

№	Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол													
		Хохирсон			Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Нийт хохирлын хэмжээ /сая.төг/		Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/		
		Иргэн		Хуулийн этгээд											
		2023	2024	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	
1	Хүнийг алах	203	196	-	33	36	172	172	1725.5	2424.3	1765.9	1843.8	100.7	139.6	
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	8923	9331	-	8361	9001	6	11	11928.8	14619.3	9497.2	11058.4	489.7	541.3	
3	Хүчиндэх	565	675	-	45	49	-	2	1852.7	3003.5	1332.4	1873.9	41.9	115.6	
4	Хулгайлах	5475	7660	10	-	-	-	-	37348.3	24706.7	24246.9	9596.2	206.1	197.2	
5	Хувийн өмчийг хулгайлах	4809	4844	4	-	-	-	-	15257.1	15683.5	4159.8	6880.7	181.3	140.7	
6	Халаасны хулгай	312	1345	-	-	-	-	-	600.6	2561.5	162.4	393.2	1.9	-	
7	Мал хулгайлах	664	516	-	-	-	-	-	3297.8	2540.0	1200.3	961.2	184.2	101.4	
8	Дээрэмдэх	400	573	1	36	37	-	-	1053.7	1079.9	384.8	431.6	3.5	8.8	
9	Залилах	13094	15881	28	-	-	-	-	306266.7	487263.2	127828.3	185078.2	76.3	2436.0	
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	382	398	6	-	-	-	-	6486.2	9457.8	4605.8	7446.4	1026.8	800.2	
11	Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, Ашиглалтын журам зөрчих	1434	1782	1	1096	1352	312	358	8779.7	17160.4	7494.4	14995.0	315.5	364.0	
12	Цахим орчинд үйлдэгдсэн	392	402	1	-	-	-	-	1640.4	997.3	94.8	128.5	-	2.0	
13	Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, Алдуул мал завших	794	1454	4	-	-	-	-	2460.2	4093.4	498.2	1516.2	23.9	4.7	

Гэмт хэрэгт холбогдсон зарим этгээд болон гэмт хэргийг үйлдэх үеийн нөхцөл байдал, түүний улмаас учирсан хохирлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах 3, 4 дүгээр хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 3.Гэмт хэргийн онцлог, нөхцөл байдлын улмаас учирсан хохирол

№	Гэмт хэргийн онцлог, нөхцөл байдал	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол													
		Хохирсон			Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Нийт хохирлын хэмжээ /сая.төг/		Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/		
		Иргэн		Хуулийн этгээд											
		2023	2024	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	
3	Согтуугаар үйлдсэн	6833	7404	5	4876	5287	285	259	12794.5	34893.4	10067.3	31139.4	576.6	846.5	
2	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн	1460	1578	-	1238	1303	21	28	1717.0	3251.3	-	-	-	-	
3	Гэр, орон сууцанд үйлдэгдсэн	11100	13691	4	3302	3244	257	350	61649.2	100011.6	25686.1	39732.5	529.3	427.3	
4	Олон нийтийн газарт үйлдэгдсэн	3341	4571	10	1184	1425	23	18	19211.2	38066.9	5140.2	10945.4	150.0	155.8	
5	Гудамж талбайд үйлдэгдсэн	6623	8976	8	2386	2686	65	107	33341.6	47226.2	21735.0	26889.0	286.8	395.4	

Хүснэгт 4.Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог байдлын улмаас учирсан хохирол

№	Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол												
		Хохирсон			Гэмтсэн хүн	Нас барсан хүн	Нийт хохирлын хэмжээ /сая.төг/	Нөхөн төлүүлсэн /сая.төг/		Битүүмжилсэн хэмжээ /сая.төг/				
		Иргэн		Хуулийн этгээд										
		2023	2024	2024								2023	2024	2023
1	Эмэгтэй хүн үйлдсэн	5977	6030	20	1077	1111	110	111	84860.2	93086.7	53810.7	56493.1	4262.7	269.3
2	Насанд хүргээгүй хүн үйлдсэн	1547	1741	3	523	538	15	15	2078.0	3276.2	1537.8	2380.2	60.3	57.8
3	Гадаадын иргэний үйлдсэн	91	121	4	15	17	3	4	11312.0	96671.6	1088.0	38804.6	-	-


Улсын хэмжээнд 2024 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 42912 иргэн, 122 хуулийн этгээд хохирч, үүнээс 991 хүн нас барж, 10603 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 143 буюу 16.9%-иар, гэмтсэн хүн 922 буюу 9.5%-иар тус тус өссөн байна.

Харин гэмт хэргийн улмаас нийт 697077.4 сая төгрөгийн хохирол учирч, үүнээс 306257.6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 5011.3 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирол 247922.2 сая төгрөг буюу 55.2%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 94721.8 сая төгрөг буюу 44.8%-иар тус тус өсөж, эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа 1941.6 сая төгрөг буюу 27.9%-иар буурсан статистик үзүүлэлт гарсан байна.

2.Авлигатай тэмцэх байгууллагын статистик

2024 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 417.247.706.374.04 төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 240.940.060.451.75 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 23.589.470.251.00 төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

График 3. Учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө, нөхөн төлүүлсэн байдал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



3. Прокурорын байгууллагын статистик

2024 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 45358 хүн хохирсноос, 20874 эмэгтэй, 3102 насанд хүрээгүй хүн байна. Мөн гэмт хэргийн улмаас 3061 хүн нас барж, 12387 хүн гэмтэж, 550 хүн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас хохирсон байна.

График 4. Хохирогчид (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Хүснэгт 5. Прокурорын байгууллагад бүртгэгдсэн хохирогч

		Прокурорын байгууллага					
		Хохирогч	Үүнээс		Амь насаараа хохирсон хүн	Эрүүл мэндээрээ хохирсон хүн	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн
			Эмэгтэй	Насанд хүрээгүй хүн			
Нийт		45,358	20,874	3,102	3,061	12,387	550
Нийслэл		33,585	15,955	2,296	1,988	7,352	190
1	Тээврийн прокурорын газар	228	92	20	21	29	1
2	Нийслэлийн прокурорын газар	3,321	1,573	180	162	953	36
3	Багануур дүүргийн прокурорын газар	10,880	5,276	788	593	1,468	59
4	Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар	4,551	1,982	283	341	1,224	28
5	Баянгол дүүргийн прокурорын газар	4,628	2,141	237	166	927	14

6	Баянзүрх дүүргийн прокурорын газар	5,042	2,569	380	284	659	26
7	Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар	2,826	1,408	140	239	617	3
8	Сүхбаатар дүүргийн дүүргийн прокурорын газар	330	150	14	10	143	0
9	Хан-Уул дүүргийн прокурорын газар	588	273	45	30	250	23
10	Чингэлтэй дүүргийн прокурорын газар	1,191	491	209	142	1,082	0
Орон нутаг		11,773	4,919	806	1,073	5,035	360
1	Архангай аймгийн прокурорын газар	398	153	25	14	148	12
2	Баян-Өлгий аймгийн прокурорын газар	429	147	38	19	172	22
3	Баянхонгор аймгийн прокурорын газар	648	291	39	81	205	19
4	Булган аймгийн прокурорын газар	308	155	29	43	161	11
5	Говь-Алтай аймгийн прокурорын газар	334	138	23	14	122	5
6	Говьсүмбэр аймгийн прокурорын газар	204	85	14	39	128	7
7	Дархан-Уул аймгийн прокурорын газар	875	447	67	40	288	26
8	Дорноговь аймгийн прокурорын газар	635	272	29	89	281	7
9	Дорнод аймгийн прокурорын газар	624	256	42	37	296	11
10	Дундговь аймгийн прокурорын газар	336	139	20	11	200	37
11	Завхан аймгийн прокурорын газар	289	94	20	24	124	16
12	Орхон аймгийн прокурорын газар	900	404	61	38	432	27
13	Өвөрхангай аймгийн прокурорын газар	806	340	64	117	302	36
14	Өмнөговь аймгийн прокурорын газар	507	205	41	58	259	26
15	Сүхбаатар аймгийн прокурорын газар	513	173	24	47	191	7
16	Сэлэнгэ аймгийн прокурорын газар	756	325	62	65	339	27
17	Төв аймгийн прокурорын газар	760	300	49	71	401	12
18	Увс аймгийн прокурорын газар	296	88	20	30	172	19
19	Ховд аймгийн прокурорын газар	651	281	42	41	268	5
20	Хөвсгөл аймгийн прокурорын газар	676	283	43	40	295	14
21	Хэнтий аймгийн прокурорын газар	828	343	54	155	251	14

4.Шүүхийн статистик

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2024 онд 20881 шүүгдэгч, 27 хуулийн этгээдэд холбогдох 17226 хэрэг хянаснаас 17051 шүүгдэгч, 15 хуулийн этгээдэд холбогдох 14682 хэргийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн улмаас 2024 онд 19956 хүн хохирогчоор бүртгэгдсэнээс 8094 эмэгтэй, 902 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 998 хүн байна. Албан тушаалаар нь авч үзвэл, улс төрийн албан тушаалтан 19, төрийн захиргааны албан хаагч 204, төрийн тусгай албан хаагч 412 /шүүгч 1, прокурор 2, мөрдөгч 34, хууль сахиулах байгууллагын ажилтан 142, бусад 233/, төрийн үйлчилгээний албан хаагч 1883 /эмч 105, багш 295, санхүүгийн ажилтан 153, бусад 1330/ төрийн бус байгууллагын ажилтан 760, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан 3425, оюутан 978, сурагч 693, малчин 1740, ажилгүй 2989, ялтан 6, бусад 6847 зэрэг тус тус бүртгэгджээ. Боловсролын хувьд дээд боловсролтой 5686, бүрэн дунд боловсролтой 7143, 1009 техникийн болон мэргэжлийн, 1842 тусгай мэргэжлийн дунд, суурь боловсролтой 2626, бага боловсролтой 1084, боловсролгүй 566 байна.

Гэмт хэргийн улмаас 552 хуулийн этгээд хохирогчоор тогтоогдсон бөгөөд төрийн байгууллага 476, хязгаарлагдмал хариуцлагатай компани 151, хувьцаат компани 4, нөхөрлөл 1, төрийн бус байгууллага 6, сан 1 байна.

Хохирогч хүнийг иргэний харьяаллаар нь авч үзвэл, Монгол Улсын иргэн 19904, гадаадын иргэн 52, харьяалалгүй хүн бүртгэгдээгүй байна.

Гэмт хэргийн улмаас 449 хүн нас барснаас 98 эмэгтэй, 43 хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас 8088 хүн гэмтсэнээс 2556 эмэгтэй, 399 хүүхэд, мөн 813 хүнд, 1471 хүндэвтэр, 5805 хөнгөн гэмтэл учирчээ.

Гэмт хэргийн улмаас 156.537.751.706 төгрөгийн хохирол учирснаас хүнд 88.129.667.879 төгрөг, хуулийн этгээдэд 30.919.231.521 төгрөгийн хохирол учирчээ. Хохирол нөхөн төлүүлэлт нийт 124.440.187.466 төгрөг, үүнээс хүнд 70.597.573.421 төгрөг, хуулийн этгээдэд 26.335.815.121 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистик

Төрөөс олгосон нөхөн төлбөрийн тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэргийн шүүхээс тогтоосон торгох ялыг гүйцэтгэсэн үнийн дүнгийн 60%, гэм буруутай төлбөр төлөгчөөс нөхөн төлүүлсэн төлбөрийн мөнгийг “Гэмт хэргийн нөхөн төлбөрийн сан”-д байршуулж, Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд хамаарах гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэж байна.

Төрөөс нөхөн төлбөр олгох үндэслэлийн дагуу 2023 онд 111.095.076.2 төгрөг, 2024 онд 384.031.5 төгрөгийг тус тус төлбөр авагч иргэдэд олгуулж, уг мөнгийг зохих санд буцаан төвлөрүүлэх, мөнгөн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэсэн.

2023-2024 онд Эрүүгийн хуулийн 10.1, 11.1, 11.4, 12.1, 17.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн улмаас хохирсон төлбөр авагч иргэдэд нөхөн төлбөр олгож, төлбөр төлөгчөөс 2022 онд 134.714.6 төгрөг, 2024 онд 262.180,5 төгрөгийг зохих санд төвлөрүүлэн ажилласан.

Төрөөс 2023-2024 онд олгосон гэмт хэргийн нөхөн төлбөрт хамаарах эрүүгийн хэргийн шийдвэрүүдийг авч үзвэл:

-2023 онд шүүхийн шийдвэрээр 36 төлбөр авагчид 111.095.076.2 төгрөг;

-2024 онд шүүхийн шийдвэрээр 25 төлбөр авагчид 384.031.5 төгрөгийн нөхөн төлбөрийг төрөөс олгуулсан байна.

Сангаас олгосон төлбөр төлөгч нарын 73.88% нь Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлд заасан хүнийг алах, 16.86% нь Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлд /96.1, 96.2/ хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 0.41% нь Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлд заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, 8.85% нь Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд /126.1/ заасан хүчиндэх гэм хэргийн улмаас учирсан хохирол төлбөрт олгосон байна.

Эмчилгээний зардалд 93 иргэнд 675.964.790 төгрөг, оршуулгын зардалд 421 иргэний 2.570.382.173 төгрөг, хөдөлмөрийн чадвараа алдсан 2 иргэний 5.123.031 төгрөгийг тус тус олгосон.

“Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ын 6.1-д Сангаас олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, нөхөн төлүүлэхээр заасан.



Нийт 516 төлбөр төлөгчид холбогдох 3.2 тэрбум төгрөгийг эргэн төвлөрүүлэхээс 1.3 төгрөгийг төвлөрүүлсэн, үүнээс хоригдлын хөдөлмөрийн хөлсний суутгалаар 578.6 сая төгрөгийг, ар гэрээс нь 422.0 сая төгрөгийг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 275.4 сая төгрөгийг төвлөрүүлж, нас барсан 10 төлбөр төлөгчийн төлбөрийн үлдэгдэл 72.4 сая төгрөгийг төлбөр төлөлтөд тооцсон бөгөөд өнөөдрийн байдлаар 261 төлбөр төлөгчөөс төлбөрийн үлдэгдэл 1.9 тэрбум төгрөгийг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаагаас хорих ял эдэлж байгаа 1.6 тэрбум төгрөгийн 215 төлбөр төлөгч байна.

Зөрчлийн хариуцлага тооцсон тухай

Иргэний, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээдийн саад учруулсан, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах хууль ёсны шаардлага биелүүлээгүй, төлбөр төлөхөөс зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэхүйг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгчдээс Зөрчлийн тухай хуулийн 6.20, 15.2, 15.27 дугаар зүйлийг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

2023 онд Зөрчлийн тухай хуулийн 6.20, 15.2, 15.27 дугаар хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу ахлах шийдвэр гүйцэтгэгчдээс 76 зөрчлийн холбогдогчид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хялбаршуулсан журмаар 13 холбогдогчид 3.1 сая төгрөгийн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 11 холбогдогчид 11,4 сая төгрөгийн, хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн 14 төлбөр төлөгчид 1400,0 мянган төгрөгийн торгох шийтгэл, 22 төлбөр төлөгчид 7-30 хоногийн баривчлах шийтгэл, албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг, 2024 онд 90 зөрчлийн холбогдогчид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хялбаршуулсан журмаар 29 холбогдогчид 8.7 сая төгрөгийн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 5 холбогдогчид 665 сая төгрөгийн, хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн 19 төлбөр төлөгчид 1900,0 мянган төгрөгийн торгох шийтгэл, 31 төлбөр төлөгчид 7-30 хоногийн баривчлах шийтгэл, албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг шүүхээр тус тус тогтоолгосон мэдээллийг хүргүүлэн ажилласан.

Гэмт хэргийн хохирол, төлбөр барагдуулалт

2023 онд 224.1 тэрбум төгрөгийн 1856 төлбөртэй хоригдол, 2024 онд 215.9 тэрбум төгрөгийн 1880 төлбөртэй хоригдол хорих ангид ял эдэлж байсан.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулах ажлын хүрээнд 2023 онд хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс 353.1 сая төгрөг, 2024 онд 583.4 сая төгрөг суутгасныг гүйцэтгэх баримт бичигт заасан хохирол, төлбөрт тооцон шилжүүлсэн байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр хохирол, төлбөр гаргуулах гүйцэтгэх баримт бичгийг албадан гүйцэтгүүлэхээр 2023-2024 онд нийт 223.189.887.8 төгрөгийг төлбөр авагч иргэнд, 275.628.557.1 төгрөгийг төлбөр авагч-хуулийн этгээдэд, 26.825.585.7 төгрөгийг улсын орлогод оруулах нийт 19822 гүйцэтгэх баримт бичгийг шүүх, төлбөр авагчдаас тус тус ирүүлсэн байна.

-2023 онд 109.971.336,6 төгрөгийн 8146 гүйцэтгэх баримт бичгийг;

-2024 онд 188.686.204.8 төгрөгийн 6879 гүйцэтгэх баримт бичгийг тус тус шинээр хүлээн авчээ.

2023 онд улсын хэмжээнд эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр хохирол, төлбөр гаргуулах 204.126.339.0 төгрөгийн 10555 гүйцэтгэх баримт бичигт, 2024 онд 321.517.691.6 төгрөгийн 9267 гүйцэтгэх баримт бичигт тус тус шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж, 2023 онд 20.901.867.3 төгрөгийг, 2024 онд 31.014.805.4 төгрөгийн хохирол, төлбөрийг барагдуулсан.

Эрүүгийн хохирол, төлбөр барагдуулах ажлын хүрээнд 2023 онд 6712, 2024 онд 5003 гүйцэтгэх баримт бичгийг эцэслэн шийдвэрлэж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангажээ.

Зөрчлийн шийтгэл, хохирол барагдуулалт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан 13.9 тэрбум төгрөгийн 6354 гүйцэтгэх баримт бичигт 2023 онд, 15.6 тэрбум төгрөгийн 10670 гүйцэтгэх баримт бичигт 2024 онд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, нийт 12.2 төгрөгийн 6253 гүйцэтгэх баримт бичгийг эцэслэн шийдвэрлэсэн.

2023 онд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийг авч үзвэл:

- 6196 гүйцэтгэх баримт бичгийн 5.6 тэрбум төгрөгийн торгох шийтгэл;
- 5 гүйцэтгэх баримт бичгийн 68.3 сая төгрөгийн зөрчил үйлдэж, олсон хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээг;
- 38 гүйцэтгэх баримт бичигт холбогдох зөрчлийн үр дагавар, хохирол 14.2 сая төгрөгийн төлбөрийн албадан гүйцэтгэх ажиллагаа явагдсан.

2024 онд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийг авч үзвэл:

- 5703 гүйцэтгэх баримт бичгийн 7.1 тэрбум төгрөгийн торгох шийтгэл;
- 7 гүйцэтгэх баримт бичгийн 63.0 сая төгрөгийн зөрчил үйлдэж, олсон хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээг;
- 2991 гүйцэтгэх баримт бичигт холбогдох зөрчлийн үр дагавар, хохирол 9.1 сая төгрөгийн төлбөрийн албадан гүйцэтгэх ажиллагаа явагдсан байна.

Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг мөнгөн дүнгээр үнэлэн тогтоох практик янз бүрээр тогтож байгаа бөгөөд ихэнх мөрдөгч, прокурор, шүүгч гэмт хэргийн хор уршгийг иргэний гэм хор, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль үйлчилж байх үед тогтсон эрүүгийн процесс дахь иргэний нэхэмжлэлтэй андуурах ойлголтын зөрүү байсаар байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гэмт хэргийн улмаас учирсан амь нас, сэтгэл санаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, эдийн бус хохирлыг мөнгөн дүнгээр үнэлэх, тооцох аргачлалыг бий болгох шаардлага үүсэж байна.

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн гэмт хэргийн улмаас хүний бие махбод, сэтгэл санаанд учирсан хохирлын үнэлгээний заавар, журам, аргачлалыг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх хүний бие махбод, эд эрхтний үнэлгээг бий болгох нь зүйтэй. Тухайлбал, Оросын Холбооны Улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэн олгож, нөхөн төлбөр олгохдоо тухайн гэм буруутай этгээдээс гаргуулж, эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашиглаж байна.

Гадаадын зарим улсын сайн жишгийг судлах замаар сэтгэл санааны хохирлыг тооцож үнэлэх, нөхөн олгох эрх зүйн орчин, практикийг бий болгох шаардлагатай. Тухайлбал, шүүх эмнэлгийг сэтгэц гэм судлалын шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлж, хүний сэтгэл санааны хохирол тооцох аргачлалыг бий болгож, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллагаас гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг зөв тогтоох, бодит үнэлгээг гаргуулах, нөхөн төлбөрийг баталгаатай болгох зорилгоор хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах



ажиллагааг мөрдөн шалгах ажиллагааны явцад өргөн хэрэглэх нь хохирогчийн эрхийг хангахад ач холбогдолтой.


Эрүүгийн хэрэгт гэмт хэргийн хор уршгийг иргэний хэргийн гэм хортой андуурч тусад нь шийдвэрлэхээр шүүхийн тогтоолд дурдаж байгаа явдлыг халах, хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах процессыг нэг мөр шийдвэрлэж байх хэрэгтэй байна.

--oOo--



НАЙМДУГААР БҮЛЭГ

ХҮҮХЭД ХОХИРСОН БОЛОН ХҮҮХДИЙН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ- CHILD VICTIM OFFENSE, JUVENILE DELINQUENCY



Хүүхдийн эсрэг үйлдсэн, хүүхэд хохирсон болон хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Хүүхдийн эрхийг хамгаалах нь өнөөгийн нийгэмд тулгамдсан, нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай асуудлын нэг бөгөөд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг нь хүний эрхийн ноцтой зөрчил юм.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйлд: “18 насанд хүрээгүй хүнийг хүүхэд гэж үзнэ. Харин тухайн улсын хуулиар насанд хүрэх насыг түүнээс доогуур тогтоосон бол тэр насыг хэрэглэнэ.”, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3.1-д: “18 насанд хүрээгүй иргэнийг хүүхэд гэж ойлгоно.” гэж тус тус тодорхойлсон байдаг. Хүүхэд нь нийгмийн хамгийн эмзэг бүлэгт хамаарахын зэрэгцээ хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийлэл нь зөвхөн тухайн хувь хүний амьдралд хүнд хор уршиг учруулах төдийгүй улс орны тогтвортой хөгжил, нийгмийн эрүүл орчны үндсийг алдагдуулдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хүүхдийн эсрэг гэмт хэрэг, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг үл хайхрах, цахим орчин дахь хүчирхийллийн асуудал ноцтой түвшинд хүрсэн байна. Энэ нөхцөл байдал нь зөвхөн хууль сахиулах байгууллагын асуудал биш, харин боловсрол, эрүүл мэндийн байгууллага, иргэний нийгэм, олон нийт хамтран ажиллах зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Иймд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд эрх зүйн зохицуулалт, тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын туршлагыг нутагшуулах, хүүхэд хамгааллын цогц бодлогыг хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Монгол Улсад жил бүр бүртгэгдэж буй гэмт хэргийн бүтцэд хүүхдийн эсрэг гэмт хэрэг 5–8 хувийг эзэлж байна. Сүүлийн таван жилд хүүхдийн бэлгийн хүчирхийллийн тохиолдол тасралтгүй өссөн үзүүлэлттэй байгаа нь нөхцөл байдлын ноцтойг илэрхийлнэ.

Энэ төрлийн гэмт хэрэг нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүй, хөгжилд ихээхэн хохирол учруулахаас гадна ирээдүйд нийгмийн гажуудал, гэмт хэрэгт өртөмтгий байдал, итгэл алдагдах зэрэг сөрөг үр дагавар бий болгодог.

Дэлхийн хэмжээнд хүүхдийн эсрэг гэмт хэргийн асуудал нь нийтлэг сорилт хэвээр байсаар байна. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989) нь хүүхдийн эрхийг хамгаалах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон улсын эрх зүйн үндэс болсон бол Ланзаротын конвенц (2007) нь хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлд Европын бүсийн онцгой баримт бичиг болжээ. Хөгжингүй орнуудад хүүхэд хамгааллын “Barnahus” төв (Исланд, Швед, Финланд), “Child Advocacy Center” (АНУ), сургуульд суурилсан “School Safety Program” (БНСУ), цахим орчны “Safer Internet Centres” (ЕХ)-ийн туршлага үр дүнгээ өгч байна. Эдгээр нь салбар хоорондын хамтын ажиллагаа, нэгдсэн үйлчилгээний загварыг бий болгож, хохирогч хүүхдийг дахин хохирох явдлыг багасгахад чиглэжээ.

Олон улсад, тэр дундаа Исланд, Швед, Финландын “Barnahus” загвар нь хүүхдийн эсрэг гэмт хэрэгт өртсөн хохирогчид нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үр дүнтэй арга хэлбэр юм. АНУ-д “Child Advocacy Center”-ууд ажиллаж, хүүхдийн мэдүүлгийг зөвхөн нэг удаа авч, бүх нотлох ажиллагааг нэг дор төвлөрүүлдэг. БНСУ-ын сургуулийн хүрээнд цахим хүчирхийлэлтэй тэмцэх тусгай нэгж байгуулж, сурагчдын цахим орчинд хамгаалах бодлогыг хэрэгжүүлдэг. Европын холбоонд “Safer Internet Centres” ажиллаж, хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах, эцэг эх, багшид зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тус тус явуулдаг.

Монгол Улсын хувьд хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орсон бөгөөд Үндсэн хуульд хүүхдийг төрийн онцгой хамгаалалтад байна гэж заасан. Үүний зэрэгцээ, “Хүүхдийн эрхийн тухай хууль” (2016), “Хүүхэд хамгааллын тухай хууль”

(2016), мөн Эрүүгийн хууль (2015, шинэчилсэн найруулга)-д хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх суурь зохицуулалтыг хуульчилсан.

Гэсэн хэдий ч, хууль тогтоомжид тодорхойгүй зохицуулалт, давхардал, хуулийн хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлууд байна. Тухайлбал, “Груминг” болон цахим хүчирхийллийг тусгайлан ялгаж хуульчилсан зохицуулалт сул байна. Практик байгууллагын үйл ажиллагаанд, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт өртсөн хохирогчийн мэдүүлгийг олон удаа авч, хоёрдогч хохирол үүсгэх тохиолдол ажиглагдаж байна. Эдгээр нь зөвхөн хууль тогтоомжийн хүрээ бус, харин хэрэгжилтийн институтийн чадавх, хяналт-үнэлгээний тогтолцоотой холбоотой сул талууд юм.

1.Хүүхэд хохирсон гэмт хэргийн нөхцөл байдал

Гэмт хэргийн улмаас 2024 онд 19956 хүн хохирогчоор бүртгэгдсэнээс 902 нь хүүхэд, 449 хүн нас барснаас 43 нь хүүхэд, нийт 8088 хүн гэмтсэнээс 399 нь хүүхэд байна.

Хүснэгт 1.2023, 2024 онд гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоон үзүүлэлт, харьцуулалт

Хохирогчийн нас	Гэмт хэрэг	2023 он		2024 он	
		Хүүхэд хохирсон гэмт хэргийн тоо	Өсөлт/ Бууралт	Хүүхэд хохирсон гэмт хэргийн тоо о	Өсөлт/ Бууралт
7 хүртэлх	Улсын хэмжээний нийт дүн	212	34	252	40
	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	28	2	49	21
	Хүнийг алах	3	0	3	0
	Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	14	-2	18	4
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	10	4	26	16
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	48	8	49	1
	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	1	0
	Хүн хулгайлах	1			
	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	21	-7	37	16
	Хүчиндэх	20	-5	29	9
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	-	4	0
	Хулгайлах	2	-	3	1
	Мал хулгайлах	2	-		
	Дээрэмдэх	2	-	1	-1
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг эсрэг гэмт хэрэг	-	-	1	-
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	96	22	89	-7
	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3	0	5	2
	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	11	5	17	6
8-13 нас	Улсын хэмжээний нийт дүн	660	11	887	227
	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	2	10	2
	Хүнийг алах	1	0		
	Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	4	1	4	0
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	3	1	6	3
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	205	-2	217	12
	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	3	12	9
	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	165	2	187	22
	Хүчиндэх	150	-2	173	23


	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг			2	
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	159	1	342	183
	Хулгайлах	93	20	245	152
	Мал хулгайлах	21			
	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	-	-	1	-
	Дээрэмдэх	21	-8	16	-5
	Залилах	23	-10	26	3
	Хөрөнгө завших	-	-	-	-
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг эсрэг гэмт хэрэг	-	-	2	-
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	89	8	94	5
	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	-	-	2	-
	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	31	0	19	-12
14-17 нас	Улсын хэмжээний нийт дүн	1,343	156	1,797	454
	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	11	-3	18	7
	Хүнийг алах	3	0	3	0
	Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	1	-3	3	2
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	7	0	11	4
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	449	22	477	28
	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	18	2	31	13
	Хүн худалдаалах	5	-2	10	5
	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	355	88	374	19
	Хүчиндэх	225	40	234	9
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	416	47	758	342
	Хулгайлах	212	9	512	300
	Мал хулгайлах	48			
	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах			4	
	Дээрэмдэх	48	2	55	7
	Залилах	99	37	118	19
	Хөрөнгө завших	2	-1	2	0
	Эдийн засгийн гэмт хэрэг	-	-	-	-
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг эсрэг гэмт хэрэг	-	-	1	-
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	62	-13	114	52
	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2		3	1
	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	-	-	2	-
	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	0		
	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	29	15	19	-10

График 1.Хохирсон хүүхдийн төрөл, насны ангилал



Цагдаагийн байгууллагын статистик мэдээгээр 2024 онд гэмт хэргийн улмаас 2936 хүүхэд хохирч, үүнээс 111 хүүхэд нас барж, 997 хүүхэд гэмтсэн нь өмнөх онтой харьцуулахад хохирсон хүүхэд 721 буюу 32.6%-иар, нас барсан хүүхэд 12 буюу 12.1%-иар, гэмтсэн хүүхэд 111 буюу 12.5%-иар тус тус өссөн байна.

График 2.Хүүхдэд учирсан хохирлын хэмжээ



Гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хүнд 6924.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх онтой харьцуулахад 2235.0 сая төгрөг буюу 47.7%-иар өссөн байна.

2.Тодорхой төрлийн гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо, мэдээ

2.1.2024 онд Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт заасан “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг” нийт 66 бүртгэсэн нь өмнөх оноос 2 хэргээр буюу 2.9%-иар буурсан бол, нийслэлд 55 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 8 хэргээр буюу 17%-иар өссөн, орон нутагт 11 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 10 хэргээр буюу 47.6%-иар буурсан байна.

2.2.Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл буюу “Хүчиндэх гэмт хэрэг” гэмт хэргийн улмаас 675 иргэн хохирсон бөгөөд үүнээс 436 буюу 64.6% нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 7 нь хүүхэд байна гэсэн үг юм.

Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн” 139 хүнд холбогдох нийт 130 эрүүгийн хэрэгт шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь өмнөх оноос хэрэг 12 буюу 8.4%-иар, хүн 7 буюу 4.8%-иар тус тус буурчээ.

Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 29 буюу 4.3% нь 7 хүртэлх, 173 буюу 25.6% нь 8-13 насны, 234 буюу 34.7% нь 14-17 насны хүүхэд байна.

График 3.Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо




График 4.Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэргийн түвшин




Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэргийн гаралт мөн сүүлийн 10 жилийн хугацаанд буурахгүй, тогтмол өссөн байна. Хүүхэд, тэр дундаа бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн хүчиндэх гэмт хэрэг нь дан ганц хохирогчдын эрүүл мэнд, бие махбодод гэмтэл учрахаас гадна, тэдний сэтгэл зүйд ноцтой гэмтэл учруулан, тухайн хүүхдийн ирээдүй, ёс суртахууны хөгжилд сөргөөр нөлөөлдөг.

2.3.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагад 2024 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1559 бүртгэгдсэн бөгөөд үүний 203 буюу 12.9%-ийг нь хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оноос 32 буюу 18.7%-иар өсжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор төрсөн хүүхэд 86, дагавар хүүхэд 43, үрчилж авсан хүүхэд 2 байна.

График 5.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн төрөл



2.4.Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Улсын хэмжээнд 2024 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 1230 бүртгэгдсэний 842 буюу 68.5% нь нийслэлд, 388 буюу 31.5% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад улсын хэмжээнд 45.4%, нийслэлд 78.0%, орон нутаг 4.0%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 2.Хүүхэд хохирсон зам тээврийн ослын тоо

Хүүхэд өртсөн зам тээврийн осол	Нийт хохирсон хүүхэд	Нас барсан хүн, хүүхэд	Гэмтсэн хүүхэд
Улсын хэмжээнд			
1230	1377	69	1308
Улаанбаатар			
842	927	11	916
Орон нутаг			
388	450	58	392

График 6.Нийслэлийн дүүргүүдийн нутаг дэвсгэрт хүүхэд өртсөн зам тээврийн ослын тоо





График 7.Орон нутагт хүүхэд өртсөн зам тээврийн ослын тоо



Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон, гэмтсэн хүүхэд

Зам тээврийн ослын улмаас нийт 69 хүүхдийн амь нас хохирч, 1308 хүүхэд гэмтэл, бэртэл авсны 239 хүүхдийн эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр зэргийн хохирол учирчээ.

№	Аймаг, дүүрэг	Нас барсан хүүхэд			Гэмтэж бэртсэн хүүхэд		
		2023 он	2024 он	Харьцуулалт (абсолют болон харьцангуй үзүүлэлт)	2023 он	2024 он	Харьцуулалт (абсолют болон харьцангуй үзүүлэлт)
1	Архангай	4	3	-25	17	17	0
2	Баян-Өлгий	1	8	8д	8	13	62.5
3	Баянхонгор	1	3	3д	16	13	-18.8
4	Булган	1	4	4д	17	15	-11.8
5	Говь-Алтай	1	5	5д	6	3	-50
6	Говьсүмбэр	0	0	0	5	2	-60
7	Дархан-Уул	0	1	0	37	40	8.1
8	Дорноговь	2	5	2.5д	20	27	35
9	Дорнод	1	1	0	19	24	26.3
10	Дундговь	1	0	0	9	8	-11.1
11	Завхан	3	1	66.7	13	13	-
12	Орхон	0	0	0	27	29	7.4
13	Өвөрхангай	2	2	0	13	15	15.4
14	Өмнөговь	1	3	3д	15	11	-26.7
15	Сүхбаатар	6	2	-66.7	23	18	-21.7
16	Сэлэнгэ	2	4	2д	23	35	52.2
17	Төв	8	3	-62.5	24	33	37.5
18	Увс	2	2	0	26	7	-73.1
19	Ховд	3	1	-66.7	29	37	27.6
20	Хөвсгөл	3	6	2д	14	17	21.4
21	Хэнтий	8	4	-50	34	15	-55.9
Орон нутаг		1164	50	58	16	395	392
22	Баянгол	-	-	-	73	153	2.1д
23	Баянзүрх	-	2	-	117	210	79.5
24	Сүхбаатар	-	-	-	71	129	81.7
25	Сонгинохайрхан	3	4	33.3	93	141	51.6
26	Хан-Уул	-	1	-	91	174	91.2
27	Чингэлтэй	-	2	-	44	90	2д
28	Багануур	-	2	-	4	7	75.0
29	Багахангай	-	-	-	2	-	-
30	Налайх	-	-	-	10	12	20.0
Нийслэл		1895	3	11	3.7д	505	916
УЛС		3059	53	69	30.2	900	1308

График 8.Хүүхэд зам тээврийн осолд өртсөн хэлбэр



Зам тээврийн ослын нэг гол шалтгаан нь хүүхдийг, тэр дундаа 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах явдал юм. Энэ нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7-д “эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх” гэж заасныг үл биелүүлсэнтэй холбоотой. Хуульд заасан энэхүү үүргийг биелүүлээгүйгээс болж хүүхэд замын хөдөлгөөнд оролцох чадваргүй, дүрэм ойлгох туршлагагүй учраас зам тээврийн осолд өртөх эрсдэл нэмэгддэг. Ийм зөрчил гаргасан тохиолдолд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 54 дэх хэсэгт зааснаар холбогдох этгээдэд торгуулийн арга хэмжээ ногдуулдаг.

Хүснэгт 4.Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн насны ангилал

№	Насны ангилал		
	0-7 нас	8-14 нас	15-17 нас
Улсын хэмжээнд			
1	377	598	402
Орон нутагт			
2	176	178	96
Нийслэлд			
3	201	420	306

Хүснэгт 5.Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр

Үзүүлэлт	Явган зорчигч	Зорчигч	Дугуйгаар зорчигч	Бусад жолооч
Нийслэл				
Тоон үзүүлэлт	586	125	100	116
Орон нутаг				
Тоон үзүүлэлт	226	192	19	13
Улс				
Тоон үзүүлэлт	812	317	119	129

Хүснэгт 6.Явган зорчигч ба дугуйтай хүний буруутай үйлдлээс шалтгаалсан осол

Төв, орон нутаг	Явган хүний буруугаас	Дугуйтай хүний буруугаас	Явган зорчигч явган хүний гарц гарамтай хэсгийн гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарсан	Явган зорчигч гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарсан	Ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн үйлдвэр гүйсэн	Явган зорчигч согтуугаар	Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр хөдөлгөөнд оролцуулсан
Нийслэл	36	54	137	150	65	79	141
Орон нутаг	25	8	7	26	7	18	6
Улс	61	62	144	176	72	97	147

Явган зорчигч согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцож хохирсон 97 осол бүртгэгдсэний 79 буюу 81.4% нь нийслэлд, 18 буюу 18.6% нь орон нутагт бүртгэгдсэн.

Мөн 2024 онд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 7 хүүхэд бүртгэгдсэн байна.

3.Мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх болон ял эдлүүлэх ажиллагаанд оролцсон хүүхдийн мэдээлэл

3.1.Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр авсан арга хэмжээ

Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/01 дүгээр тушаалаар “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн баталж, насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний шаардлагад гэрч, хохирогч хүүхэд, өсвөр насны сэжигтэн, яллагдагчтай ярилцах, мэдүүлэг авах ажиллагааг тэдгээрийн нас, бие, сэтгэл зүйн онцлогт тохирсон, хүүхдэд ээлтэй, тав тухтай орчинд явуулах, ярилцлага, мэдүүлгийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаас гадна Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын харьяа байгууллагуудад байгуулж болох зохицуулалтыг шинээр нэмж тусган олон улсын гэрээ, конвенцод нийцүүлсэн байна.

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хүрээнд “Ял эдлүүлэх ажиллагаанд хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар зохицуулсан Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцын хэрэгжилт”-ийг шалгаж, олон улсын гэрээ конвенц, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хугацаатай албан бичиг, холбогдох хуульд нэмэлт оруулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад тус тус хүргүүлсэн байна.

Хүснэгт 7.Хүүхэд өртөж хохирсон гэмт хэргийн шийдвэрлэлт

№	Зарим төрлийн гэмт хэрэг	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт		Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт			Мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт			
		Хэргийн тоо	Өсөлт, бууралт	Хаасан	ЭХҮЯТ	Нэгтгэсэн	Шүүхэд шилжүүлсэн	Хэрэгсэхгүй болгосон	Түдгэлзүүлсэн эн	Нэгтгэсэн
1	Гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэрэг	4013	+17%	840	828	-	1174	272	-	2

2024 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэгт 45358 хүнийг хохирогчоор тогтоогдсоны 3102 буюу 6.8% нь насанд хүрээгүй хохирогч байна.

Гэмт хэргийн улмаас 449 хүн нас барснаас 43 нь, 8088 хүн гэмтсэнээс 399 нь хүүхэд байна. Улсын хэмжээнд хүүхэд хохирсон нийт 689 гэмт хэрэгт 737 шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна. Мөн шүүхээс насанд хүрээгүй 8 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна.

3.2.Сургалт, судалгааны чиглэлээр

Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн байдал, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл”-ийг сүүлийн 2 жилийн байдлаар судалж, “Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа” гарын авлага эрхлэн гаргаж, нийслэл, дүүргийн прокуроруудад “Цахим орчин дахь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт, анхаарах асуудал” сэдвээр, Хүн худалдаалахтай тэмцэх хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох журмын талаар хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны асуудал эрхэлсэн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна.

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шийдвэрлэлт”-ийг сүүлийн 4 жилийн байдлаар судалж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд яриа, таниулга хийж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, цагдаагийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын хамтарсан багийн төлөөллийг хамруулан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд судалгаагаар тогтоогдсон нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал хүргүүлжээ.

“Хүүхдийн эсрэг болон хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шийдвэрлэлт”-ийн байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар судалж, гэмт хэрэг ихээр үйлдэгдсэн хороод, ерөнхий боловсролын сургуулиудад мэдэгдэл бичиж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага гарган тарааж, богино хэмжээний шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээсэн байна.

3.3.Оногдуулсан ял, албадлагын арга хэмжээний төрөл

2024 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс улсын хэмжээнд нийт 131 хүүхдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс өсвөр насны 38 хүний шийтгэх тогтоолыг хойшлуулсан байна.

Хүснэгт 8.Хүүхдийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж, хорих ял эдлэгсдийн тоо

№	Гэмт хэргийн зүйлчлэл	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	16	60	44	275

Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэж байна.



Хүснэгт 9.Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн судалгаа
(Улаанбаатар хотын хэмжээнд)

№	Зөрчлийн тухай хуулийн заалт	Өсөлт, бууралт			
		2023	2024	Тоо	Хувь
1	Хүүхдийн эрх зөрчих /ЗТХ-6.20.6/	9	10	1	11.11
2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /ЗТХ-5.4.4/	5490	5598	108	1.97

4.Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал


Үүний зэрэгцээ, гэр бүлийн үл хайхрал, хүчирхийлэл, архидалт зэрэг сөрөг орчин, сургуулийн орчин дахь гадуурхал, үе тэнгийн дарамт шахалт, ядуурал, нийгмийн шударга бус байдал зэрэг эдийн засаг, нийгмийн хүчин зүйл, мөн өсвөр насны сэтгэлзүйн тогтворгүй байдал, бусдын нөлөөнд автах зэрэг хувь хүний онцлогоос шалтгаалан хүүхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэх тохиолдол нэмэгдэх хандлагатай байна.

Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 2024 онд 1373 бүртгэгдсэн нь өмнөх оноос 103 буюу 8.1%-иар, нийслэлийн хэмжээнд 971 бүртгэгдсэн нь 180 буюу 22.8%-иар тус тус өсөж, орон нутагт 402 бүртгэгдсэн нь 77 буюу 16.1%-иар буурсан байна.

Хүснэгт 10.Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2023 он	2024 он		2023 он	2024 он
Улсын хэмжээнд	1270	1373	8.1	3.6	3.1
Нийслэлд	791	971	22.8	3.2	3.0
Орон нутагт	479	402	-16.1	4.5	3.2

График 9. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн түвшин (2005-2024 он)



Хүснэгт 11.Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн тоо (Эрүүгийн хуулийн зүйл ангиар)

Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо			Нийт насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн хэрэгт эзлэх хувь
	2023 он	2024 он	Өсөлт, бууралт /хувиар/	
Хүнийг алах		3		0.2
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	383	366	-4.4	26.7
Хүчиндэх	38	23	-39.5	1.7

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг		798	885	10.9	64.5
Үүнээс	Хулгайлах	381	363	-4.7	26.4
	Залилах	295	378	28.1	27.5
	Дээрэмдэх	52	41	-21.2	3.0
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодсыг хууль бусаар ашиглах		5	9	80.0	0.7
ХАБТХАЖЭ		14	21	50.0	1.5
Бусад		32	66	2.1 дах	4.8

4.1.Хүүхдийн үйлдсэн гэмт хэргий үйлдэгдсэн цаг, гараг, газар

Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 211 буюу 15.4% нь Даваа гарагт, 215 буюу 15.7% нь Мягмар гарагт, 204 буюу 14.8% нь Лхагва гарагт, 214 буюу 15.6% нь Пүрэв гарагт, 163 буюу 11.8% нь Баасан гарагт, 184 буюу 13.4% нь Бямба гарагт, 182 буюу 13.3% нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 469 буюу 34.2% нь 06:00-14:00 цагт, 344 буюу 25.1% нь 14:00-19:00 цагт, 179 буюу 13.0% нь 19:00-22:00 цагт, 381 буюу 27.7% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 12.Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн цаг, гараг, газар

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00		3			2		1	6
01:00	12	13	8	14	4	16	12	79
02:00	5	10	15	4	11	5	11	61
03:00	7	2	5	6	5	2	4	31
04:00	5	10	4		6	7	8	40
05:00	7	6	3	6	3	3	4	32
06:00	5	3		3	1	2	2	16
07:00	3	3	3	6	2	4	5	26
08:00	7	8	5	6	4	6	4	40
09:00	4		1	6	3	5	5	24
10:00	19	25	22	25	16	29	20	156
11:00	11	10	11	8	11	8	6	65
12:00	8	12	3	5	1	7	3	39
13:00	19	11	25	18	8	10	12	103
14:00	18	14	18	13	11	6	9	89
15:00	6	13	7	3	2	6	6	43
16:00	16	13	20	7	16	13	14	99
17:00	10	9	15	17	11	10	8	80
18:00	6	7	4	4	6	3	3	33
19:00	7	15	5	9	12	8	10	66
20:00	14	6	12	23	2	10	9	76
21:00	4	3	3	5	4	8	10	37
22:00	8	12	5	13	6	6	9	59
23:00	10	7	10	13	16	10	7	73
Нийт	211	215	204	214	163	184	182	1373

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 351 буюу 25.6% нь гэр, орон сууцанд, 428 буюу 31.2% нь гудамж талбайд, 108 буюу 7.8% нь олон нийтийн газарт,



7 буюу 0.5% нь нийтийн тээвэрт, 14 буюу 1.0% нь төрийн байгууллагад, 20 буюу 1.5% нь төрийн бус байгууллагад, 108 буюу 7.8% нь аж ахуйн нэгжид, 20 буюу 1.5% нь авто зам дээр, 317 буюу 23.1% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Зураг 1. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн газрын харьцуулалт



4.2. Хүүхэд гэмт хэрэг үйлдсэн байдал

Бүртгэгдсэн гэмт хэргийн 50 буюу 3.6% нь согтуугаар, 10 буюу 0.7% нь мансуурсан үедээ үйлдсэн, 3 буюу 0.2% нь галт зэвсгээр үйлдэгдсэн, 91 буюу 6.6% нь эмэгтэй хүн оролцож, 12 буюу 0.9% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 234 буюу 17.0% нь бүлэглэн, 407 буюу 29.6% нь цахимаар үйлдсэн байна.

Зураг 2. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн ерөнхий нөхцөл байдал



4.3. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн илрүүлэлт

Хэрэг бүртгэлтийн 1224 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 161 хэрэг буюу 15.1%-иар, үүнээс 1223 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 161 буюу 15.2%-иар тус тус өссөн.


Тухайн гэмт хэргийн илрүүлэлт 99.9 хувь байгаа нь өмнөх оны түвшинд байна.

График 10. Энэ төрлийн гэмт хэргийн сүүлийн 10 жилийн илрүүлэлтийн хувь (хэргийн ангиллаар)



Нийт 1675 хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 81 буюу 5.1%-иар өссөн. Холбогдогчдын 98 буюу 5.9% нь эмэгтэй, 1577 буюу 94.1% нь эрэгтэй хүүхэд эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмэгтэй хүүхэд 193 буюу 66.3%-иар буурч, эрэгтэй хүүхэд 274 буюу 21.0%-иар өссөн байна.

График 11. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн нас, хүйс, боловсролын түвшин



Шүүхээс анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулсан шийдвэрийг ялтны оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас хяналт тавьж хэрэгжүүлж байна.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэсэн шийдвэрийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, нэгдсэн тоо бүртгэл хөтөлж байна.

5. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүний нийтлэг шинж

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүний шинжийг судлах нь урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой. Судалгааны үр дүн, олон улсын туршлагаас харахад гэмт хэрэг үйлдэгчдийн сэтгэл зүйн, зан төлөвийн болон нийгмийн нийтлэг шинж чанарууд руу чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулсан байна.

Нэгдүгээрт, сэтгэл зүйн болон зан төлөвийн шинж. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн дийлэнх нь бага насандаа хүчирхийлэлд өртсөн, эсвэл анхаарал халамжгүй дутуу нөхцөлд өссөн байдаг. Энэ нь хүчирхийлэл үе дамжин дамжих үзэгдэл бий болгодог. Мөн түрэмгий зан төлөв давамгайлсан, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар сул, эмпатийн мэдрэмж багатай хүмүүс энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг.

Хоёрдугаарт, архидалт ба донтолт. Монголын нөхцөлд хүүхдийн эсрэг гэмт хэргийн олон тохиолдол архины хэтрүүлсэн хэрэглээтэй холбоотой байдаг. Согтуурсан үедээ хяналтаа алдах, түрэмгий зан авиртай болох нь хүүхдийг хүчирхийлэх нөхцөл болдог. Мөн мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын хэрэглээ нь хүчирхийллийн эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Гуравдугаарт, бэлгийн гаж чиг хандлага, садар самуун зан үйл. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүст педофилийн шинж ажиглагддаг бөгөөд энэ нь хүүхдийг бэлгийн хүслээ хангах хэрэгсэл мэтээр үзэх хандлагаар илэрдэг. Өнөө цагт цахим орчин дахь “грумминг” буюу хүүхдийг сэтгэл санаагаар уруу татах, итгэлийг олж бэлгийн хүчирхийлэл үйлдэх шинэ хэлбэр нэмэгдэж байна.

Дөрөвдүгээрт, нийгмийн байр суурь ба орчны шинж. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчид ихэвчлэн хохирогчтой ойрын хүрээлэлтэй байдаг. Эцэг эх, хамаатан садан, хөрш, найзын танил, эсвэл итгэл хүлээсэн мэргэжлийн байр суурь эзэлдэг хүмүүс (багш, дасгалжуулагч, шашны төлөөлөгч гэх мэт) энэ төрлийн гэмт хэрэгт илүүтэйгээр холбогддог нь олон улсын судалгаагаар тогтоогдсон. Энэ нь хүүхдийг итгэж болох орчиндоо ч эрсдэлд орох нөхцөл байгааг харуулж байна.

Тавдугаарт, сэдэл. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх шалтгаан нь олон төрөлтэй байна. Зарим тохиолдолд эрх мэдлээ ашиглан давамгайлал тогтоох зорилгоор хүчирхийлэл үйлддэг бол зарим нь бэлгийн хүслээ буруу аргаар хангах зорилготой байдаг. Үүний зэрэгцээ, эдийн засгийн ашиг сонирхлоор хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгодог.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг нь нийгмийн олон хүчин зүйлсийн нийлбэр дүнд бий болж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн хууль сахиулах байгууллагын хэмжээнд бус, эрүүл мэндийн, боловсролын, сэтгэл зүйн, нийгмийн халамжийн иж бүрэн бодлого шаардлагатай байна.

Хүүхдийн эрхийг зөрчих аливаа үйлдэл нь тухайн хүүхдийн амьдралд төдийгүй нийгмийн хөгжлийн чанар, улс орны ирээдүйд сөргөөр нөлөөлөх тул энэхүү асуудлыг бодлого, хууль эрх зүйн орчин, олон нийтийн оролцоо, хүмүүнлэгийн үнэт зүйлстэй уялдуулан тууштай хэрэгжүүлэх шаардлагатай.

Монгол Улс хууль тогтоомжийн хувьд хүүхдийн эрхийг хамгаалах тодорхой алхмууд хийсэн боловч хэрэгжилтийн түвшинд орон нутгийн бодит нөхцөл байдал, хүний нөөцийн чадавх, олон нийтийн оролцоо сул хэвээр байна. Олон улсын тэргүүн туршлагыг нутагшуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийгмийн соёлыг өөрчлөх, салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх замаар хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг нь хувь хүний сэтгэл зүйн онцлог, гэр бүлийн орчин, нийгмийн болон эдийн засгийн нөхцөл, эрх зүйн орчны боловсронгуй бус байдал зэргийн нийлмэл нөлөөгөөр үйлдэгдэж байна. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгч нь ихэвчлэн өөрөө хүчирхийлэлд өртөж байсан түүхтэй, архидалт, зан төлөвийн гажуудалтай, хүүхдийг сул дорой гэж үздэг, ойрын хүрээллийн хүн байх тохиолдол давамгайлдаг. Иймээс гэмт хэрэг үйлдэгчийн шинжийг судалж, эрсдэл өндөртэй бүлгийг эрт илрүүлэх, архидалт болон донтолтын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх магадлалтай бүлгийг хяналтад авах, эцэг эхийн хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээрх боловсролыг нэмэгдүүлэх нь урьдчилан сэргийлэхэд чухал алхам болно.

Үүний зэрэгцээ, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хүүхэд гэмт хэрэгт холбогдох шалтгаан нь ихэвчлэн ядуурал, гэр бүлийн орчин, боловсролын дутагдал, үе тэнгийн нөлөө, цахим орчны сөрөг нөлөөлөл зэрэгтэй холбоотой тул эдгээр суурь хүчин зүйлсийг арилгах нь хамгийн үр дүнтэй урьдчилан сэргийлэх алхам болно. Иймд хүүхдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сургуулийн орчинд хүмүүжлийн ажил, ёс суртахууны төлөвшил, эерэг харилцааг хөгжүүлэх, эцэг эхэд хүүхэд хүмүүжүүлэх сургалт, зөвлөгөө тогтмол олгох, нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчны зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль зөрчсөн тохиолдолд ялын бодлогоос илүүтэйгээр нийгэмшүүлэх, зан үйл засах, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх чиглэлийг түлхүү хэрэглэх шаардлагатай байна. Энэ бүхэн нь хүүхдийн гэмт хэрэг үйлдэх нөхцөл шалтгааныг бууруулж, нийгэмд зөв төлөвшсөн, хариуцлагатай иргэнийг бэлтгэхэд ач холбогдолтой.

ЕСДҮГЭЭР
БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН
БАЙГУУЛСАН АЖИЛ-
PREVENTIVE
MAINTENANCE



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг, 8 дугаар хавсралтаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг, 15 дугаар хавсралтаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг тус тус баталсан.

Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 149 дүгээр тогтоолоор “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн дүрэм”-ийг баталснаар тус сангийн удирдах зөвлөлийн Ажлын албаны чиг үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанд хариуцуулжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2024 онд үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1.Төрийн алба хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг баримтлах, хүний эрхийг дээдэлсэн ёс суртахууныг төлөвшүүлэх сургалт, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг идэвхжүүлэх;

2.Төрийн албаны анхан дунд шатан дахь хүнд суртлыг арилгах, таслан зогсоох, иргэд хувийн хэвшлийг чирэгдүүлж, авлига үүсгэх нөхцөл бүрдүүлж байгаа үйл ажиллагаа, чиг үүргийн талаар дүгнэлт хийж, эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх;

3.Салбар, байгууллагын эрх зүйн соёл (замын хөдөлгөөний соёл г.м)-ыг төлөвшүүлэх, хорт зуршил (согтуурах, мансуурах г.м)-аас ангид байх болон иргэдэд чиглэсэн эрх зүйн соёл, ухамсрыг төлөвшүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

4.Улсын Их хурал, аймаг, сум, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, төрийн байгууллага, төрийн алба хаагчийн онцлог хууль тогтоомжийн зохицуулалтын талаар салбар, байгууллагын хүрээнд мэдээлэл түгээх;

5.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хүн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, идэвх зүтгэл, үр дүн харгалзан урамшуулах;

6.Эрэгтэйчүүдийг жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, чадавхжуулах чиглэлээр соён гэгээрүүлэх, сургалт зохион байгуулах;

7.Иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд цахим технологи, программ хангамж нэвтрүүлэх ажлыг нэмэгдүүлэх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (залилах) болон цахим хэлбэрээр үйлдэгдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх;

8.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэцийн эрүүл мэнд, нөлөөлж буй хүчин зүйлс, түүнийг арилгах, үзүүлэх тусламж үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх;



9.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сурагчид чиглэсэн эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэх зэрэг болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл:

1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд 19 ажил, арга хэмжээ төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн байдлаар 13 ажил, арга хэмжээ 100 хувь, 5 ажил, арга хэмжээ 70 хувь, 1 ажил, арга хэмжээ Гадаад харилцааны яам 0 хувь (тайлан ирүүлээгүй), дундаж 86.8 хувьтай;

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд хүрээнд 23 ажил, арга хэмжээ төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн байдлаар 14 ажил, арга хэмжээ 100 хувь, 5 ажил, арга хэмжээ 70 хувь, 4 ажил, арга хэмжээ 30 хувь, дундаж 81.3 хувьтай;

3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд 6 ажил, арга хэмжээ төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн байдлаар 5 ажил, арга хэмжээ 100 хувь, 1 ажил, арга хэмжээ 70 хувь, дундаж 95 хувьтай;

4.Соён гэгээрүүлэх чиглэлээр 11 ажил ажил, арга хэмжээ төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн байдлаар 10 ажил, арга хэмжээ 100 хувь, 1 ажил, арга хэмжээ 70 хувь, дундаж 97.2 хувьтай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл нийт 59 ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс биелэлт 90.1 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн", өмнөх жилтэй харьцуулбал 3 хувиар өссөн дүнтэй байна.

2.Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил

2.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулах, бүс нутаг дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах, олон улсын чиг хандлагын талаар туршлага судлах, олон улсын хурал зохион байгуулах ажлын хүрээд “Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хамтын ажиллагааны Коломбын төлөвлөгөө” (Colombo Plan) байгууллагын Зөвлөлдөх хорооны 48 дахь удаагийн олон улсын хурлыг 2024 онд Монгол Улс хүлээн авч, Улаанбаатар хотноо зохион байгуулсан. 2024 оны хурал нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эсрэг хүчээ нэгтгэсэн бүс нутгийн төлөө, урьдчилан сэргийлэх ажиллагааг эрчимжүүлэх нь” сэдвийн дор зохион байгуулсан бөгөөд цаашид уг салбарт анхаарах тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, нөөц бололцоог зөв зохистой ашиглах стратеги, хэрэгжүүлж буй техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэх талаар хэлэлцсэн.

Зураг 1. "Colombo Plan" байгууллагын Зөвлөлдөх хорооны 48 дахь хурлын оролцогчид



Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 19-ний өдрүүдэд зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хариуцлагын комиссын 33 дахь удаагийн чуулган” болон НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Монгол дахь суурин төлөөлөгч 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Хар тамхитай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцах үед мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал (каннабис)-ын тархцад хяналт тавих, шинээр тархцын цэгийг олж тогтоох ажилд зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлэх зорилгоор НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас хэрэгжүүлдэг “Хууль бус талбайн хяналтын хөтөлбөр” (Illicit crop monitoring programme)-ийг Монгол Улсад хэрэгжүүлэх саналыг танилцуулж, тулгамдаж байгаа асуудлын талаар харилцан санал солилцож, техник, технологийн талаар тусламж үзүүлэхээ илэрхийлсэн байна.

Зураг 2. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад оролцогчид

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Төрийн Департамент, Коломбын төлөвлөгөө байгууллага хамтран тус байгууллагын Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх зөвлөх хөтөлбөр (Drug Advisory Program)-ийн Урьдчилан сэргийлэх модулийн Түвшин 10 буюу “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх” сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 6 хоногийн хугацаатайгаар зохион байгуулсан.



Сургалтыг олон улсын багш нар зааж буй бөгөөд сургалтад эрүүл мэнд, хууль сахиулах, төрийн бус байгууллагын холбогдох мэргэжилтэн, албан хаагч, эмч нар хамрагдаж гэрчилгээ авсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Устгал-2024” нэгдсэн арга хэмжээг 2024 оны 6-7 дугаар саруудад тархац бүхий 11 аймаг, нийслэл хотын хэмжээнд зохион байгууллаа.

НҮБ-ын 1961, 1971, 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцын хавсралтад орсон бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гаалийн байгууллагаас сэжигтэй ачаа, тээш, эд зүйлийг хяналтын дор хүргүүлэх, гааль, тагнуул, цагдаагийн байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах, сургах, дадлагажуулах зорилгоор “Суваг-1” арга хэмжээг зохион байгуулж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн гэмт хэргийг илрүүлж ажилласан.

Зураг 3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тусгай чиг үүргийн байгууллагуудын алба хаагчид

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тусгай чиг үүргийн байгууллагуудын алба хаагчдад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таних, илрүүлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Төрийн Департаментын хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” гэрээний хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын



Хар тамхитай тэмцэх газрын албан хаагчдаас бүрдсэн сургагч багш нар 2024 оны 05, 06 дугаар сард Сэлэнгэ аймгийн “Сүхбаатар”, “Алтанбулаг” боомт, Дорнод аймгийн “Хавирга”, “Баянхошуу” боомтод ажиллаж буй хил хамгаалах байгууллага, гадаадын иргэн, харьяатын байгууллага, Гаалийн байгууллагын албан хаагчдад хүн худалдаалах болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чадавх бэхжүүлэх сургалт тус тус зохион байгуулж, нийт 120 алба хаагч хамруулсан.



Сүхбаатар аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 425 дугаар анги, ШШГЕГ-ын харьяа 413, 429, 421, 417 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Зэвсэгт хүчний 189 дүгээр анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын баривчлах байр, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтэс, Дотоодын цэргийн 05, 810, 809 дүгээр анги, Тээврийн цагдаагийн албаны Хамгаалалтын хэлтэс, Баянзүрх дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Сүхбаатар боомт, Дорнод аймгийн Хавирга, Баянхошуу боомтуудын хил, гааль, тагнуулын байгууллагын нийт 958 алба хаагч нарт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, хууль зүйн хариуцлага” сэдэвт танхимын сургалтыг 35 удаа зохион байгуулсан.

2.2. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хуулийг дагаж батлагдах шаардлагатай зарим журмыг боловсруулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 215 дугаар тогтоолоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам”-ыг баталсан.

2. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2024 оны А/60, А/40 дүгээр хамтарсан тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-ыг баталсан.

3. Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн баталсан.

4. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан.

5. Гадаад харилцааны сайдын 2024 оны А/71 дүгээр тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан.

